

Dr. med. P. Nymadawa
Ulan - Bator
Central Post, P.O.B. 596
MONGOLIA

Dr. Dambadar
P. Nymadawa



Ангaax уxaан

3

1983

АНАГААХ УХААН

ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ ЯАМ

13 дахь жилдээ

№ 3 (47)

1983 он

Эрдэм шинжилгээ практикийн улирал тутмын сэтгүүл

Dr. med. P. Nyudawa

Ulan - Bator

Central Post, P. O. B. 596

MONGOLIA

АГУУЛГА

Эмнэлгийн бүх шатны боловсон хүчний ажлын хариуцлага
сахилгыг дээшлүүлье 3

ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Г. Зэст, Ч. Цэрэннадмиц, В. Я. Бобылев — Хэрлэг төст үений үрэвсэлтэй өвчтөний поликлиникин нөхцөлд диспансерлах нь	6
Ш. Сүхбат — Эрүүлийг хамгаалах байгууллагуудын эдийн засгийн судалгаа шинжилгээ	9
Б. Саарал — Жирэмсэн эмэгтэй, иярай хүүхдэд тавих хамтын хяналт	11

СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ

Ц. Бундан, О. Бадамцэрэн — Артерийн битуурээгүй цоргын мэс заслын эмчилгээ 13	
Ж. Хасболд, П. Нямдаваа — В гепатитийн вирусийн гадаргуугийн эсрэг-төрөгчийг гельхроматографийн аргаар цэвэрээр ялгасан нь	16
С. Ямаахай — Зүрхний мэс засал хийхдэд цусны ширхэглүүртөрөгчийн холбогдол	20
Г. Цогт, В. Р. Зиц — Улаанбаатар хотын хүн амын уушгины төрөлхийн гаж хөгжлийн судалгаа	23
М. Сүхбаатар — Уушгины цочмог үрэвслийн үеийн цус бүлэгнэлтийн өөрчлөлт 25	
Г. Дэжээхүү — Цусны даралт ихсэх өвчний эмнэлзүйн илрэлээр өвчтөний тавиланг тодорхойло	28
М. Отгон — Хэт авиаагаар оношлох асуудалд	33

МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛГӨӨ, ЛЕКЦ, ТОЙМ

Ш. Баяртготх — Хэрлэг төст үений үрэвслийн үед үенд стероид гармон хийж эмчлэх	36
Д. Сүхээ — Эх барих эмэгтэйчүүдийн практикт алганы хээний шинжилгээний ач холбогдол	39
Л. Бадамханд — Үхамсырын мөн чанар ба түүний үүсэл гарал	44
П. Онхуудай — Гамма камерын оношилгоо	46
С. Сонин — Хэт авиаагаар оношлох арга	49
Б. Одонхүү — Уушгины цочмог үрэвслийн үе шат, хүндрэлийн зэргийг тодорхойлох, эмчлэх	51
З. Мэндсайхан — Амьсгалын эрхтэний урвалж чанарын асуудалд	54
Д. Алимаа — Билирубин	55
Ц. Жамбалдорж, Х. Гэлэгжамц — БронхоФиброСкопийн шинжилгээ, эмчилгээний арга	58
— Лабораторийн аюулгүйн дүрэм	59

ТУРШЛАГА СОЛИЛЦЬЁ

Г. Дэмид, Н. Хуяг — Нөхөн сэлбэх эмчилгээнд алло ясыг бэлтгэж хэрэглэх нь	53
Ж. Идэр — Цээжний хөндийд хос катетер тавих эмчилгээний арга	64
Д. Малчинхүү — Уушгины үрэвслийн бүрдмэл эмчилгээнд гепариныг хавсран хэрэглэх нь	67
С. Дорж — Кесар огтлол хийх арга техник	70
З. Норсмаа — Эмэгтэйчүүдийн бэлиг эрхтэний хорт хавдар өвчний эмчилгээний ерөнхий зарчим	73
Г. Гэндэнжамц — Ходоодны арагт үрэвслийн эмчилгээний зарим хэлбэр	76

ГАДААД ОРНУУДАД

— Зөвлөлтийн эрүүлийг хамгаалахын 80-аад оны зорилт	78
---	----

МЕДИЦИНА

МИНИСТЕРСТВО ЗДРАВООХРАНЕНИЯ

Выходит с 1970 г

№ 3 (47)

1983 г

Научно-практический ежеквартальный журнал

СОДЕРЖАНИЕ

Повысим ответственность и дисциплину медицинских кадров ... 3

ОРГАНИЗАЦИЯ, ЗДРАВООХРАНЕНИЯ

Г. Зэст, Ч. Цэрэннадмид, В. Я. Бсбылев — Диспансеризация больных ревматоидным артритом в условиях поликлиники	6
Ш. Сухбат — Экономический анализ здравоохранения	9
Б. Сарал — Совместное наблюдение за беременными женщинами и грудными детьми	11

ИССЛЕДОВАНИЯ

Ц. Еүгэл, С. Бадамцэрэн — Хирургическое лечение открытого артериального протока	13
Ж. Уасбэлд, П. Нимгэва — Выделение пограничного антигена вируса гепатита В методом гельзетографии	16
С. Ямахай — Содержание фибриногена в крови и его роль в кардиохирургии	20
Г. Цогт, В. Р. Зиц — Изучение врожденных аномалий легких у населения г. Улан-Батора	23
М. Сухэ-Батор — Изменение коагулограммы при острой пневмонии у детей	25
Г. Дэжэхү — Клиническое проявление гипертонической болезни и её прогностическое значение	28
М. Отгон — К вопросу ультразвуковой диагностики	33

ОБЗОРЫ, ЛЕКЦИИ, КОНСУЛЬТАЦИИ

Ш. Баяртогтох — Внутрисуставное лечение ревматоидного артрита стероидными гормонами	36
Д. Сухэ — Дерматологические исследования в акушерско-гинекологической практике	39
Л. Бадамханд — Сущность сознания и его происхождение	44
П. Онхудай — Применение гаммакамеры в диагностических целях	46
С. Соинин — Метод ультразвуковой диагностики	49
Б. Одонху — Определение стадии и степени осложнений при острой пневмонии и их лечение	51
З. Мэндса Йхан — К вопросу реактивности органов дыхания	54
Д. Алима — Билирубин	55
Ц. Жамбалдорж, Х. Гэлэгжамц — Диагностика и лечение с помощью бронхоскопии	58
— Правила лабораторной безопасности	59

ОБМЕН ОПЫТОМ

Г. Дэмид, Н. Хуяг — Способ консервации алло кости для костной трансплантации	63
Ж. Идер — Лечение эмпием плевры методом двойной катетеризации	64
Д. Малчинху — Применение гепарина в комплексной терапии тяжелой пневмонии у детей	67
С. Дорж — Методика и техника кесарева сечения	70
З. Норсма — С общие принципы лечения злокачественных новообразований гениталий	73
Г. Гэндэнжамц — Некоторые виды лечения хронического гастрита	76

ЗА РУБЕЖОМ

— Здравоохранения СССР: Какие проблемы предстоит решить в 80-х годах	78
--	----

ЭМНЭЛГИЙН БҮХ ШАТНЫ БОЛОВСОН ХҮЧНИЙ АЖЛЫН ХАРИУЦЛАГА, САХИЛГА БАТЫГ САЙЖРУУЛЬЯ

Эрүүлийг хамгаалах Яам эмнэлгийн боловсон хүчний ажлын хариуцлага, схилга батыг сайжруулах зорилтыг энэ онд дэвшүүлж боловсон хүчинтэй ажиллах ажиллагааг шинэ шатанд гаргах, ялангуяа дунд шатны удирдах ажилтын ажлын хариуцлагыг өндөржүүлэх, эмч ажилчдын хөдөлмөрийн сахилгыг бэхжүүлэх өндөр шаардлага тавьж, гүйцэтгэлийн хяналт шалгалт, удирдлагын арга барилыг өөрчлөн сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ авч байна.

Эмнэлгийн эмч, өжилтэн, ажилчдын ажлын хариуцлага, сахилга бат сайжирч байгаагийн үр дүнд хөдөлмөрчдийн эрүүл мэндийг хамгаалах ажилд багагүй амжилт олж байна.

Дундговь, Булган аймгийн эрүүлийг хамгаалах газар, Дорноговь аймгийн анагаах ухааны дунд сургууль, арьс өнгөний эмгэг судлалын нэгдсэн төв, II амаржих газар зэрэг байгууллагад боловсон хүчний ажлын хариуцлага, хөдөлмөрийн сахилгыг дээшлүүлэх талаар тодорхой бодлого, чиглэл, төлөвлөгөөтэй ажиллаж байгаагаас зарим үр дүнд хүрч байна.

Эмч, эмнэлгийн ажилчдын хариуцлага, сахилга батыг өндөржүүлж, бүтээлч идэвх санаачилгыг өрнүүлэх нь хүн амын эрүүл мэндийг хамгаалах ажлыг сайжруулах асар их нөөц, амжилтын уг сурвалж юм.

Гэтэл энэ нөөц бололцоо, боломжийг муу ашиглаж, боловсон хүчинтэй ажиллах явдал хангалтгүй байгаагаас зарим эмнэлгийн байгууллага, эмч, эмнэлгийн ажилчдын дотор хөдөлмөрийн сахилга зөрчих, хариуцлага алдех явдал гарч байна.

Яамны шууд харьяа эмнэлэг, урьдчилан сэргийлэх 28 байгууллагад ажлын цагийн ирцийн байдлыг 1983 оны 5 дугаар сарын 5-нд шалгаж үзэхэд шалгагдсан байгууллагуудын 264 хүн 51 цаг 27 минут ажлаас хожимдсоны гадна ажлын цагаас 30 минут өнгөрөөд байхад тодорхой шалтгаан нь мэдэгдэхгүйгээр 64 хүн ажилдаа ирээгүй байсан байна. Улсын клиникин төв эмнэлэг, хавдár судлалын төв, хүүхдийн клиникин төв эмнэлэг, эрүүл ахуй, халдварт, нян судлалын улсын институт, хотын аптекуудыг удирдах конторын эмч ажилчин 14—30 хүн ажлаас 5 цаг 15 минутаас 7 цагаар хожимдож байжээ.

Энэ бол эмнэлгийн удирдлага эмч, ажилтан ажилчдад хөдөлмөрийн сахилгын талаар тавих шаардлага, хяналт муу, түүний ач холбогдлыг дутуу үнэлж байгаатай холбоотой юм.

Адил нөхцөлд ажиллаж байгаа эрүүлийг хамгаалах газар, эмнэлгийн байгууллагын ажлын үр дүн харилцан өдилгүй байгаа нь тэнд ажиллаж байгаа эмч, мэргэжилтэн ажилчдын ажлын хариуцлага, санаачилга, сахилга, зохион байгуулалтаас хамаарч байна.

Дархан хотын эрүүлийг хамгаалах газар хөдөлмөрчдийн эрүүл мэндийг хамгаалах, социалист аж төрөх ёсыг хэвшүүлэх талаар хотын нам, улс олон нийтийн байгууллагын санаачилга, туслалцааг өр-

нүүлэн ажиллаж үр дунд хүрч байхад зэргэлдээх Эрдэнэт хотын эрүүлийг хамгаалах газрын эмч, ажилчдын ажлын хариуцлага, хөдөлмөрийн сахилга хангалтгуй байна.

Шалгалтын материалаас үзэхэд гоц аюулт халдварт өвчнийг эсэргүүцэн судлах газар, биобэлдмэл цусны үйлдвэр шинжилгээний институтын зарим удирдах ажилтан, мэргэжилтний хариуцлага, сахилга сүл, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэхгүй, дуулгаваргүй хандах, социалист өмч хөрөнгөнд хайр гамгүй хандсан зэрэг хариуцлагагүй явдал гарсан байна.

Муу ажиллагаатай нэг байгууллага, хөдөлмөрийн сахилгыг баримталдаггүй хариуцлага, хүмүүжлийн дöголдолтой нэг эмч ажилчны хортой зуршил үйл ажиллагаа эрүүлийг хамгаалах системийн хамт олны амжилт нэр хүндэд хар толбо суулгаж, ёс суртахууны хор хохирол учруулж байна.

Хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах дээд зэргийн хариуцлагатай хүнлэг ариун үйлст архичйн, хүмүүжлийн дöголдолтой хүн ажиллах ёс суртахууны үндэс байхгүй.

Эрүүлийг хамгаалах систем, хамт олны ололт амжилт, нэр хүндийг ариун тунгалаг байлгах эрхэм үүрэг эмнэлгийн байгууллага, эмч, ажилчин хэнд боловч ногдож байна.

Эмнэлгийн хамт олон гагцхүү өндөр зохион байгуулалт, хариуцлага сахилгатай баймааж нийгмийн өмнө хүлээсэн энэ үүргээ нэр төртэй биелүүлж чадах болно.

Эмч, эмнэлгийн ажилчдын ажлын хариуцлага, сахилгыг дээшлүүлэх талаар дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд юуны өмнө эрүүлийг хамгаалахын удирдах ажилтан, эмч, мэргэжилтний ажил хариуцах хариуцлага, удирдлагын арга барилыг дээшлүүлж, хөдөлмөрийн сахилгыг бэхжүүлж, шаардлагыг өндөржүүлэх хэрэгтэй.

Нам засгийн тогтоол шийдвэр, Эрүүлийг хамгаалах Яамны гаргасан тушаал, даалгавар, заавар, зөвлөмж бол эрүүлийг хамгаалахын зохион байгуулагч, эмч, ажилтан, ажилчдын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр юм. Түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих, биелэлтийг бүрэн хариуцах явдал тэдний албан үүрэг мөн.

Гэтэл удирдлагаас өгсөн үүрэг даалгавар болон яамны тушаал шийдвэрийг биелүүлэх ажилд өнгөц хандах, биелэлтийг эргэж тайллагнахгүй дутагдал зарим эрүүлийг хамгаалах газар, эмнэлгийн байгууллагад узэгдсээр байна.

Эмч, эмнэлгийн ажилтны хариуцлага, хөдөлмөрийн сахилгыг дээшлүүлэхийн тулд:

— Эмнэлгийн байгууллага, эмч, ажилчин бүр гэмт хэрэг, зөрчилгүй үйлчилгээний дöголдолгүй байгууллага, хамт олон болох үүрэг авахын хамт 1—2 эмнэлэг салбараар бусад байгууллага хамт олныг уриалж үүрэг авахуулж хөдөлмөрийн сахилгыг бэхжүүлэх явдалд хамт олны идэвх санаачилга, оролцоог өрнүүлж ажиллах нь чухал.

— Эмнэлгийн байгууллага бүрт халамжлан хүмүүжүүлэх зөвлөл, хэсэг байгуулж яамнаас баталж гаргасан зааврын дагуу ажилуулж ахмадын хувьсгалт дайчин, хөдөлмөрч ухамсар хүмүүжлээр хамт олныг хүмүүжүүлэх, даалгасан ажлыг хийж бүтээхийн төлөө өндөр хариуцлага хүлээж ажилладаг хөдөлмөрийн ухамсартай сахилгыг тогтоох хэрэгтэй.

— Хууль, хяналтын байгууллагатай хамтран хууль сурталчлах сарын ажил явуулах, эмч, ажилган ажилчдын хууль эрхийн мэдлэгийг дээшлүүлэх хичээл, лекц яриа хийх, мэдлэгийн шалгалт авах, үдэшлэг, уулзалт зохиох зэрэг олон хэлбэрийн системтэй ажил зохионол зохино.

— Эмч, ажилтан, ажилчдын ажил үүргийн хуваарийг боловсронгуй болгох, шинэчлэх, хүн бүрийн хийх хариуцах ажлыг нь мэдүүлж ойлгуулах, ажлын цагийн үргэлжлэх хугацаанд хийж бутээж байгаа зүйлийн ур дун, чанар, хэмжээг шалгаж тооцож байвал зохино.

Зөвхөн ажлын цагийн ирц, завсарлага, таралтыг буртгэх төдийгөөр шаардлага хангагдахгүй бөгөөд нэгж цагийн хөдөлмөрийн бутээмжийг байнга тооцож байх явдал гол зүйл юм.

Ийм учраас цагийн буртгэлийг сайжруулахын зэрэгцээ цаг ашиглагах технологийг үйлдвэрлэлийн сахилгыг бэхжүүлэх талаар эмнэлгийн байгууллагууд онцгой анхаарч дэс дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлвэл зохино.

Эмч, эмнэлгийн ажилчдын ажлын хариуцлага, хөдөлмөрийн сахилгыг бэхжүүлэх гол хөшүүрэг бол гүйцэтгэлийн хяналт, шалгалтыг үр дүнтэй хийх явдал юм.

Эмнэлгийн байгууллагуудад хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж эхлэхдээ эмнэлгийн дарга-өрөнхий эмч өглөө бүр эмч, ажилтан ажилчдынхаяа ирцийн мэдээг авч хяналт тавьдаг байвал зохино. Энэ нь хамт олонд хир шаардлага тавьж тэднийг хөдөлмөрт хэрхэн хандуулж буй хэмжүүр болно.

Эмчлэн сэргийлэх байгууллагын үйл ажиллагаа, эмч, ажилчдын ажлын хариуцлага, хөдөлмөрийн сахилгыг тогтмол хугацаанд шалгаж байхаар хяналт шалгалтын нэгдсэн график, төлөвлөгөө гаргаж мөрдөн ажиллах хэрэгтэй.

Эрүүлийг хамгаалахын зохион байгуулагч, удирдах ажилтан бүржилд ажлын цагийн 30 хувиас доошгүйг нэгж байгууллагад ажилласан байх шаардлагыг өөртөө тавьж сар тутам тооцож, дүгнэж байх хэрэгтэй. Эмчилгээ үйлчилгээний ажлыг өдөр тутам мэдэж байхаар ажлаа зохион байгуулах хэрэгтэй.

Нэгж байгууллагын гүнд орж хүнээ таньж судлах, тулж ажиллахын оронд конторт сууж цаг алдаж зарим эмч ажилчдаа танихгүй, ажил амьдралыг нь мэдэхгүй, сайн муу талыг нь судлаагүй илэн длангүй ярилцдаггүй дутагдлыг арилгах ёстой.

Ажлаар доголдож байгаа нэгж байгууллага, тасаг, хэсэг, гэмт хэрэг зөрчилд орж болзошгүй эмч, ажилчдын судалгaa буртгэлийг шинэчлэн хамт олны батлан даалтанд өгөх, ганцаарчлан ажиллах, хуулийн зөвлөлгөө өгүүлэх, сайн талыг нь дэмжиж туслах зэргээр тэдэнтэй ажиллах ажлыг эрс сайжруулбал зохино.

Зарим байгууллагад ажлаас хожимдог, эрт явдаг, ажлын цагаар хий дэний суудаг, сэлгүүцдэг, ажлын цаг ашиглалтын талаар шаардлага тавихад дургүйцдэг, элдэв тайлбар тавьдаг цөөн хүн байна.

Ийм хүмүүсийг хамт олны хараа хяналтанд авч засч, хүмүүжүүлэхэд онцлон анхаарах хэрэгтэй. Ажлын цагийн ашиглалтыг сайжруулах тухай МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Ю. Цэдэнбалын 9 дүгээр албан даалгавар, МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1971 оны тогтоол болон „Үнэн“ сонини 1983 оны 105 дугаарт нийтлэгдсэн МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Намын хянан шалгах хорооны дарга Б. Дэжидийн бичсэн „Хөдөлмөрийн сахилгыг бэхжүүльье“ өгүүллийг эмч ажилтан бүрээр дахин судлуулж дүгнэлт хийлгэж ажиллавал зохино.

Өндөр хариуцлага, сахилга, зохион байгуулалтыг тогтоохын төлөө тэмцэл бол эрүүлийг хамгаалах ажлыг сайжруулах талаар намаас дэвшүүлсэн зорилтыг бүрэн дүүрэн хэрэгжүүлэх, эмчлэн сэргийлэх ажлын чанар, үр нөлөөг дээшлүүлэх гол хөшүүрэг болж байна.

Ийм учраас эмч, ажилчдын хариуцлага, сахилгыг намаас тавьж байгаа зорилтын хэмжээнд хүргэх нь эрүүлийг хамгаалах нийт байгууллага, эмч, ажилтан ажилчдын өнөөгийн гол зорилт болж байна.

ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

г. зэст, ч. цэрэннадмид, в. я. бобылев.

ХЭРЛЭГ ТӨСТ ҮЕНИЙ ҮРЭВСЭЛТЭЙ ӨВЧТӨНИЙГ ПОЛИКЛИНИКИЙН НӨХЦӨЛД ДИСПАНСЕРЧЛАХ НЬ

АНАГААХ УХААНЫ ДЭЭД СУРГУУЛЬ

Диспансерчлалт бол өвчтэй хүнд үзүүлэх эмнэлгийн тусlamжийн орчин үеийн хамгийн боловсронгуй сайн арга юм. Сүүлийн жилүүдэд энэ арга улам их ач холбогдолтой бэлсоор байгаа бөгөөд хэрлэг төст үений үрэвсэлтэй өвчтөний хувьд бол бүрч чухал болж байна. ЗХУ зэрэг анагаах ухааны тэргүүний хөгжилтэй орны туршилагаас үзэхэд хүн амд хэрлэгийн төрлийн өвчтэй хүмүүст үзүүлэх эмнэлгийн тусlamжийн системийг бий болгож, диспансерчлах үйлчилгээний аргыг амьдралд нэвтрүүлсний үрээр дахилтын тоог мэдэгдэхүйц бууруулж, ийм өвчтэй хүмүүсийн амьдрах хугацааг уртасган, хөдөлмөрийн чадварыг сэргээж. хугацааг нь нилээд хэмжээгээр сунгаж чадсан байна. Тухайлбал зурхний хэрлэг судлалын төв, кабинетуудыг зохион байгуулж диспансерчлалтыг өргөн явуулсны үрээр Ярослав мужид 10 жилийн дотор хэрлэг өвчний дахилтыг 3 дахин бууруулж чадсан юм. Эрт оношлон, диспансерчлалтыг идэвхтэй явуулж тодорхой үе шаттайгаар эмчлэхэд хэрлэг төст үений үрэвсэлтэй өвчтөний 75 хувийг нилээд удаан хугацаагаар хөдөлмөрийн чадвартай болгож бэлдог байна. [1] ЗХУ-ын Анагаах ухааны академийн хэрлэг судлалын институтын ажилтнуудын судалгаанаас үзэхэд хэрлэг төст үений үрэвсэлтэй өвчтөнийг 15—19 жил диспансерийн хараанд байлгаж эмчилснээр 2/3-д нь өвчний идэвхжилт буурч, 70—80% нь хөдөлмөрийн чадвартай болжээ [2].

Харин БНМАУ-ын хүн амьг диспансерчлах асуудал ялангуяа хэрлэг төст үений үрэвсэлтэй өвчтөний хувьд шийдвэрлэгдэж хараахан чадаагүй байгаа юм.

Энэ асуудал ихээхэн чухал байгаа нь юуны өмнө үе мөчний өвчин нилээд их хэмжээгээр байгаатай холбоотой юм. Үе мөчний өвчиний дотор хэрлэг төст үений үрэвсэл голлодог бөгөөд олон тооны судалгаанаас үзэхэд насанд хүрэгчдийн 0,5—0,8%-д тохиолддог байна. Уг өвчний нийгмийн хор холбогдол нь түүний түгээмэл байдлаар хязгаарлагдахгүй, бас зогсолтгүй даамжран газар авсаар өвчтөнийг ихээхэн тахир дутуу болгодогт оршино.

ЗХУ-ын Анагаах ухааны академийн хэрлэг судлалын институтын судалгаагаар хэрлэг төст үений үрэвслийн улмаас поликлиникт үзүүлсэн өвчтөний 20 гаруй хувь нь тахир дутуу байжээ.

БНМАУ-ын хувьд Шастины нэрэмжит клиникийн III эмнэлгийн эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комиссын (ЭХМК) мэдээгээр уг үрэвслийн улмаас тахир дутуугийн группэд орсон өвчтөн, уул комиссоор тахир дутуугийн группэд орсон өвчтэний дотор 1976 онд 0,6%-ийг эзэлж байсан бол 1980 онд 6%-ийг эзлэх болжээ. Хэрэв хэрлэг төст үений үрэвсэлтэй өвчтөнд өвчний бур эхний үеэс нь үе шаттай эмчилгээ тогтмол удаан хугацаагаар хийж чадвал 5—6 жилийн үечилсэн эмчилгээний туршид бүх өвчтөний 95% нь хөдөлмөрийн чадвараа бүрэн хадгалж чаддаг байна (2).

Гэтэл Улаанбаатар хотын болон бусад хот, хөдөөний поликлиники, амбулаториид хэрлэг төст үений үрэвсэл болон ер нь үе мөчний бусад өвчнийг эрт оношлох, өвчтөнийг амбулаторт, поликлиникийн хэмжээнд нарийн буртгэж, диспансерийн хараанд авах ажил хангалтгүй байна.

Өвчний учир тахир дутуу болох нь анагаах ухা�ан, биологийн талаас гадна нийгмийн хөдөлмөрийн хүчиний нөөцөнд шууд нөлөөлдөг тэдгийг анхаарах ёстой. Ийм учраас хэрлэг төст үений үрэвсэлтэй өвчтөнийг цаг алдалгүй тогтмол эмчлэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ маш чухал болох нь ойлгомжтой байна. Эдгээр зорилтыг биелүүлэхэд юуны өмнө өвчтөнийг эрт илрүүлэх нь чухал. Уг үрэвслийг оношлоход Америкийн хэрлэг судлаачдын холбооноос гаргасан оношилгооны шалгуурууд хамгийн өргөн хэрэглэгдэж байна. Тэдгээрийн дотроос практикийн эмч нарын ажиллагаанд ашиглахад хялбар, боломжтойг нь ялгавал:

1. Өглөөгүүр бие хөшүүн байх
2. Үе мөчөө хөдөлгөхөд наад зах нь нэг үенд өвчтэй байх юм уу эсвэл барьж үзэхэд хөндүүр байх (үүнийг эмч тогтооно).
3. Бага гэхэд нэг үений хавийн зөвлөн эд хавантай байх юмуу эсвэл үений хөндийд нэвчдэс шингэн хурсан байх (үүнийг эмч үнэлэн тогтооно).
4. Бага гэхэд мөчний нэг үе овойх (үүнийг эмч тогтооно), үений 2 удаагийн эмгэг үзэгдлийн хоорондын зайд З сараас хэтрээгүй байна.
5. Хоёр талын ижил үе (симметрээр) хавдах (үүнийг эмч тогтооно). Хэрэв их бие талын (проксимал) фаланг (шивнүүр) хоорондох, мөн алга-фалангийн хоорондох үе, өлмийн үе гэмтсэн байвал заавал хоёр талд ижил (симметр) байх албагүй. Харин хурууны үзүүр талын үе гэмтэх нь энэ шалгуурт тохирохгүй.
6. Үений тэнийх талын ясны овгор дээрх арьсан дор юм уу үе хавийн арьсан дор булдруу бий болох. (үүнийг эмч тогтооно).
7. Үений хэрлэг төст үрэвслийн өвөрмөц рентген өөрчлөлт гарах, үүнд зөвхөн дегенерац өөрчлөлт биш, гэмтэлтэй үенд наад зах нь гэвэл ясны нягтрал үүссэн байна. Харин дегенерац өөрчлөлт хэрлэг төст үений үрэвслийн онцшиг угүйсгэхгүй.
8. Хэрлэг төст өвчнийг үүсгэх хүчин зүйл байна.

Эдгээр шалгуурын аль нэг нь байвал уг үрэвслийн талаар онцгой анхаарч шинжилгээг гүнзгийрүүлбэл зохино.

Сүүлийн үед хэрлэг төст үений үрэвслийн эмчилгээнд үечилсэн арта голлож байгаа бөгөөд түүний дотроос амбулаторын эмчилгээ чухал юм. Ялангуяа өвчний эрт шатнаас нь эхлэн байнгын диспансерчлалтад хамруулбал илүү үр дүнтэй.

Хэрлэг төст үений үрэвсэлтэй өвчтөнийг диспансер, поликлиникийн нөхцөлд эмчлэх нь больницаад эхэлсэн эмчилгээний үргэлжлэл байх ёстой. Энэ шатанд дараах арга хэмжээг авч явуулбал зохино. Үүнд:

1. Поликлиникт эмчилгээг хийхдээ бэльницаад эхлэн хийсэн эмчилгээг үргэлжүүлэх байдлаар заавал удаан нөлөөтэй эмүүд хэрэглэх хэрэгтэй. Үүнд: хинолины төрлийн эмүүд (хлорохин), резохин, делагил, плаквенил), мөн үрэвслийн эсрэг сгероидын бус эмүүд (аспирин, бутидион, индометацин, вальтарен г. м.) хэрэглэх бөгөөд өвчтөн бүрт тохирох тун, эмчилгээг үргэлжлүүлэх хугацааг диспансерийн ажиглалтын явцад тогтоохын зэрэгцээ бие махбодод уул эмүүдийн таарч байгаа эсэхийг хянаж байх ёстой.

2. Архаг халдвартын голсмыг эмийн болон мэс заслын аргаэр эрүүлжүүлнэ.

3. Физик. эмчилгээ, эмчилгээний гимнастик, иллэг зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч явуулна.

4. Диспансерийн ажиглалтын уед хэрлэг өвчний явц өндөр идэвхтэй юмуу эсвэл засрахгүй ужиг, амбулаторын эмчилгээ ур дун өгөхгүй байх зоргийг харгалзан өвчтөнийг больницид дахин хэвтүүлэх шаардлагатай эсэхийг тогтооно.

5. Өвчтөний хөдөлмөр зохицуулалтын асуудлыг зөв шийдэж арай хөнгөн ажилд шилжүүлнэ. Рашиан сувилалд явуулж эмчилнэ.

Диспансерийн ажиглалтын явцад өвчтөнийг З сард нэг удаа, хэрэв өвчин хурдан даамжрах явцтай байвал 1—2 сар тутамд давтан шинжилгээ хийнэ.

Хэрлэг төст үений үрэвсэлтэй өвчтөний эмчилгээнд рашаан эмчилгээ чухал зайлшгүй нэг шат нь байх ёстой. Энэ шатны эмчилгээний зорилго больниц, поликлиникт хийсэн өмнөх 2 шатны эмчилгээний ур дунг бэхжүүлэх, цусны эргэлт, бодисын солилцоог сайжруулах зэрэг өвчтөний бие махбодыг ерөнхийд нь тэнхрүүлэх улмаар үе мөчний уйл ажиллагааг сайжруулах явдал юм.

Рашаан сувиллын эмчилгээ дотор эрхтэний үрэвсэлгүй, өвчиний зөвхөн үений хэлбэрийн уед, өвчин хурцаагүй идэвхгүй шатанд юмуу эсвэл идэвх хамгийн бага байгаа, үений ажиллагааны дутагдал I-II зэргээс ихээгүй уед шаардлагатай. Өвчиний эрт шатанд уул эмчилгээг хийвэл хамгийн ур дунтэй байдаг.

Рашаанд сувилах уед өвчтөнд урьд нь сонгон тохируулсан эмийн эмчилгээг зогсоолгүй үргэлжлүүлэх ёстой. Рашиан сувиллын газар шавар-усан эмчилгээг эмтэй хослооос гадна бас эмчилгээний гимнастик, иллэгийг өргөн хэрэглэх нь уг үрэвслийн хам эмчилгээний маш чухал хэсэг юм. Энэ нь үе, булчингийн уйл ажиллагааг сэргээнэ.

Рашаан сувилалд төрөл бүрийн физик эмчилгээг өргөн хэрэглэнэ. Ийнхүү хам эмчилгээг нарийн ялгаатайгаар тохируулан хийж чадвал рашаан сувиллын эмчилгээний шатааас урт удаан хугацааны сайн үр дунд хүрч болно.

Үений өвчтэй өвчтөнийг аль болохоор эрт илрүүлэн өвчиний оношлогох хамгийн зохистойгсor диспансерчлах боловсронгуй хэлбэр бол ЗХУ-ын туршлагаас үзэхэд үе-мөчний эмгэгтэй өвчтөнийг үзэж, үйлчлэх нарийн мэргэжлийн тусгай үзлэгийг зохион байгуулах явдал юм. Иймээс БНМАУ-д хэрлэг судлалын төв, поликлиникийн дэргэд хэрлэг судлалын кабинет бий болгож, хүн амд энэ талаар үзүүлэх тусламжийн нэгдмэл системийг зохион байгуулах шаардлагатай байна.

Хэрлэг төст үений үрэвсэл болон ер нь хэрлэгийн төрлийн өвчтэй хүмүүсийг эрт илрүүлж, диспансерийн хяналтанд авч, эмчилгээ урьдчилан сэргийлэлтийн зөв зохистой аргыг зөв зохион байгуулж чадвал эдгээр өвчиний идэвхийг бууруулж, хөдөлмөрийн чадвар түр алдалтын хугацааг бодиносгож өвчтөний тахир дутуугийн группд орохыг багасган, улмаар улс ардын аж ахуйн хөдөлмөрлөх хүчний нөөцийг нэмэгдүүлэх нэгэн боломжийг бий болгох юм.

Ашигласан хэвлэл

1. Сафонов А.Г. Вопросы ревматизма. 1979, № 3, 6
2. Трофимова Т.М. Полянская И.П. Суровцева В. М. и др. В кн: Вопросы реабилитации при ревматических заболеваниях.. М., 1979, 80.

ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГУУДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ТЕХНИКУМ

Эрүүлийг хамгаалах салбарт оруулж байгаа улсын төсвийн зардал өсөн нэмэгдэхийн хамт түүний нийгэм эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, хөрөнгийг хамгийн зохицой хэлбэрээр ашиглах явдал чухал юм. Эрүүлийг хамгаалах салбарт арвилан хэмнэлтийн зарчмыг бүтээлчээр хэрэгжүүлэн зарцуулж байгаа төгрөг мөнгө нэг бүрийн үр ашгийг тооцон харуулахад эдийн засгийн судалгаа чухал үүрэгтэй. Судалгаагаар үр ашгийг харуулаад зогсохгүй цаашид авах арга хэмжээг төлөвлөнө. Эрүүлийг хамгаалахын эдийн засгийн судалгааг ажлын зохион байгуулалтыг сайжруулах, үр ашиг багатай зарцуулж байгаа үзүүлэлтэй багасгах, арвилан хэмнэх журмыг нэвтрүүлэх, дотоод нөөц бололцоог бүрэн дүүрэн ашиглах, машин тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах, материалын нөөцийн нормыг хатуу баримтлахад чиглүүлэн зохион байгуулна.

Эдийн засгийн судалгааг улсын төлөвлөгөөний биелэлт, зардлын гүйцэтгэл хоёрыг уялдуулан холбож явуулна. Иймд төлөвлөгөөний биелэлтийг судалж түүний шалтгааныг илрүүлэн гаргасны дараа төсөвлөгдсөн зардлын гүйцэтгэлийг түүнтэй холбон судална.

Судалгаанд нягтлан бодох, статистик, шуурхай бүртгэлийн тоо мэдээллийг ашиглана. Тайлангаар гарсан орны фонд ба ор-хоногийн ашиглалтын судалгааг хийе.

Хүснэгт I.

Орны фонд ба ор-хоногийн ашиглалтын судалгаа

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл	
		оны эцэст	дундаж	оны эцэст	дундаж
1	Ашиглаж байгаа нийт ор	120	125	130	130
2	Ор хоног	38400	40625	42900	46900

Нийт ор төлөвлөгөөт дунджаас 15 ороор (140—125) илүү ашиглаж төлөвлөгөө 112 хувиар биелэгдсэн байна. Энэ нь жилийн дундуур шинээр тасаг нээж ажиллуулсан ба нэмэгдэл ор тавьж ашигласантай холбоотой. Үүнийг тасаг тус бүрээр өвчлөлийн байдалтай холбон судалж болно. Ор-хоногийн төлөвлөгөөг дунджаар ашиглахаар тооцож төлөвлөснөөс 6275 ор хоног (46900—40625) илүү ашигласан байна. Энэ нь орны тоо 15-аар нэмэгдсэнээс (40625—125×15) 4875 ор-хоног, нэг орны ашиглалт 10 өдрөөр нэмэгдэж (46900 : 140—40625 : 125×140) 1400 ор-хоног илүү ашигласнаас тус тус нөлөөлжээ.

Ор хоногийн ашиглалтын байдлыг цаашид улсын ба орон нутгийн ижил больнициын дундажтай харьцуулан судална. Ор ашиглалтын болон эмнэлэг үйлчилгээний ажлын чанарын нэг чухал үзүүлэлт бол орны ашиглалт буюу эргэц юм. Ор хоногийн төлөвлөгөө давж биелэгдсэн ч гэсэн орны ашиглалт-эргэц удааширсан байвал нэг өвчтөнийг олон хоногоор хэвтүүлж эмчлэх, цаашилбал ор хоногийн төлөвлөгөөг

биелүүлэх зорилгоор хүмүүст үр дүнтэй тодорхой эмчилгээ хийхгүй удаан хугацаагаар хэвтүүлэх хандлага гардаг. Иймд эргэцийг хэдэн жилээр буюу төлөвлөгөөт хэмжээтэй харьцуулан судална. Нэг орон дээр жилд хичнээн хүн эмчилсэн буюу нэг өвчтөн хичнээн өдөр хэвтэж эмчлүүлсэн болохыг энэ үзүүлэлтээр тооцож тодорхойлдог. Үүнийг тооцоходо нийт ор-хоногийн тоог хэвтэж эмчлүүлсэн өвчтөний тоонд хуваана. Жишээ нь: Нэгдсэн эмнэлэгт тайлангийн жилд давхардсан тоогоор 2930 хүн хэвтэж эмчлүүлсэн гэвэл ($46900 : 2930$) нэг өвчтөн дунджаар 16 өдөр эмчлүүлсэн байна. Гэтэл төлөвлөгөөт ороор тооцоход 2950 өвчтөн хэвтэж эмчлүүлэхээр байсан гэвэл 1 өвчтөн 14 өдөр хэвтэж эмчлүүлэх байжээ. Төлөвлөгөөнөөс нэг хүн 2 өдөр илүү хэвтэж эмчлүүлсэн байна. Нэг орон дээр жилд төлөвлөгөөгөөр ($40625 : 125 : 14$) 23 хүн хэвтэж эмчлүүлэх ёстойгоос гүйцэтгэлээр ($46900 : 140 : 16$) 20 хүн хэвтэж эмчлүүлсэн нь төлөвлөгөөт боломжит хэмжээнээс даруй 3 хүн дутуу байна. Өөрөөр хэлбэл энэ больницын хэмжээгээр (140×3) 420 хүн нэмж хэвтүүлж эмчлэх боломж алдсан байна.

Одоо ор-хоногийн төлөвлөгөөний биелэлтэй эм, хоолны зардал болон бусад материалын зардлыг нэг ор-хоногт ногдох зардлаар судалж узье.

Эм ба хоолны зардлын судалгаа

Хүснэгт 2.

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэлт хэтрэлт
1.	Эм ба боох материалын зардал	260 000	408030	-148030
2.	Хоолны зардал	207 187	225120	-17,933

Нийт зардлын хэтрэлт хэмнэлтэд нэллээлсэн хүчин зүйлийг тооцохын тулд орны зардлыг дараах хүснэгтээр тооцьё.

Нэг ор-хоногийн эм хоолны зардлын судалгаа

Хүснэгт 3.

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэлбэлзэл (+, -)
1.	Ашигласан ор хоног	40625	46900	+6275
2.	Нэг ор хоногт зарцуулсан эмийн зардал	6—40	8—70	-2—30
3.	Нэг ор хоногт зарцуулсан хоолны зардал	5—10	4—80	-0—30

Эмийн зардал төлөвлөсөн хэмжээнээс хэтрэхэд 2 хүчин зүйл нөлөөлнө. I-рт ор-хоногийн төлөвлөгөөний биелэлт, 2-рт нэг ор-хоногт ногдох зардлын өсөлт юм. Үүнийг тооцвол ор-хоногийн төлөвлөгөө 6275 ор-хоногоор давсанаас 40160 төгрөг ($6275 \times 6 = 40$)-өөр хэтэрчээ. Нэг ор-хоногт зарцуулах норм 2 төгрөг 30 мөнгөөр хэтэрсэнээс эмийн нийт зардал 107870 төгрөг ($46900 \times 2 = 30$)-өөр хэтэрсэн байна.

Хоолны зардал ор-хоногийн төлөвлөгөөний биелэлтийн улмаас 32,0 төгрөгөөр хэтэрч, нэг ор-хоногийн хоолны зардал 30 мөнгөөр хямдарснаас 14,1 төгрөг хэмнэгдсэн байна.

Цалингийн фонд, орон тооны төлөвлөгөөний биелэлтийг судалъя.

Цалингийн фондын судалгаа

Хүснэгт 4.

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хэлбэлзэл (+, -)
1.	Эмнэлгийн нийт ажилчдын орон тоо	120	116	-4
2.	Жилийн цалингийн фонд	589,6	509,5	-80,1
3.	1 ажилчны жилийн дундаж цалин	4913	4393	-520

Цалингийн фондыг 80,1 мянган төгрөгөөр хэмнэхэд ажилчдын тоо, цалингийн фонд 80,1 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна. Энэ нь орон тоо дутуу ажилласнаас $19,72 (4913 \times 4)$ төгрөг, дундаж цалин төлөвлөгдсөнөөс 520 төгрөгөөр багассанаас 60,3 мянган төгрөг (520×116) тус тус нөлөөлсөн байна,

Эмнэлэг үйлчилгээний зардлыг ингэж судлахаас гадна үндсэн фондын ашиглалтыг машин тоног төхөөрөмжийн ашиглалтын үзүүлэлт цаг, эмчлүүлсэн өвчтөний тоо зэрэг үзүүлэлтээр судална.

Б. СААР АЛ

ЖИРЭМСЭН ЭМЭГТЭЙ, НЯРАЙ ХҮҮХДЭД ТАВИХ ХАМТЫН ХЯНАЛТ

III АМАРЖИХ ГАЗАР

Манай нам, засгаас эх нялхсын эрүүл мэндийг сахин хамгаалах талаар авч явуулж байгаа олон тал арга хэмжээний үр дүнд эх, нялхсын өвчлөл, эндэгдэл буурч нийт хүн амын эрүүл мэндийн үзүүлэлтүүд жилээс жилд сайжирч байна. Гэвч манай эх нялхсыг хамгаалах төрөлжсөн байгууллагуудын зохион байгуулалт, урьдчилан сэргийлэлт, эмнэлэг үйлчилгээний ажлын цар хүрээ, чанар өнөө үеийн өсөн нэмэгдэж буй шаардлагыг хангахад хараахан хүрэхгүй байгааг МАХН-ын Төв Хорооны 1979 оны 21 дугээр тогтоолд онцлон тэмдэглэсэн билээ. Нам засгийн тогтоол шийдвэрийг өөрсдийн практик үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэгжүүлэхэд манай эх нялхсыг хамгаалах төрөлжсөн байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах асуудал чухлаар шаардагдаж байна.

Жирэмсэн эмэгтэйчүүд ба нярай хүүхдийг ЗХУ, ах дүү социалист бусад орны туршлагаар эх барих, эмэгтэйчүүд, хүүхдийн эмч нараас хамтран хянадаг „Хамтын хяналт“ -ын аргыг манай орны нөхцөлд бүтээлчээр хэрэгжүүлэхэд дараах зүйлүүдийг хийх зүйтэй юм.

1. Эх барих эмэгтэйчүүд, хүүхдийн хэсгийн эмч, эргүүлийн сувилагч нараас жирэмсэн эхчүүд, нярай хүүхдэд хамтын хяналт тавихын тулд эх барих-эмэгтэйчүүд ба хүүхдийн хэсгийг аль болохоор хооронд нь ойролцоо байрлуулан, эмэгтэйчүүд хүүхдийн эмч нар ажиллагаагаа нягт уялдуулан харьяалсан дэвсгэр нутгийн жирэмслэх наасны

эмэгтэйчүүдийн дэлгэрэнгүй бүртгэлийг гаргаж тэдний гэр орны нөхцөл, ахуй хангамж, хоол ундны дэглэм зэргийг нарийвчлан судлах шаардлагатай.

Үүний зэрэгцээ сарын тэмдгийн хуанлийг нарийн хөтлүүлж, хугацаандаа ирээгүй тохиолдолд цаг алдалгүй үзлэг хийн, жирэмсэн буюу өвчтэй эсэхийг тодруулах хэрэгтэй юм.

Ингэснээр жирэмснийг эрт хугацаанд нь илрүүлэн жирэмсэн эмэгтэйн бие ургийн өсөлт бойжилтыг аль болох эртиээс хянаж урьдчилан сэргийлж ажилласнаар жирэмслэлт, төрөлтийг хэвийн явуулж, тээж төрүүлэх хүүхдийн эрүүл байх нөхцөлийг хангах болно.

Хүүхэд төрмөгц төрөх газар. эмэгтэйчүүдэд зөвлөлгөө өгөх тасаг энэ тухай харьяа хүүхдийн хэсэгт мэдээлж, хүүхдийн хэсгийн эмч нар нярай хүүхэд хүлээн авах эрүүл ахуйн бэлтгэлийг гэр оронд нь урьдчилан ханггуулсан байх шаардлагатай.

2. Мөн жирэмсэн эмэгтэйчүүдийг хүүхэд, эх барих-эмэгтэйчүүдийн хэсгийн эмч нар хамтран хянаж уг жирэмсэн эмэгтэйн хөдөлмөр, амьдралын ахуйн нөхцөлийг хэвийн байдлаар хангахад зөвлөж туславал зохино.

3. Амаржих газрын нярай хүүхдийн эмч нар төрөлтийн болон нярайн эрт үед хүүхдийн биед гарсан бага боловч өөрчлөлтийг гярхай ажиглан эмчилж, амаржих газраас хүүхдийг гэрт нь гаргах үедээ тодорхой солилцох хуудсаар хэсгийн эмч наарт хүлээлгэн өгч байхаас гадна хүүхдийн больницод шилжсэн нярайг хэсгийн эмч наарт нь мэдээлдэг ж урам тогтоох нь зүйтэй.

4. Амаржих газрууд нь эхчүүдэд нярай хүүхэд. эрүүл өсч бойжих орчны эрүүл ахуйн шаардлага, нярай, хүүхдийн арчилгаа сувилаа, хооллолт, элдэв өвчлөлөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөлгөө өгсөн байх ба эдгээр зарчмыг хүүхдийн хэсгийн эмч, сувилагч нар гэр орны нөхцөлд хэрэгжүүлэхэд нь хяналт тавьж ажиллана.

5. Дээрх байгууллагын эмч ажилчид эмчилгээ урьдчилан сэргийлэх ажлынхаа уялдааг аль болох ойртуулахад идэвх санаачилга гарган бие биедээ шурхай мэдээлэн, хамтран ажиллахын зэрэгцээгээр хөдөлмөрчдийн ахуй соёлыг сайжруулах, эрүүлийг хамгаалах болон бусад хслбогдох хууль тогтоомжийг таниулан ойлгуулж, тэдгээрийг хэрэгжүүлэх ажилд слон түмэн (гэр булийн гишүүд)“-ийг ухамсартай идэ вхтэй орслцуулах нь чухал байна.

Ийнхүү байгаа бололцоогоо бүрэн ашиглаж, үр бүтээлтэй хамтран ажиллаж чадвал эмчилгээ урьдчилан сэргийлэх ажлын чанар улам сайжирч, эх хүүхдийн өвчлөл эндэгдэл тууштай буурахад багагүй нөөц бололцоо бай гаа мэт санагдана.

СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ

Ц. БУНДАН О. БАДАМЦЭРЭН

АРТЕРИЙН БИТҮҮРЭЭГҮЙ ЦОРГЫН МЭС ЗАСЛЫН ЭМЧИЛГЭЭ

НЭГДСЭН III ЭМНЭЛЭГ

Артерийн битүүрээгүй цорго нь зүрхний бусад төрөлхийн гажиг дотроос нилээд элбэг тохиолдог эмнэлзүйн шинж тэмдэг, хүндрэл нь эрт илэрдэг гажиг юм. 1958 онд манай оронд анх энэ гажгийг мэс заслын аргаар эмчилснээс хойш 192 хүнд уул мэс заслыг хийгээд байна. Үнээс 4 өвчтөнд arterийн битүүрээгүй цоргыг дахин хаах мэс засал хийсэн юм. Иймээс бид arterийн битүүрээгүй цоргыг мэс заслын аргаар эмчлэх, түүний үр дүнг тодорхойлох зорилгоор уул гажиг бүхий 120 хүнд судалгаа хийж, материалыг статистикийн аргаар боловсруулав.

Судалгааны материал. Бид зүрхний цахилгаан бичлэг, зүрхний авиа дууны бичлэг, поликардиографи, цээж гэрэлд харах, спирографи, зүрх сэтгүүрдэх зэрэг хам шинжилгээний тусламжтайгаар (1—2) онош тогтоож, нэгээс дээш насны хүмүүст насны хязгаар харгалзахгүйгээр уушгины arterийн даралт гол судасны даралттай тэнцсэн буюу их болсноос бусад бүх тохиолдолд уг гажгийг засах мэс заслын эмчилгээ хийсэн юм. Мэс заслыг хийхдээ arterийн битүүрээгүй цоргыг орчныхы нь зөвлөн эдээс сайтар болгоомжтой ялгаад хоёроос гурван удаа зангидах боох, хоёр боолтын дундуур оёх, тасалж, оёх оёгч аппаратаар (УАП—20) оёх, arterийн битүүрээгүй цорго үрэвслийн шинжтэй байвал жийргэвчтэй нэмэлт боолт хийх зэрэг олон аргыг амжилттай хэрэглэж байна.

Хүснэгт 1.

Хийсэн мэс заслын хэлбэр

№	Хагалгааны нэр	Ажиглалтын тоо	Хувиар
1	Хоёр зангидах боох	35	81
	Гурав зангидах боох	46	
2	Нэг удаа оёж боох	56	91
	Хоёр удаа оёж боох	35	
3	Цус тогтоох губк	13	6,9
	хэрэглэж боох	7	3,6
4	Тасалж боох	192	100,0%
	БҮГД		

Arterийн битүүрээгүй цоргыг дахин боох мэс засал нилээд онцлогтой. (5, 6) Үүнд, арын зүсэлтээр цээжний хөндийг нээж гол судас, уушгины arter, arterийн битүүрээгүй цоргыг орчныхы нь эдээс ялгаад arterийн битүүрээгүй цоргын хоёр төгсгөлөөр бүдүүн тортон утсанд авч цус алдалтаас сэргийлж тус цоргыг дээр өгүүлсэн аргын

аль нэгээр, ихэвчлэн тасалж боох аргаар мэс засал хийдэг. Мэс заслын эмчилгээний үед цус алдах хүндрэл нэг хүнд тохиолдсон боловч яаралтай цус сэлбэж цоргын цус алдсан хэсэгт жийргэвчтэй оёдол тавьж цусыг тогтоов. Түүнчилэн мэс заслын эмчилгээний дараахь амьсгалын замын хүндрэл 5 хүнд ажиглагдсанаас нэг өвчтөнд цагаан мөгөөрсөн хоолойд гуурс суулгасан бусад тохиолдолд эмийн эмчилгээ хийсний үр дүнд хүндрэлийг бүрэн арилгав.

Хүснэгт 2.

Мэс заслын дараахь угдрэл

хүндрэл	өвчтөний тоо		
	хагалгааны үед	хагалгааны дараа	хувь
1. Цус алдалт	I	=	0,8
2. Уушгины ателектаз	=	1	0,8
3. Ларингит	=	2	1,7
4. Уушгины хатгалгаа	=	2	1,7
БҮГД	1	5	5

Зарим судлаачдын судалгаагаар хагалгааны дараахь үхлийн хувь 1—1,5 байхгэд манай энэ ажиглалтаар 0,8% байна. (3—4)

Түүнчилэн хагалгааны үед уушгины артер, артерийн битүүрээгүй цорго, гол судасны даралтыг шууд хатгалтаар Мингограф—42 дээр бичиж тухайн үед мэс заслын эмчилгээний аргыг сонгон авсан нь артерийн битүүрээгүй цорго дахин онгойх хүндрэл гаргахгүй байх чухал нөхцөлийг бүрдүүлж байна.

Бид мэс заслын эмчилгээний үр дүнг хагалгааны ойрын үед, хагалгааны дараахь 4—21 хоногт судалсан юм. Үүнд, 42 өвчтөнд хагалгааны үед даралт үздэг махир зүүг уушгины артерид байрлуулж артерийн битүүрээгүй цоргын гол судас талынхыг боож, уушгины артерийн даралтыг үзэхэд 0,6—0,9 Кла-аар буурсан, уушгины артерид то-дорхойлогддог доргион бүрэн арилсан чагнахад агшилт суралтын шуугиангүй болж, системийн бага даралт 4 Кла-аар нэмэгдэн хэвийн байдалд орсон. Түүнчилэн хагалгааны дараахь 3—4 өдрөөс өвчтөний биенийн байдал сайжирдаг. Мөн хагалгааны дараахь 14—21 хоногт 20 өвчтөнд поликардиографийн шинжилгээ хийж үзүүлэлтийг хагалгааны өмнөх үеийнхтэй харьцуулбал асинхрон агшилт, Блюмбергийн коэффициент хэвийн болсон ба бусад үзүүлэлт нь хагалгааны өмнөх үеийнхтэй ижил байлаа.

Поликардиографийн үзүүлэлт

Хүснэгт 3

Үзүүлэлтүүд	Хагалгааны өмнө M±m	Хагалгааны дараа M±m
Асинхрон агшилт	0,054±0,003	0,05±0,006
Изометрийн агшилт	0,08±0,007	0,07±0,004
Хүчдэлийн үе	0,14±0,01	0,2±0,0089
Механик агшилт	0,35±0,0345	0,34±0,001
Ерөнхий агшилт	0,37±0,009	0,34±0,008
Блюмбергийн коэффициент	2,35±0,32	2,88±0,34
Агшилтын дотоод үзүүлэлт	82,8±0,01	88,8±0,34
Миокардийн хүчдэлийн индекс	45,0±0,42	44,7±0,04
Диастол	0,78±0,07	0,40±0,099

Хагалгааны дараах 21—28 хоногт гадаад амьсгалыг судалж үзэхдэд амьсгалын тоо хэвийн болсон, хүчилтөрөгчийн шингэлтийн тоо нэмэгдсэн, минутын эзэлхүүн, хүчилтөрөгчийн ашиглах коэффициент өөрчлөгдөөгүй харин уушгины амьдралын эзлэхүүн, амьсгал авах, гаргах нөөц эзэлхүүн, багассан нь ажиглагдлаа. Гадаад амьсгалыг уг гажгийн үе шаттай харьцуулан үзэхэд гажгийн I, II үед хагалгааны дараах 14—16 хоногт үзүүлэлтүүд хэвийн болох хандлагатай байхад, гажгийн III—IV үед удаан хугацаанд өөрчлөлтүүд хэвээрээ байна. Иймээс хагалгааны дараах хожим үед (6 сар түүнээс дээш) уг мэс заслын эмчилгээ хийлгэсэн хумуусийн бие махбодод эргэн сайжрах үзэгдэл хэрхэн явагддагийг дээрх хам шинжилгээний аргаар судалж тодорхойлох зорилт бидний өмнө тавигдаж байна.

ДҮГНЭЛТ. 1. Артерийн битүүрээгүй цоргыг мэс заслын аргаар эмчлэх нь уул гажгийг засах шилдэг, үр дүн сайтай арга юм.

2. Мэс заслын эмчилгээний дараах ойрын хугацаанд (21 хоногийн дотор) поликардиограф, спирографийн шинжилгээний зарим үзүүлэлт хэвийн болох боловч ихэнх үзүүлэлт хагалгааны өмнөх үеийнхтэй ижил байгаа нь тус гажгийн үед уушгины судас болон зүрхэнд морфологийн нилээд гүнзгий өөрчлөлт гардгийг харуулж байна. Иймээс ийм гажигтай хүүхдэд мэс заслын тусламжийг аль болс хыгаа нийэнд үзүүлэх нь чухал ач холбогдолтой юм.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Т. Шагдарсүрэн, С. Загдаа, Ц. Бундан, Р. Пүрэв—Зүрх судасны гажгийн клиник оношийн асуудалд. ШУА мэдээ сэтгүүл. 1971, 71—73.
2. Т. Шагдарсүрэн—Зүрхний гажгууд тэдгээрийн онош, эмчилгээ. 1972, 81—88.
3. Н. В. Архангельская Гемодинамические нарушения при ОАП и отдаленные результаты его М. 1971, 168.
4. Куприянов П. А., Бурмистров М. И., Кутушев Ф. Х., Мишура В. И. Причины неблагоприятных исходов хирургического лечения некоторых врожденных пороков сердца. Хир. 1960, 3—9.
5. Лебедев С. А. Приступии Ч. В.—Техника операции при НАП. Минск 1973, 91—96.
6. Малиновский Н. Н., Константинов Б. А.—Повторные операции на сердце. М., 1980, 160.

ХИРУРГИЧЕСКОЕ ЛЕЧЕНИЕ ОТКРЫТОГО АРТЕРИАЛЬНОГО ПРОТОКА

Ц. Бундан, О. Бадамцерен

Приходятся материалы обследования 120 больных с незаращением артериального протока для установления более оптимального метода хирургического лечения данного порока и результаты его. В условиях МНР с 1958 г успешно применялись такие методы, как двух и трехкратная перевязка протока, перевязка с ушиванием между ними рассечение протока с ушиванием концов последнего и перевязки с использованием прокладки, ушивания протока с помощью ушивающего аппарата УАН—20.

Изучены результаты хирургического лечения с помощью электрокардиографических, фонокардиографических, поликардиографических, рентгенографических исследований и зондирования сердца.

Ж. ХАСБОЛД П. НЯМДАВАА

В ГЕПАТИЙН ВИРУСИЙН ГАДАРГУУГИЙН
ЭСРЭГТӨРӨГЧИЙГ ГЕЛЬХРОМАТОГРАФИЙН АРГААР
ЦЭВРЭЭР ЯЛГАСАН НЬ

ШУА-ИЙН ЕРӨНХИЙ БА СОРИЛЫН БИОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН
ЭРҮҮЛ АХҮЙ, ХАЛДВАР, НЯН СУДЛАЛЫН УЛСЫН ИНСТИТУТ

Лейкеми өвчтэй австраль хүний цусны ийлдсэнд Б. Бламберг нарын (4) анх илрүүлсэн өвөрмөц эсрэгтерөгч нь ийлдэст гепатитийн үед цусны ийлдсэнд байнга тодорхойлогддогийг олж тогтоосноор (20) вируст гепатитийн судалгаанд шинэ үе эхэлсэн билээ.

Цасидын судалгаа нь Австраль эсрэгтерөгч бсл хожмоо Дэйний биенцэр нэр авсан В гепатитийн вирусийн (5) суперкапсидын бурэлдэхүүний хэсэг юм гэдгийг хөдөлгөөнгүй тогтоосон тул 1977 онд ДЭХБ-ын экспертийн бүлэг уг эсрэгтерөгчийг В гепатитийн вирусийн гадаргуугийн эсрэгтерөгч ($\text{HBs}-\text{Ag}$ —Hepatitis B surface antigen) гэж нэрлэх зөвлөмж гаргасныг (24) одоо нийтээр баримтлах болжээ.

$\text{HBs}-\text{Ag}$ нь вирины бүрэлдэхүүнд орохоос гадна дангаараа 15—25 нм хэмжээтэй $2,4-4,6 \times 10^6$ дальтон молекул жинтэй бөмбөлөг буюу савхангар сицийг үүсгэдэг ажээ. (10)

Вируст гепатитийг ялган сношлох оношуул бэлтгэх болон В гепатитаас сэргийлэх вакцин хийхийн тулд $\text{HBs}-\text{Ag}$ -ийг их хэмжээгээр, цэврээр гарган авах шаардлага гардаг. В гепатитийн вирусийн бутцийг нарийвчлан судалснаар $\text{HBs}-\text{Ag}$ -ийн гол детерминантыг нийлэг аргаар гарган авах (7,12), уг эсрэгтерөгчийг нийлэгжүүлэгч гепатомын эсийн өсгөвөр өшиглэх (3,21), $\text{HBs}-\text{Ag}$ -ийг хариуцсан вирусийн генийг E. coli-д суулгах (19) зэрэг шинэ аргуудыг бичиж байгаа хэдий боловч $\text{HBs}-\text{Ag}$ -ийг гарган авах гол эх сурвалж нь $\text{HBs}-\text{Ag}$ агуулсан хүний цусны ийлдэс байсаар байна. $\text{HBs}-\text{Ag}$ агуулсан хүний цусны ийлдсэнээс $\text{HBs}-\text{Ag}$ -ийг цэврээр ялгахын тулд хэт хурилдуурдах (8,14), иммунхроматографийн (11), полимержуулсан гльобумин глиглэсэн аффин-хроматографын (18) болон полиэтиленгликолиор шат дараалан тундасжуулах (6, 15, 17) аргуудыг хэрэглэдэг байна. Сүүлийн үед судлаачид дээрх аргуудын заримыг хослуулан хэрэглэж сайн үр дүнд хүрэх болжээ. (9, 16, 22, 23)

Бид тус орны өвөрмөц нөхцөлд тохирсон $\text{HBs}-\text{Ag}$ -ийг цэврээр ялгах арга боловсруулахын тулд уургийн молекулуудыг молекул жинтэй нь ялгадаг гельхроматографийн аргын хувилбаруудыг ашиглан $\text{HBs}-\text{Ag}$ -ийг хүний цусны ийлдсэнээс цэвэрлэх цуврал туршлага хийсэн юм. Бидний боловсруулсан аргаар $\text{HBs}-\text{Ag}$ -г харьцаангуй цэврээр ялган авч болох бөгөөд эцсийн бүтээгдэхүүний цэвэршилтийн зэрэг нь бусад аргаар ялгасан $\text{HBs}-\text{Ag}$ -тай дүйхүүц юм гэдгийг туршлагын үр дүн харуулав.

Материал, арга зүй

$\text{HBs}-\text{Ag}$ -ийн эх үүсвэр Угтвар иммунэлектрофорезийн аргаар (13) $\text{HBs}-\text{Ag}$ илрүүлсэн эрүүл донорын болон эрүүл эхийн эхсийн цусны ийлдсийг хэрэглэв.

Ийлдсийг туршлаганд хэрэглээгүй үед -40°C -т хадгалж байв. Полиэтилен-гликоль-оор тундасжуулах 6000 дальтон жинтэй полиэтилен-гликоль (ПЭГ)—(Sigma Chemicals Co., USA) ашиглан Внек нарын (23) боловсруулсан аргыг хялбарчлан хэрэглэв. Үүнд: тодорхой хэмжээний $\text{HBs}-\text{Ag}$ эерэг ийлдсийг хэмжин авч давсны хүчлээр pH

4,6 болгоод; 30% ПЭГ-ээс эцсийн түвшрүүлэг 2% байхаар тооцоолон дуслаар нэмээд -10°C -т 30 мин байлгав. Дараа нь $+4^{\circ}\text{C}$ -т 3000 хурдтай 30 мин хурилдуурдаж, тундсыг хаяад тундсын дээр эцсийн түвшрүүлэг 4,5% байхаар дахин 30% ПЭГ нэмж, -10°C -т 30 мин байлгав. Мөн $+4^{\circ}\text{C}$ -т 3000 хурдтайгаар 30 мин хурилдуурдаж, тундсын дээр шингэнгийг хаяад тундсыг ийлдсийн анхны эзлэхүүний 1/10—1/20-тэй тэнцэх хэмжээний нэрсэн усанд уусгав. Гарсан уусмалаас -ПЭГ ийн улдэгдлийг G-50 Molselect (Hungary) гельд хроматографлаж салгав.

Гель-хроматограф 0,15 M NaCl-тай 0,01 M Трис-HCl (PH 7,6) буферт тэнцвэржүүлсэн Биогель A5 м (Bio-Rad Ladoratories Co., USA) марькийн 200—400 меш хэмжээтэй агарозин гелийг хэрэглэв. Уг гелийтг 2 x 75 см хэмжээтэй колонконд угсарч, 1—5 мл материалыг 8 мл/цаг хурдтайгаар хроматографлав.

Фракцуудыг 40 дуслаар хураав.

Ургийн хэмжээг тодорхойлох гельхроматографын фракцуудад бол 280 нм долгионы урттай хэт ягаан туюаны шингэлтээр, бусад тохиолдолд биуретийн нийтлэг аргаар тодорхойлов.

HB_s-Ag ба ийлдсийн өвөрмөц уургийт илрүүлэх дээ угтвар иммунэлектрофорез (13) болон завсрлын гельтэй нийлмэл иммунэлектрофорезийн (1) аргыг хэрэглэж, хүний ийлдсийн уургуудын эсрэг гахайн эсрэг бие (SwAHu) ielfo-SERYAC, Chekoslovakia), Эрүүл ахуй, халдварт, нян судлалын улсын институтэд гарган авсан (2) HB_s-Ag-ийн эсрэг ямааны эсрэг биеийг ашиглав.

ҮР ДҮН, ШҮҮМЖК: Эхний цуврал туршилтыг 10^4 — 10^6 молекул-жинтэй ургийн молекулуудыг өөр хооронд нь ялгах чадвартай гелиэр HB_s-Ag эерэг 1,0 мл цусны ийлдсийн хроматографлаж хийв.

Энэ туршлагын дүнгээс үзэхэд ийлдсийн нийт уураг 3 фракц болон салж байв. (Зураг 1). Завсрлын гельтэй нийлмэл иммунэлектрофорезоор HB_s-Ag-ийн тархалтыг үзэхэд 31—40 дэх фракцид буюу ургийн эхний 2 фракцийн хооронд гарч байлаа. Гэвч нэг удаагийн ялгалтанд оруулах ийлдсийн ачааллыг нэмэгдүүлэхэд HB_s-Ag бүхий фракц дахь бусад ургийн хэмжээ ихэсч байсан учир энэхүү нэг шатат гель-хроматографын арга нь HB_s-Ag-ийг их хэмжээгээр гарган авахад тохиромжгүй байлаа.

Тиймээс гельхроматограф хийхээс өмнө цусны ийлдсээс бусад ургийг зайлцуулж, HB_s-Ag-ийн хэмжээг ихэсгэх нэг шат нэмэх шаардлагатай болов. Энэ зорилгоор бид ПЭГ-ээр урьдчилан тундасжуулах аргыг (23) хэрэглэв.

ПЭГ-ээр хоёр шаттайгаар тундасжуулахад туршлаганд авсан ийлдэсний нийт ургийн 87% нь, нийт HB_s-Ag-ийн 20% орчим нь хаягдаж, HB_s-Ag-ийн өвөрмөц идэвх 6 дахин ихсэв (Хүснэгт 1).

4,5% ПЭГ-ээр тундасжуулсан фракцаас ПЭГ-ийг G-50 Molselekt-ээр зайлцуулж, Биогель A-5 м (200—400 меш) гелиэр хроматографлажад 30—43 дугаар фракцид 1 : 4—1 : 512 (дунджаар 1 : 16) таньцтай HB_s-Ag ялгарав. (Зураг 2)

HB_s-Ag агуулсан фракцуудын нийлбэр уургийн хэмжээ 3,6 мг/мл болсон нь өмнөх шатны уургийн хэмжээнээс 30 дахин бага болжээ.

ПЭГ-ээр тундасжуулсны дараа HB_s-Ag-ийг гельхроматографаар цэвэрлэсэн 2 шатны ерөнхий үзүүлэлтийг үзвэл (Хүснэгт 2), ажилбарын явцад анх авсан сорьцын уургийн 99,1% нь хаягдаж, эцсийн бүтээгдэхүүн дэх HB_s-Ag-ийн өвөрмөц идэвх нь 62,8 дахин ёсчээ. Энэ нь HB_s-Ag-ийг цэвэрлэж, ётгөрүүлсэн бусад судлаачийн үзүүлэлтээс (6, 15, 22, 23) муугүй байна.

ДҮГНЭЛТ. 1. HB_s-Ag эерэг хүний цусны ийлдсээс бага хэмжээний HB_s-Ag-ийг гельхроматографын аргаар цэврээр ялгаж болох юм.

2. Гельхроматографаар ялгах HB_s-Ag-ийн гарцыг нэмэгдүүлэхийн тулд ПЭГ-ээр урьдчилан тундасжуулах нь тохиромжтой.

Хүс нэгт 1

Цусны ийлдсээс HBs-Ag-ийг ПЭГ-ээр тундасжуулсан үзүүлэлт

Фракцууд	Хэмжээ (мл)	Ургийн хэмжээ (мг.мл)	HBs-A хэмжээ (урвуу таньц)
Анх авсан ийлдэс	100	82	4
20% ПЭГ-ээр тундасжуулсан дараахь шингэн	90	73	6
20% ПЭГ тундас	10	71	0
4,5% ПЭГ ээр тундасжуулсан дараахь шингэн	95	47	0
4,5% ПЭГ тундас	10	106	32

Хүснэгт 2

Цусны ийлдсээс HBs-Ag-ийг ПЭГ-ээр урьдчилан тундасжуулсан дараа гельхроматографаар цэвэрлэсэн үзүүлэлт

Сорилын материал	Хэмжээ (мл)	HBs-Ag хэмжээ (урвуу таньц)	Ургийн хэмжээ (мг.мл)	Өвөрмөц идэвх	Цэвэрлэсэн зэрэг
Анх авсан ийлдэс	100	6	82	0,07	1,0
ПЭГ-ээр тундасжуулсан фракцii	10	32	106	0,3	4,3
Гель-хроматографийн HBs-Ag эерэг фракцийн нийлбэр	20	16	3,6	4,4	62,8

1. Урвуу таньц


ургийн хэмжээ — томъёогоор бодож гаргав.

2. Сорыцын өвөрмөц идэвх

анх авсан ийлдсийн өвөрмөц идэвх — томъёогоор гаргав.

3. ПЭГ-ээр тундасжуулсан материалаас 3 мл авч Г-50 гелиэр ПЭГ улдэгдлээс салгахад 5 мл болтол шингээрснийг биогелиэр хроматографлахад гарсан хэмжээ.


Зураг 1



HB_s-Ag-ээрэг цусны ийлдсээс гельхроматографын аргаар HB_s-Ag-ийг цэвэрлэсэн нь.

Зураасаар ургийн ерөнхий хэмжээг 280 nm урттай гэрлийн долгионы шингээлтээр, ташуу шугамтай дөрвөлжнээр HB_s-Ag-ийн өвөрмөц идэвхийг тус тус тэмдэглэв.

Зураг 2



Цусны ийлдсээс ПЭГ-ээр урьдчилан өтгөрүүлсэн материалыас HB_s-Ag-ийг гельхроматографаар цэвэрлэсэн нь.

Зураасаар уургийн ерөнхий хэмжээг (1 : 3-аар шингэлсэн) 230 нм урттай гэрлийн долгионы шингээлтээр, ташуу зураастай дэrvолжнөөр HB_s-Ag-ийн таныцыг угтвар иммуунэлектрофорезоор тодорхойлсныг тус тус тэмдэглэв.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Аксельсон, Н., Крэлль, Й, Вееке, Б. Руководство по количественному иммуноэлектрофорезу, М., 1977. 216
2. Нимадава, П., Пуревдава, Э. и др. Получение и апробация гипериммунной диагностической сыворотки против HBs-Ag, В кн.. Тезисы докладов третьей научно-практической конференции "Актуальные вопросы вирусологии"; У-Б., 1982. 18—19;
3. Abey, D. P. et al., Controlled synthesis of HBs-Ag in a differentiated human liver carcinoma-derived cell line, *Nature*, (1979). 282 ; 615;
4. Blumberg, B. S., Alter, H. J., Visnick, S.: A new antigen in leukemia sera, *J. Am. Med. Ass.*, (1965): 191 : 541;
5. Dane, D. S., Cameron, C. H., Briggs, M.: Virus-like particles in serum of patients with Australia-antigen-associated hepatitis, of patients *Lancet*, (1970) 1 : 695;
6. Derizzo, E. et al.: Concentration and purification of hepatitis B antigen With polyethylene glycol and polyelectrolyte 60, a cross-linked copolymer of isobutylene maleic anhydride, *Infect. Immun.* (1972), : 5 : 213;
7. Dreessman, G. R. et al.: Antibody to hepatitis B surface antigen after a single inoculation of uncoupled synthetic HBs-Ag peptides, *Nature* (1982):295 : 158;
8. Gerin, J. L. et al.: Australia antigen: large-scale purifi-cation from human serum and biochemical studies of its proteins, *J. Virol.* (1971):, 7 : 569;
9. Gerlich, W. H. et al.: Structural relationships between the surface antigens of ground squirrel hepatitis virus and human hepatitis B virus, *J. Virol.* (1980) : 36 ; 787;
10. Hoofnagle, J. H.: Hepatitis B surface antigen and antibody, In: *Virus and the Liver*, Eds. L. Bianchi, W. Gerok et al., MTP Press Ltd.. Lancaster, (1980) pp. 27—37;
11. Howen, S. et al.: The use of an immunosorbent in the isolation of Australia antigen, *Vox Sang.* (Suppl.): (1973) 114—122;
12. Lerner, R. A. et al.: Chemically synthesized peptide predicted from the nucleotide sequence of the hepatitis B virus genome elicit antibodies reactive With the native envelope protein of Dane particles, *Proc. Natl. Acad. Sci. U.S.A.*, (1981) 78 : 3403;
13. Maynard, J. E. et al., Laboratory techniques for the detection of hepatitis B surface antigen, Atlanta, 95 pp.;
14. Mishiro, Sh. et al. (1980): A 49,000-daltonpolypeptide bearing all antigenic determinants and full immunogenicity of 22-nm hepatitis B surface antigen particles, *J. Immunol.* (1977) 124 : 1589;

15. Nath, N. et al.: Purification of hepatitis B surface antigen using polyethylene glycol, pepsin and Tween-80, Vox Sang, 31 (Suppl.) (1976): 84;
16. Neurath, A. R. et al.: Large-scale purification of hepatitis B surface antigen using affinity chromatography, Experientia (1978) 34 : 414;
17. Neurath, A. R. et al.: Hepatitis B antigens: separation of two populations differing in particle size distribution, Proc. Soc. Exp. Biol. Med. (1973) 143 : 440;
18. Neurath, A. R., Strick, N.: Affinity chromatography of HBs-Ag from e-antigen-positive sera on insolubilized cross-linked albumin, Arch. Virol. (1979), 60 : 79;
19. Pasrk, M. et al.: Hepatitis B virus genes and their expression in E. coli, Nature (1979) 282 : 575;
20. Prince, A. M.: An antigen detected in the blood during the incubation period of serum hepatitis, Proc. Natl. Acad. Sci. USA, 1968 60 : 814;
21. Skelly, J. et al.: Hepatitis B surface antigen produced by a human hepatoma cell line, Nature, (1979) 282: 617;
22. Vnech, J. et al.: Association of normal serum protein antigens with chimpanzee hepatitis B surface antigen particle, J. Med. Virol. (1978) 2: 319;
23. Vneck, J., Prince, A. M.: Large scale purification of hepatitis B surface antigen, J. Clin. Microbiol. (1975): 3 : 626;
24. WHO Expert Committee on Viral Hepatitis: Terminology of hepatitis viruses and antigens, Intervirology: (1977), 8 : 65;

ВЫДЕЛЕНИЕ ПСВЕРХНОСТНОГО АНТИГЕНА ВИРУСА ГЕПАТИТА В МЕТОДОМ ГЕЛЬХРОМАТОГРАФИИ

Ж. Хасболд, П. Нямдава

Разработана модификация метода очистки HBs-Ag из сыворотки крови путем гельхроматографии на Биогель А-5 м (200—400 меш) с предварительной преципитацией при помощи полиэтиленгликоля 6000.

При использовании разработанной модификации удалось уменьшить общее количество белка на 99,1% и увеличить специфическую активность в 62,8 раз в конечном продукте по сравнению с исходной сывороткой.

С. ЯМААХАЙ

ЗҮРХНИЙ МЭС ЗАСАЛ ХИЙХЭД ЦУСНЫ ШИРХЭГЛҮҮР ТӨРӨГЧ (ФИБРИНОГЕН)-ИЙН ХОЛБОГДОЛ

АНАГААХ УХААНЫ ХҮРЭЭЛЭН

Зүрхний мэс засалд гипотерми, цусны зохиомол эргэлтийн аппарат хэрэглэснээр цус булэгнэлтийг улам идэвхтэй судлах шаардлагатай болов. Цус булэгнэлтэд ширхэглүүр төрөгч чухал ач холбогдолтой.

Зүрхний мэс заслыг цусны зохиомол эргэлттэй хийхэд ширхэглүүр төрөгчийн хэмжээнд онцгой өөрчлөлт гарч болзошгүй учир мэс заслаас өмнө өвчтөний цус бүлэгнэх системийг сайтар шинжлэх нь зүйтэй юм.

Зүрхний төрелхийн гажгийн үед цусан дахь ширхэглүүр төрөгчийн хэмжээ онц өөрчлөгдхгүй хэвийн хэлбелзэлд (2—4 г/л) багтаж байдгийг судлаачид тэмдэглэж байна. Хэвлэлийн тоймоос үзэхэд мэс засал хийхээр унтуулсны дараа цусны ширхэглүүртөрөгчийн хэмжээ хэвийн дунджаас ялимгүй ихэсдэг ажээ. (1—5, 8—9, 12—13)

Мэс заслын байдал, үүсэн гарах хүндрэлээс шалтгаалан ширхэглүүр төрөгчийн хэмжээ янз бүрээр өөрчлөгднө. (6—7, 13) Гэхдээ гол төлөв цусны зохиомол эргэлттэй хийсэн мэс заслын эцэст ширхэглүүр

төрөгч багасна. Ийм өөрчлөлтийг судлаачид ажигласан бөгөөд цус юулэлт 30 минут үргэлжлэхэд ширхэглүүр төрөгч 53—68%-иар багасч байжээ. (3—5, 10) Үүнийг цус гепаринжуулалт хангалтгүйтэй холбон тайлбарлах ба хялгасан судасны системд өчүүхэн ширхэгтэй бүлэн үүсч ширхэглүүр төрөгчийн нөөцөд муугаар нелөөлнө. (3—4)

Цусны зохиомол эргэлтийн үед ширхэглүүр төрөгч багасч тэр нь цус өлдлөлтад хүргэх талаар судлаачдын санал зэрөөтэй байна. Ширхэглүүр төрөгчийн хэмжээ багассанаас болж цусны зохиомол эргэлтийн аппарат зогссоны дараа цус алдана гэж (2—3) зарим судлаач үзэж байхад, зарим нь өөрсдийн туршилтанд тулгуурлан харин фибрин усгагч идэвх ихэссэнээс шалтгаалан цус алдана гэж үзэж байна. (6)

Мэс заслын дараа 2—4 хисгийн дотор ширхэглүүртөрөгч болон цус бүлэгнүүлэх бусад үзүүлэлт ихсэж заримдаа эмгэг өөрчлөлтөд хүрч бүлэн үүсэх нөхцөл бүрдэх үндэстэй. (6)

Үүнийг зурхний мэс заслын дараа 4—8 дахь өдөрт цусны ширхэглүүр төрөгчийн хэмжээ 10—12 г/л болж байсантай холбон тайлбарлаж болно.

Шинжилгээний материал, ажлын арга зүй. Бид зурхний төрөлхийн белэн олдмол гажигтай 330, мэс заслын эмчилгээ хийлгэсэн 76 өвчтөнд ажиглалт хийлээ. Эдгээрийн дотор зурхний тосгуур хоорондын 53, фаллогийн гурвалсан болон дөрвөлсөн гажигтай 14, arterийн битүүрээгүй цорготой 126, хоёр хаваст хавхлагын нарийсалт олдмол гажигтай 53 өвчтөн байв.

Мэс заслын эмчилгээ хийлгэсэн 76 өвчтөнийг оношоор ялгавал arterийн битүүрээгүй цорготой 31, зурхний ховдол хоорондын цоорхойтой 12, тосгуур хоорондын цоорхойтой 17, хоёр хаваст хавхлагын нарийсалттай 16 хүн байв.

Цусны ширхэглүүр төрөгчийг R. A. Рутбергийн аргаар тодорхойлж статистикийн бсловсруулалт хийв.

Шинжилгээний дүн. Зурхний тосгуур хоорондын цоорхой төрөлхийн гажигтай өвчтөнд цусны ширхэглүүр төрөгчийн хэмжээ дунджаар $0,28 \pm 0,01\%$, ховдол хоорондын цоорхойтой өвчтөнд $0,30 \pm 0,04\%$, arterийн битүүрээгүй цорготой өвчтөнд $0,27 \pm 0,08\%$, фаллогийн гурвалсан болон дөрвөлсөн гажигтай өвчтөнд $0,20 \pm 0,002\%$, хоёр хаваст хавхлагын нарийсалт гажиг бүхий өвчтөнд $0,33 \pm 0,017\%$ тус тус байв. Үүнээс үзэхэд цусны ширхэглүүртөрөгчийн хэмжээ зурхний гажигтай өвчтөнд хэлбэлзэл багатай өөрөөр хэлбэл эрүүл хүний хэмжээнд байна. Гэвч төрөлхийн гажиг, ялангуяа фаллогийн гурвалсан болон дөрвөлсөн гажигтай зарим өвчтөний цусанд хэвийн хэмжээний доод хязгаараас доогуур байв.

Зурхний гажигаа мэс заслаар эмчлүүлсэн 76 хүний цусны ширхэглүүртөрөгчийн хэмжээ мэс заслын дараах нэг, хоёр, долоо, арван дөрөв дэх өдрийдэд өөрчлөгдөж байгааг ажиглахад arterийн битүүрээгүй цорготай өвчтөний цусанд ширхэглүүртөрөгч дунджаар $0,26 \pm 0,01\%$; $0,27 \pm 0,03\%$; $0,37 \pm 0,01\%$; зурхний тосгуур хоорондын цоорхойтой белен хоёр хаваст хавхлагын нарийсалт гажигтай байсан өвчтөнд тогтвортай нэгэн түвшинд ($0,32—0,33 \pm 0,02\%$), ховдол хоорондын цоорхой гажигтай өвчтөнд $0,42—0,40 \pm 0,03\%$ байлаа.

Цусны зохиомол эргэлтгэй мэс заслын дараах нэг, хоёр, долоо, арван дөрөв дэх өдрийдэд цусны ширхэглүүртөрөгч $0,20\%$; $0,28\%$; $0,24\%$; $0,46\%$ болж цаашид өөрчлөгдсөнгүй.

Зурхний arterийн битүүрээгүй цорго тосгуур болон ховдол хоорондын цоорхойгий, хоёр хаваст хавхлагын олдмол гажгийн үед цусны ширхэглүүр төрөгчийн хэмжээнд онцын өөрчлөлт гардаггүй тухай судлаачдын дүгнэлттэй бидний ажиглалт үндсэндээ тохирч байна. Хөхрөх шинж тэмдэг үлэмж тодорсон, зурхний гурвалсан, дөрвөлсөн гажгийн

Үед ширхэглүүртөрөгчийн хэмжээ эрүүл хүнийхээс нилээд доошур байна. Энэ нь элэгний үйл ажиллагаа хямарч биохимиин үзүүлэлт, ялангуяа цус бүлэгнэлт тухайлбал ширхэглүүртөрөгчийн хэмжээ хэдийгээр бага байсан боловч мэс заслын эмчилгээний дараа цус алдалт тохиолдоогүй ба нэгдэх өдрөөс эхлэн нэмэгдэж хэвийн байдалд орж байна.

1950—1970 оны хэвлэлд цусны зохиомол эргэлтийн үед ширхэглүүр төрөгчийн хэмжээ багасах нь аппарат зогсооны дараа цус алдалтад гарцаагүй хүргэдэг гэж бичсэн байх боловч бидний ажиглалтанд тийм тохиолдол ажиглагдсангүй. Харин гемодилюцтай, цусны зохиомол эргэлтийн үед ширхэглүүртөрөгчийн хэмжээ аппарат зогсоноос хойш асар удалгүй мэс заслын ёмнөх байдалд ойртоож байлаа.

Мэс заслын дараах нэг, хоёр, долоо, арван дөрөв дэх өдрийдэд ширхэглүүртөрөгчийн хэмжээ тогтвортой нэгэн түвшинд буюу 0,26—0,42 г%-ын хооронд байсан нь 1,0—1,2 г% байдаг гэсэн зарим судлаачдын судалгаатай тохиорхгүй байгаа юм. (6) Энэ байдлыг гемодилюцтай, цусны зохиомол эргэлтэй холбон тайлбарлаж болох талтай. Нөгөө талаар цусны зохиомол эргэлтэд гемодилюцийн аргыг хэрэглэх нь өвчтөний цусны ширхэглүүртөрөгчид нүцтой өөрчлөлт гаргахгүй байна.

Дүгнэлт. Өөрийн судалгаанд үндэслэн дор дурьдсан урьдчилсан дүгнэлт хийв.

— Зүрхний төрөлхийн гажиг тосгуур болон ховдол хоорондын цоорхой, артерийн битүүрээгүй цорго, хоёр хавтаст хавхлагын нарийсалт, олдмол гажгийн үед цусан дахь ширхэглүүртөрөгч эрүүл хүнд байх хэмжээнд байна.

— Фаллогийн гурвалсан ба дөрвөлсөн гажигтай өвчтөний цусан дахь ширхэглүүртөрөгчийн хэвийн бага хэмжээнээс багадах тохиолдол байж болно.

— Гемодилюцтай цусны зохиомол эргэлтийн үед ширхэглүүртөрөгч багасах боловч мэс заслын дараах өдрөөс хэвийн хэмжээнд орох ба мэс заслын дараах үгдрэлгүй үед хэвийн хэлбэлзэлд байна.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Залесский Г. Д. Жур. Вопр. Ревмат. 1961, № 1. 57
2. Левицкая Л. А. В кн: Вопросы патологии физиологии сердечно-сосудистой системы. М. 1963, 188
3. Уманский М. А. Пробл. гемат. и перелив. крови 1962, № 8, 46.
4. Степанян Е. П., Лагутина А. М. Жур. груд. хир. 1959, № 3, 52.
5. Степанян Е. П., Смирнская Е. М. Жур. груд. хир. 1962, № 1, 41.
6. Степанян Е. П., Геселевия Е. Л., Поспелова Е. П. В кн: Изменение метаболизма при сердечно-сосудистой патологии, 1968.
7. Терентьев Л. И. В сб. Операции на открытом сердце. 1961, 211
8. Allen J. G. Extracorporeal circulation., 1958. 231
9. Overbeck W. Thoraxchirurgie, 1960. 40. 2
10. Perkins H., Osborn S. J. lab. clin. med., 1956. 48. 223
11. Spohn K. Thoraxchirurgie, 1960. 7, 3. 228
12. Swan H. at all.. Surgery 1955. 38. 858
13. Thies H. A. Chemotherapia, 1961. 3. 4. 354

СОДЕРЖАНИЕ ФИБРИНОГЕНА В КРОВИ И ЕГО РОЛЬ В ҚАРДИОХИРУРГИИ

С. Ямахай

При операциях на сердце с экстракорпоральным кровообращением, из основных компонентов свертывающей системы крови, значительные изменения претерпевает фибриноген.

Содержание фибриногена в крови у больных с врожденными пороками сердца колеблется в пределах нормы. В частности, у больных с дефектом межпредсердной и межжелудочковой перегородки, а также незаросшим артериальным протоком уровень содержания фибриногена в крови составлял $0,28 \pm 0,01$ г%.

У больных с триадой и тетрадой Фалло отмечен низкий уровень фибриногена в крови.

Была выявлена гипофибриногенемия во время операции на сердце с искусственным кровообращением. Исследования, проведенные на 1; 7 и 14 день после операции показали, что при неосложненном течении операции в послеоперационном периоде уровень фибриногена достигает нормы.

Несмотря на низкое содержание фибриногена до операции у больных с триадой и тетрадой Фалло не наблюдалось кровотечений во время операции и после нее.

— О —

Г. ЦОГТ, В. Р. ЗИЦ.

УЛААНБААТАР ХОТЫН ХҮН АМЫН УУШГИНЫ ТӨРӨЛХИЙН ГАЖ ХӨГЖЛИЙН СУДАЛГАА

СҮРҮЕЭ УУШГИНЫ ЭМГЭГ СУДЛАЛЫН НЭГДСЭН ТӨВ

Амьсгалын эрхтэний төрөлхийн гаж хөгжлийг судалсан эрдэм шинжилгээний бүтээлүүд сүүлийн жилүүдэд олширч байна. Энэ нь нэг талаар уг эмгэг хүн амын дотор ихэсч байгаатай нөгөө талаар түүний оношилгоо сайжирсантай холбоотой юм.

Уушгини гажиг нь үр хөврөлийн ба төрсний дараахь үед үүсдэг боловч эмнэл зүйн шинж тэмдэг нь зөвхөн үрэвслээр хүндэрсэн тохиолдолд илрэдэг тул энэ нь түүний оношилгоог улам хүндруүлдэг.

БНМАУ-ын хүн амын дотор явуулсан мөгөөрсөн хоолой, уушгини төрөлхийн тажгийн судалгааны тухай мэдээлэл бидэнд тохиолдоогүй болно. Эмнэл зүй, лаборатори, рентген-томограф, бронхологийн шинжилгээний аргуудаар уушгини эмгэгтэй 1350 өвчтөний 51-д (3,8 % нь) бид төрөлхийн гажгийг оношилсон юм. Тэдний 33 нь эрэгтэй, 18 нь эмэгтэй хүмүүс байв.

Уушгини гажиг нь голдуу залуу 30 хүртэлх насны хүмүүст илэрч байв.

Өвчтөний өчгөөс үзэхэд 43 өвчтөнд энэ эмгэгийн анхны шинж тэмдэг хүүхэд, өсвөр насанд томуу, хэтгэлгаагаар өвчилсний дараа мэдэгдэж эхэлсэн, өөрөөр хэлбэл зөвхөн үрэвсэл үүссэн тохиолдолд илэрч байжээ. Харин хүндрэлгүй үед өвчтөн өөрийгөө эрүүл гэж тооцдог байснаас урьдчилан сэргийлэх үзлэгээр 8 хүнд тохиолдоор илэрсэн юм.

Бэлцруут гипоплаз—39, гуурсан бэлцруу—5, „тольдсон“ уушги—3, уушгини агенез—1, энгийн гипоплаз—1, уушгини дэлбээний гипоплаз—2 хүнд тус тус илэрч байв. Энэ судалгаанаас өмнө уушгини эдгээр гажгийг нэг ч тохиолдолд оношилж байгаагүй бөгөөд гуурсан хоолойн архаг үрэвсэл, архаг хатгалгаа, уушгини буглаа, сүрьеэ, өмөн, уушгини хатуурсан үрэвсэл, уушгинд хий тогтсон гэж эмчилж байжээ.

Уушгини бэлцруут гипоплаз нь олонтоо (76%) тохиолдож байснаас гадна эмнэл зүйн янз бүрийн шинж тэмдгээр илэрч байсан учир анхаарал татаж байв. Бэлцруут гипоплаз нь баруун уушгинд (21), Зүүнд (16), хоёуланд (2) байрлаж уушгийг бүхэлд нь 4 тохиолдолд хамаарч байсан болно. Эдгээр өвчтөн сүрьеэ (13), гуурсан хоолойн тэлэлт (9), архаг буглаа (3) гэсэн оноштойгоор олон жилийн турш эмчлүүлж байжээ.

Бусад судлаачдын болон өөрсдийн ажиглалтыг үндэслэн бид бэлцруут гипоплазыг хүндрэлгүй (5), хүндэрсэн (34) гэж 2 үндсэн хэлбэрт ангилав. Хүндрэлгүй эмгэгтэй хүмүүс нь ямар нэгэн зовиур шаналгаагүй байсан бөгөөд рентген-флюорографийн үзлэгээр илэрсэн юм.

Хүндэрсан хэлбэрийн үед идээт цэргийн ханиад (29), цээжээр өвдөх (20), биеийн ачааллын үед амьсгаадах (23), халуурах (11) зэргийн архаг үрэвслийн шинж тэмдэг илэрч байв. Гадна үзлэгээр уүшгини гажигтай тал нь 7 хүнд хавтгай болсны улмаас цээжний хэлбэр өөрчлөгдсөн байлаа.

Тогшилтын чимээний богиносолт (23), хайрцагны чимээ (6), чагнахад ширүүн амьсгал (24), суларсан амьсгал (25), хуурай хэржигнуур (16,) нойтон (21) хүнд тус тус сонсдож байв. Бэлцруут гипоплазын эмнэл зүй нь олдмол идээт үрэвсэлт өвчинтэй харьцуулбал хөнгөн явцтай байсныг тэмдэглэх нь чухгал байна. Тухайлбал, хүчилтөрөгчийн архаг дутагдлын шинж болох „бөмбөрийн цохиур“, „щагны шил“ зөвхөн 2 хүнд ажиглагдлаа.

Микробын флор нь идээт үрэвсэлт өвчинүүдийнхээс онцгой ялгаагүй байсан болно. Эмгэг төрөгч стафилококк, стрептококк, пневмококк буюу микробын холбоо ихэнх тохиолдолд тодорхойлогдож байв. 92,2% тохиолдолд микрофлор нь үндсэн антибиотикуудад өндөр тэсвэртэй байсныг энэ эмгэгтэй өвчтөнийг эмчлэхэд анхаарах хэрэгтэй юм.

Цусны талаас гарч байсан өөрчлөлтүүд нь тодорхой онцлоггүй байв. $8-12 \cdot 10^6$ хэмжээний лейкоцитоз 16 хүнд 30—40 мм СОЭ—22, нейтрофилез, протеинограммын өөрчлөлт, СРБ 18—20 хүнд тус тус ажиглагдаж байлаа.

Уүшгини бэлцруут гипоплаз нь рентген-томографийн шинжилгээгээр уүшгини эрс өөрчлөгдсөн зураглалын дэвсгэр дээр янз бүрийн хэлбэр хэмжээтэй хий бүхий хөндийнүүдээр илэрч байлаа.

Хүндэрсан үед үүнээс гадна их хэмжээний сүүдэр үүсч, зарим тохиолдолд (4) шингэний түвшин тодорхойлогдож байв. Голт нь эмгэгтэй тал руу татагдаж, ар тийш эргэсэн байлаа.

Эмгэг хэлбэрийн шинж, тархалтыг тодорхойлж оношлох гол арга нь бронхограф бөгөөд энэ шинжилгээгээр тодотгогч бодисоор дүүрсэн бэлцруут хөндийнүүд нь янз бүрийн хэлбэр, хэмжээтэй байсан ба эдгээр нь зарим тохиолдолд „Савангийн хөөс“ төстэй байв.

Бактерийн эсрэг цогцолбор эмчилгээ нь энэ өвчний хүндэрсан хэлбэрийн үед нилээд их үр дүн өгсөн юм. 26 өвчтөний биеийн байдал илт сайжирч, 8 өвчтөнд мэс заслын эмчилгээ амжилттай хийсэн болно.

Бид мөгөөрсөн бэлцруүний 5 тохиолдолд (бүх гажгийн 10%) ажиглалт хийсэн юм. Манай клиникт хэвтэхээс өмнө эдгээр өвчтөн архаг буглаа (3), цээжний гялтангийн уутлагдсан үрэвсэл (1), цээжинд хий дүүрсэн гэж эмчлүүлж байсан бөгөөд бүгдээрэнд нь мэс заслын эмчилгээ амжилттай хийсэн байна. Уүшгини төрөлхийн бусад гажгийг цөөн тохиолдолд оношилсон бөгөөд энэ нь практикийн ач холбогдол багатай боловч ялгах оношилгооны хувьд хүндрэлтэй байв.

Бидний энэ урьдчилсан судалгаанаас үзэхэд Улаанбаатар хотын хүн амын уүшгини эмгэгийн дотор төрөлхийн гажиг тийм ч цөөнгүй тохиолдож ялгах оношилгоонд нилээн их ач холбогдолтой байна. Уүшгини гажгийн эмнэл зүй нь зөвхөн үрэвслийн үед илэрдэг. Стационарт хэвтэж амбулаториор эмчлүүлж байгаа өв чөнүүдийн оношийн зөрөө нь эмч нарын мэдлэг дутмаг байгаатай холбootой юм.

Рентген-бронхологийг ба бусад шинжилгээг хэрэглэсэн халдвартархалтын зорилгот судалгаа нь хүн амын дотор амьсгалын эрхтэний төрөлхийн гажгийг илрүүлж цаг тухайд нь эмчлэх боломж олгох юм.

**ИЗУЧЕНИЕ ВРОЖДЕННЫХ АНОМАЛИЙ ЛЕГКИХ
У НАСЕЛЕНИЯ г. УЛАН-БАТОРА**

Г. Цогт, В. Р. Зин

Впервые проведен анализ 1350 историй больных, находившихся на стационарном и амбулаторном лечении в различных учреждениях г. Улан-Батора по поводу бронхолегочной патологии. Тщательная оценка анамнестических, клинических, лабораторных, рентгенотомографических, бронхологических, микробиологических и других исследований позволила у 51 (3,8%) человека диагностировать различную врожденную аномалию легких. Мужчин было 33, женщин—18, в основном молодого возраста (36). Первые симптомы заболевания у большинства больных (43) отмечались в детско-подростковом периоде и как правило, были связаны с развитием неспецифического воспалительного процесса. Наиболее частой аномалией легких были кистозная гипоплазия (39), реже встречались солитарная бронхогенная киста (5), простая гипоплазия (3) и др.

М. СҮХБААТАР

**УУШГИНЫ ЦОЧМОГ ҮРЭВСЛИЙН ҮЕЙИН
ЦУС БҮЛЭГНЭЛТИЙН ӨӨРЧЛӨЛТ**

АНАГААХ УХААНЫ ДЭЭД СУРГУУЛЬ

Хүүхдийн уушгины цочмог үрэвслийн эмгэг жамыг тал бүрээс нь нарийвчлан судлаж оношилгоо эмчилгээнд шинэ бүрдэл арга нэвтрүүлэх нь амьсгалын замын эмгэгийн өвчлөл, хүндрэл, эндэгдлийг бууруулахад чухал нөлөтэй юм.

Ялангуяа уушгины үрэвслийн үед цус бүлэгнэлт өөрчлөгдэх асуудал судалгааны эхлэл шатандай явагдаж судлаачдын дунд энэ талаар санал зөрөөтэй байна. Тухайлбал, Л. Д. Алексеевын судалгаагаар насанд хүрэгчдийн уушгины үрэвслийн үед, А. Ю. Лемберск, А.К. Табуч нарын судалгаагаар хүүхдийн уушгины үрэвслийн үед цус бүлэгнэлт багасч байхад Ю. А. Шовкоплясынхаар цус бүлэгнэлт ихсэж байна (1).

Бид хүүхдийн уушгины цочмог үрэвслийн үеийн цус бүлэгнэлтийн өөрчлөлтийг өөрийн орны нөхцөлд судлах зорилт тавьсан юм. Уушгины цочмог үрэвслийн үеийн цус бүлэгнэлтийн өөрчлөлтийг тогтоохын тулд хэвийн үзүүлэлтийг авч үзье. 1—14 хуртэлх наслын хүүхдийн цус бүлэгнэлтийн хэвийн үзүүлэлтийг (2) хүснэгт 1-д харуулав.

Хүснэгт 1

Хүүхдийн цус бүлэгнэлтийн зарим үзүүлэлт

№	Үзүүлэлтүүд	M±	±б	±m	Насанд хүрэгчид
1.	Цус бүлэгнэх хугацаа (мин)	6,2	2,0	0,2	5—10
2.	Цайдрамал шилний бүлэгнэлт (мин)	16,4	3,3	0,5	—
3.	Сийвэнгийн дахин кальцжих сек)	106	20,4	0,5	60—120
4.	Тромботест (зэрэг)		IY—IY		IY—IY
5.	Протромбины хэрэгцээ (%)	97,0	3,3	0,5	80—100
6.	Фибриноген (Мг %)	280	68	8,9	200—400
7.	Фибрин задлах идэвхжил (цаг)		2—5		2—4
8.	Гепаринд тэсвэрлэх чанар (мин)	6,6	3,8	0,5	7—11
9.	Чөлөөт геларин (сек)	4,7	0,8	0,01	5—7, нэгж

Бид 1960 оноос эхлэн уушгины цочмог үрэвслийн үеийн эмгэг жа-
мыг лавшуулан судлах, эмчилгээний оновчтой арга боловсруулах,
үрэвслийн цус бүлэгнэлтийн хямралыг судлах зорилгоор судал-
гаа хийж эхэлсэн юм (8—9). Судалгаанд нийт 3 сараас 16 наасны 72
хүүхэд хамрагдсан. Бүх хүүхдийн 30 нь энгийн, 42 нь хордлоготой хэл-
бэрийн үрэвсэлтэй байв. Өвчтөний онош нь зовиур шаналгаа, бодит үз-
лэг, туслах шинжилгээгээр бүрэн нотлогдсон.

Хүснэгт 2

Ажиглалтанд авсан хүүхдийг онош, нас, хүйсээр харуулбал:

№	Онош	өвчтөний тоо	Хүйс		Нас		
			эр	эм	3 хүртэлх	4—7	8—16
	Энгийн хэлбэр	30	15	15	14	12	6
	Хордлогот хэлбэр	42	19	23	18	14	8
	БҮГД	72	34	38	32	26	14

Цус бүлэгнэх хугацааг Ли Уайтын аргаар, сийвэнгийн дахин кальц-
жих хугацааг Бергергоф болон Роккийн аргаар, тромботесын зэргийг
Фулите-Итагийн арга засварласан М. А. Котовщиковагийн аргаар, прот-
ромбины хэрэгцээг М. А. Котовщикова болон З. Д. Федоровагийн аргаар,
гепаринд тэсвэрлэх чанарыг Зиггийн аргаар, фибриногеныг
Р. А. Рутбергийн аргаар, фибриний өтгөрлийг В. П. Балудагийн аргаар
тус тус тодорхойлов.

Хүүхдийн уушгины цочмог үрэвслийн үеийн цус бүлэгнэлтийн за-
рим үзүүлэлтийг хүснэгт 3-д харуулав.

Хүснэгт 3

Эмнэлэүйн онош	Цус бүлэгнэх хугацаа (мин)	Сийвэнгийн дахин кальцжих (сек)	Тромботест (зэрэг)	Протромбины хэрэгцээ (%)	Гепаринд тэсвэрлэх чанар (мин)	Фибриноген (мг %)	Фибриний өтгөрөл (мин)
Энгийн хэлбэр	7,68 ± 1,98 ± 0,23	100,17 ± 10,24 ± 0,18 ±	II—YI	71,18 ± 2,24 ± 0,20	11,18 ± 2,33 ± 0,26	188,66 ± 63,4 ± 6,4	11,24 ± 2,44 ± 0,19
Хордлогот хэлбэр	6,75 ± 1,93 ± 0,29	91,36 ± 10,33 ± 0,20	YI—VII	75,61 ± 1,77 ± 0,26	13,68 ± 1,56 ± 0,24	398,36 ± 75,66 ± 0,21	10,18 ± 1,04 ± 0,15

Уушгины цочмог үрэвсэлтэй хүүхдийн цус бүлэгнэлтийн үзүүлэл-
тийг 3 бүлэг болгон ангилж бүлэгнэлт хэвийн, бүлэгнэлт ихсэх, ба-
гасах хандлагатай гэж магадлуур тогтоон мөрдэн ажиллаа. Эдгээр ма-
гадлуурыг дараах хүснэгтээр харуулав.

**Уушгины цочмог үрэвслийн үеийн цус бүлэгнэлтийг
үнэлэх магадлуур**

№	Үзүүлэлтүүд	Бүлэгнэлт		
		хэвийн.	багасах	ихсэх
1.	Цус бүлэгнэх хугацаа (мин)	7—10	>10	<7
2.	Сийвэнгийн дахин кальцжих (сек)	90—120	>120	<90
3.	Тромботест (зэрэг)	IY—IY	<IY	>IY
4.	Протромбины хэрэгцээ (%)	80—100	<80	>100
5.	Гепаринд тэсвэрлэх чадвар (мин)	6—10	>10	<6
6.	Фибриноген (мг %)	200—300	<200	>300
7.	Фибриний өтгөрөл (мин)	10—12	>12	<10
8.	Фибринсген В	+-	—	++

Бидний судалгаанд хамрагдсан өвчтөний 24 буюу 33,3% нь хэвийн үзүүлэлттэй, 11 буюу 15,3% нь цус бүлэгнэлт багасах, 37 буюу 51,4% нь цус бүлэгнэлт ихсэх хандлагатай байв.

ДҮГНЭЛТ 1. Бидний ажиглалтаар уушгины цочмог үрэвслийн үед гемокоагуляци өөрчлөгдж байна.

2. Уушгины цочмог үрэвслийн үед цусанд фибриноген ихсэх нь бие маходын хамгаалах урвал юм.

3. Уушгины цочмог үрэвслийн хордлогот хэлбэрийн үед цусны бүлэгнэх хугацаа, сийвэнгийн дахин кальцжих нь богинооч байгаа, гепаринд тэсвэрлэх чанар нэмэгдэж, фибриний өтгөрөл ихсэж, тромботест IY—IY зэрэг болж байгаа нь бүлэгнэлт ихсэж байгааг харууллаа.

4. Цусны бүлэгнэлт ихсэж байгаа нь уушгины цочмог үрэвслийн үеийн хордлогот хэлбэрийг эмчлэх эрчимт эмчилгээний бүрдэлд цус бүлэгнэлтийн эсрэг эм хэрэглэх шаардлагатай харуулж байна.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Шовкопляс Ю. С. Пед. 1978, 10, 7—11
2. Папаян А. В., Алексеев А. А. Пед. 1976, 62—65
3. Сүхбаатар М. Изменения коагулограммы при острой пневмонии у детей. Тез. докл. конф., посвященной 60 летию МНР. УБ. 1981, 126.
4. Сүхбаатар М. Опыт применения гепарина при острой пневмонии у детей. УБ 1981, IY, 93—94.
5. Сүхбаатар М. Изменения коагулограммы при различных формах острой пневмонии и метод их коррекции. Тез. докл. конф., посвященной 40 летию основания Монгольского государственного медицинского института. УБ. 1982, 108.
6. Сүхбаатар М. Результаты применения гепарина в комплексной терапии тяжелых форм острой пневмонии у детей. Тез. докл. конф., посвященной 30 летию КЦДБ. УБ. 1982, 11.
7. Котовщикова М. А. Методические указания по исследованию свертывающей системы крови. 1966, 6—13
8. Данилова Г. Н. Методы определения гепарина в крови. Лабор. дело. 1974, 9, 523—527.
9. Балуда В. П. Лабор. дело. 1959, 2, 47—53.

ИЗМЕНЕНИЯ КОАГУЛОГРАММЫ ПРИ ОСТРОЙ ПНЕВМОНИИ У ДЕТЕЙ

М. Сухэ-батор

У 72 больных (34 девочки и 38 мальчиков в возрасте от 3 мес до 16 лет) с острой пневмонией исследовали показатели свертывающей и фибринолитической систем крови. У 30 детей (15 девочек и 15 мальчиков) выявлены простые формы пневмонии а у 42 детей (23 девочки и 19 мальчиков) токсические формы.

В результате исследований при токсической форме пневмонии отмечены укорочение времени свертывания и рекальцификации плазмы, повышение толерантности плазмы к гепарину, значительное возрастание фибринового сгустка и степени и тромботеста.

По показателям свертывающей и антисвертывающей системы крови при острой пневмонии выявлено 3 типа коагулограмм: нормальная (У 24 детей—33,3%), с наклонностью к гипокоагуляции (11 детей—15,3%) и с наклонностью к гиперкоагуляции (37 детей 51,4%).

— O —

Г. ДЭЖЭЭХҮҮ

ЦУСНЫ ДАРАЛТ ИХСЭХ ӨВЧНИЙ ЭМНЭЛ ЗҮЙН ИЛРЭЛЭЭР ӨВЧТӨНИЙ ТАВИЛАНГ ТОДОРХОЙЛОХ

АНАГААХ УХААНЫ ХҮРЭЭЛЭН

Цусны даралт ихсэх өвчний эмнэл зүйн илрэлийг судлах нь уг өвчний онош, үе шат, явцыг тогтооход чухал ач холбогдолтой юм.

Сүүлийн уед судлаачид цусны даралт ихсэх өвчний үеийн эмнэл зүйн зарим шинж тэмдгээр уг өвчний төгсгөл, тавиланг тодорхойлохыг зорьж байна. Гэвч энэ талаар хийсэн судалгаа төдий л их биш юм.

Иймээс цусны даралт ихсэх өвчний үеийн эмнэл зүйн зарим шинжээр уг өвчний тавиланг тодорхойлох зорилт тавьж энэхүү судалгааг хийв.

СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ БА АЖЛЫН ХЭМЖЭЭ. Цусны даралт ихсэх өвчний учир судалгаанд хамрагдсан 1177 өвчтөнээс сүүлийн 5 жилийн дотор уг өвчиөөр нас барсан 79 хүний судалгааны материалд анализ хийв. Хяналтын явцад судалгаанд хамрагдсан бүх өвчтөнд шээс, цусны шинжилгээ, цусны холестерин, сахар, үлдэгдэл азот, зүрхний цахилгаан бичлэг (ЗЦБ), нүдний уг шинжлэх, биеийн жин өндрийг хэмжих зэрэг өвчний онош, үе шат, явцыг тодорхойлох шинжилгээг жил бүр тогтмол хийж байв.

Энэхүү судалгаанд өвчтөний сүүлийн үеийн үзлэг, зарим шинжилгээний дүнг оруулав.

Өвчтөний зүрхний цахилгаан бичлэгт Миннесотын кодын дагуу анализ хийж, нүдний угийг Кейт-Вагнер-Баркерийн ангиллаар, биеийн жинг өндрийн хэмжээнд харьцуулах [4] журмаар үнэлгээг өгөв.

Өвчтөний зовиур, өвчилсөн хугацаа зэргийг уг өвчтөний өгүүллийг баримтлаа авав.

Цусны даралт ихсэх өвчний үе шатыг тогтоохдоо ДЭХБ-аас 1962 онд боловсруулсан ангиллыг баримтлав. [4]

Уг судалгааны статистикийн зарим үзүүлэлтийг ЭВМ-ТРА1-1001 тооцоолон бодох машины тусламжаар бодов.

СУДАЛГААНЫ ДҮН. 5 жилийн хугацаанд цусны даралт ихсэх өвчтэй 123 хүн нас барснаас 79 нь уг өвчний хүндрэлээр, 44 нь бусад шалтгаанаар нас баржээ. Цусны даралт ихсэх өвчиөөр нас барсан 79 өвчтөний 54 (68,36%) нь тархинд цус харваж, 9 (11,40%) нь зүрхний шигдээсээр, 7 (8,85%) нь бөөрний архаг дутагдлаар, 9 (11,40%) нь гэнэт нас барсан байна.

Бусад шалтгаанаар нас барж буй хүмүүсийн олонхи нь элэгний болон бусад эрхтэний хорт хавдар, сурьеэ, ушгины архаг үрэвсэлт өвчнөөр нас баржээ.

Хүснэгт 1

Цусны даралт ихсэх өвчнөөр нас барсан хүмүүсийн насыны байдал

Нас барсан шалтгаан насны бүлэг	тархинд цус харвах	зүрхний шигдээс	бөөрний архаг дутагдал	гэнэт нас барсан	Бүгд	Хувь
20 хүртэл						
20—24					1	1,26
25—29					5	6,83
30—34	1				2	2,54
35—39	5				5	6,83
40—44	1		1		17	21,52
45—49	2	1	2		18	22,78
50—54	11	2	1	3	31	39,24
55—59	15	1	=	2	79	100%
60 ба дээш	19	5	3	4		
Бүгд	54	9	7	9		

Дээрх хүснэгтээс үзэхэд уул өвчинөөр нас барах явдал ихэвчлэн (83,55%) 50-иас дээш насны хүмүүст тохиолдож байна. 50-иас доош насанд нас барагсдын 69,23% нь тархинд цус харвах, 7,7% нь зүрхний шигдээс, 23,07% нь бөөрний архаг дутаглаар тус тус нас баржээ.

Хүснэгт 2

Цусны даралт ихсэх өвчинөөр нас барагсдын өвчний үе, шат.

Нас барсан шалтгаан өвчний үе шат	бүх өвчтөн	тархинд цус харвах	зүрхний шигдээс	бөөрний архаг дутагдал	гэнэт нас барсан	Бүгд	Хувь
I	618	7	3			10	12,65
II	388	11	2	2	3	18	22,79
III	171	36	4	5	6	51	64,56
БҮГД	1177	54	9	7	9	79	100%

Дээрх хүснэгтээс үзэхэд цусны даралт ихсэх өвчинөөр нас барсан 79 өвчтөний 51 (64, 56%) нь уг өвчний III үед нас баржээ. Харин нас барсан өвчтөнүүдийг үе шат тус бурд нь авч үзэл I үед байгаа 618 өвчтөнөөс 1,62% нь, II үед байгаа 388 өвчтөнөөс 4,64% нь, III үед байгаа 171 өвчтөнөөс 29,83% нь тус тус уг өвчинөөр нас барсан байна.

Хүснэгт 3

Цусны даралт ихсэх өвчнөөр нас барсан хүмүүст
илэрч байсан зовиур (%)

нас барсан шалтгаан Зовиур	Тархинд цус харвах	зүрхний шигдээс	бөөрний архаг дутагдал	гэнэт нас барсан	Бүгд
Толгой өвдөх	24,0	12,2	11,1	18,4	18,9
Толгой эргэх	12,0	—	11,1	10,5	10,4
Хүзүү хөших	20,0	—	5,0	15,8	14,2
Нүд бүрэлзэх	16,0	10,2	6,1	13,2	13,2
Нойр муудах	8,0	3,1	11,1	7,9	6,6
Зүрх дэлсэх	4,0	9,1	22,2	5,3	8,5
Зүрх өвдөх	8,0	38,2	—	5,3	6,5
Амьсгаадах	8,0	18,2	11,1	10,5	12,3
Хавагнах	—	9,1	22,2	7,9	5,6
Дотор муухайрах	—	—	—	2,6	—
Бүгд	100,0	100,0	100,0	100,0	100,0

Дээрх хүснэгтээс үзэхэд тархинд цус харваж нас барагсдын 80,0 %, гэнэт нас барагсдын 65, 8 %-д толгой өвдөх, хүзүү хөших, нүд бүрэлзэх зэрэг тархи мэдрэлийн зурхний шигдээсээр нас барагсдын 74, 6 %-д зүрх өвдөх, амьсгаадах зэрэг зурхний талын зовиур давамгайлан илэрч байжээ.

Хүснэгт 4

Цусны даралт ихсэх өвчнөөр нас барагсдын артерийн даралтын дундаж
(мм. МУБ)

артерийн даралт Хүндрэл	систол		диастол	
	M	±G	M	±G
Тархинд цус харвах	208,39	23,6	190,33	14,53
Зүрхний шигдээс	184,5	30,82	113,25	16,72
Бөөрний архаг дутагдал	212,0	22,78	128,25	6,49
Гэнэт нас барсан	202,83	33,87	114,5	16,26

Хүснэгтээс үзэхэд цусны даралт ихсэх өвчний хүндрэл нь ихэвчлэн систолын даралт 200 мм МУБ, диастолын даралт 110 мм МУБ-ас дээш байгаа уед тохиолдож байна. Бөөрний архаг дутагдаар нас барсан хүмүүсийн артерийн даралт, ялангуяа диастолын даралт нь бусад хүндрэлийн үеийнхээс харьцангуй өндөр байна.

Хүснэгт 5-аас үзэхэд зүүн ховдлын гипертрофи, ST—сегмент, Т—щүдний өөрчлөлт нь цусны даралт ихсэх өвчний аль ч хүндрэлийн уед элбэг илрэх боловч зүрхний шигдээсээр нас барахын өмнөх уед илүү их илэрч байжээ.

Нүдний уг шинжилсэн дүнгээс үзэхэд нас барагсдын нүдний угт цусны даралт ихсэх өвчний үеийн өөрчлөлт 100 % илэрч байснаас нейроangiопатийн өөрчлөлт бөөрний архаг дутагдалтай хүмүүсийн 85, 7 %-д, тархинд цус харавсан хүмүүсийн 52,2 %-д, гэнэт нас барагсдын 42, 9 %-д, зүрхний шигдээсээр нас барагсдын 28,6 %-д тус тус илэрч байв.

**Цусны даралт ихсэх өвчнөөр нас барагсдын Зүрхний цахилгаан
бичлэгт илэрсэн үндсэн өөрчлөлтүүд (%)**

			Зүүн ховдлын гипертрофи	S—T сегментийн өөрчлөлт	T—ш үдний өө рөлөлт
Тархинд цус	эр	60,0	40,0	60,0	
харвах	эм	57,14	42,86	42,86	
	бүгд	58,33	41,67	50,0	
Зүрхний шигдээс	эр	100,0	100,0	100,0	
	эм	66,67	66,67	100,0	
	бүгд	75,0	75,0	100,0	
Бөөрний архаг	эр	100,0	66,67	66,67	
дугтагдал	эм	100,0	50,0	50,0	
	бүгд	100,0	60,0	60,0	
Тэнэт нас барсан	эр	66,67	50,0	50,0	
	эм	66,67	33,33	33,33	
	бүгд	66,67	44,44	44,44	
Бүгд	эр	73,33	53,33	60,0	
	эм	66,67	46,67	53,33	
	бүгд	70,0	50,0	56,67	

Нас барсан хүмүүсийн биеийн байдалд судалгаа хийж үзэхэд зүрхний шигдээсээр нас барагсдын 75 %, гэнэт нас барагсдын 55,5 %, тархинд нь цус харваж нас барагсдын 49,8 %, бөөрний архаг дутагдлаар нас барагсдын 25 % нь жин ихтэй хүмүүс байв.

ШҮҮМЖ. Цусны даралт ихсэх өвчтэй хүмүүсийн нас баралтын талаар хийсэн судалгааны ажил цөөнгүй байдаг. [1—2] Гэвч цусны даралт ихсэх өвчний үед илэрч буй эмнэл зүйн шинж тэмдгээр уг өвчний тавиланг тодорхойлох талаар хийсэн судалгааны ажил төдий л их биш юм.

Хүнд хэлбэрийн цусны даралт ихсэх өвчтэй 60 хүртэл насны 100 өвчтөнг 1955 оноос 1965 он хүртэл 10 жилийн турш хяналтанд авч ажиглалт хийжээ. [5] Судалгааны дүнгээс үзэхэд диастолын даралт өндөр байх, нүдний уgt ретинопатийн өөрчлөлт илрэх, зүрхний зүүн ховдлын гипертрофи, бөөрний үйл ажиллагааны дутагдал илрэх нь уг өвчний тавиланд муугаар нөлөөлж байжээ.

Судалгаанаас үзэхэд цусны даралт ихсэх өвчтэй хүмүүс тархинд цус харвах болон зүрхний шигдээсээр нас барагдад систол, диастолын даралт шууд нөлөөлж байжээ. [5]

Манай судалгаанд хамрагдсан 1206 хүнд илэрч байсан эмнэл зүйн шинж тэмдгүүдийг судалж үзэхэд arterийн даралт ихсэх нь өвчний үе шат ахих, зүрхний булчин болон нүдний уgt органик өөрчлөлт үүсэхэд шууд хүчтэй нөлөөлж байлаа [3].

Бидний судалгааны дүнгээс үзэхэд ч цусны даралт ихсэх өвчний хүндрэл нь систолын даралт 200 мм МУБ, диастолын даралт 110 мм МУБ-аас дээш байгаа үед ихэвчлэн тохиолдож байна. Энэ нь цусны даралт ихсэх өвчний хүндрэлээс сэргийлэхийн тулд юуны өмнө arterийн даралтыг бууруулах нь чухал ач холбогдолтой болохыг харуулж байна.

Цусны даралт ихсэх өвчнөөр нас барсан хүмүүсийн зүрхний цахилгаан бичлэгт судалгаа хийж үзэхэд зүүн ховдлын гианертрофи болон *ST* сегмент, *T*—шүдний өөрчлөлт нь зүрхний шигдээс, бөөрний архаг дутагдлаар нас барсан хүмүүст харьцангуй их илэрч байжээ. Иймд зүрхний цахилгаан бичлэгт зүрхний титэм судасны дутагдлын шинж болох *ST* сегмент, *T*—шүдний өөрчлөлт илэрч буй хүмүүст даралт бууруулах эмчилгээ хийхийн зэрэгцээ зүрхний булчингийн тэжээллэг чанарыг сайжруулах, титэм судасны дутагдлыг багасгах, эмчилгээнүүдийг хавсран хийх нь чухал байна.

Нүдний угийн байдлыг шинжилсэн дүнгээс үзэхэд нейроангиретинопатийн өөрчлөлт ихэвчлэн бөөрний архаг дутагдлаар нас барсан хүмүүст (85,7 %) илэрч байжээ. [2] Зарим судлаачид нүдний угт нь ретинопати, нейроангиретинопатийн өөрчлөлт илэрч байсан 290 хүний үхлийн шалтгааныг судалж үзэхэд 33 % нь бөөрний архаг дутагдлаар, 23 % нь тархинд цус харваж, 21 % нь зүрхний шигдээсээр нас барсан байжээ. [3]

Бидний болон дээрх судлаачдын судалгааны [1—4] дүнгээс, үзэхэд нейроангиретинопати нь цусны даралт, ихсэх өвчний хүнд хэлбэрийн үед элбэг тохиолдож голдуу бөөрний архаг дутагдлаар төгсдөг болохыг харуулж байна. Иймд даралт ихтэй өвчтөний нүдний угт нейроангипатийн өөрчлөлт илэрч байвал бөөрний үйл ажиллагааг тодруулах шинжилгээнүүдийг нэмэн хийж, шаардлагатай бол бөөрний архаг дутагдлаас сэргийлж эмчилвэл зохино.

Цусны даралт ихтэй тарган хүмүүс ихэвчлэн зүрхний шигдээсээр нас барж байна. Эдгээр үзлэг шинжилгээний дүнгээс үзэхэд тархи мэдрэлийн талын зовиур давамгайлан илэрч байсан, нүдний угтаа ангиосклероз ба ретинопатийн өөрчлөлттэй хүмүүсийн тархинд нь цус харваж зүрхний талын зовиур ихтэй, зүрхний цахилгаан бичлэгтээ *ST*—сегмент, *T*—шүдний өөрчлөлт нь тод илэрсэн, жин ихтэй хүмүүс зүрхний шигдээсээр, нүдний угтаа нейроангиретинопатийн өөрчлөлттэй, диастолын даралт өндөр байдаг хүмүүс бөөрний архаг дутагдлаар зонхилон нас барж байна гэж үзэж болохоор байна.

ДҮГНЭЛТ 1. 5 жилийн хугацаанд цусны даралт ихсэх өвчтэй 123 хүн нас барснаас 79 нь уг өвчний хүндрэлээр, 44 нь бусад шалтгаанаар нас баржээ. Цусны даралт ихсэх өвчнөөр нас барсан өвчтөнүүдийн 68,36 % нь тархинд цус харваж нас барсан байна.

2. Цусны даралт ихсэх өвчний хүндрэл нь систолын даралт 200 мм МУБ, диастолын даралт 110 мм МУБ-аас дээш үед ихэвчлэн тохиолдож байна.

3. Тархи мэдрэлийн талын зовиур давамгайлан илэрч байсан, нүдний угтаа ангиосклероз ба ретинопатийн өөрчлөлттэй хүмүүс зонхилон тархинд цус харваж, зүрхний талын зовиур ихтэй, зүрхний ажиллагаа болон *ST*—сегмент *T*—шүдний өөрчлөлт тод илэрсэн, жин ихтэй хүмүүс зүрхний шигдээсээр, нүдний угт нь нейроангиретинопатийн өөрчлөлттэй, диастолын даралт өндөр (120 мм МУБ ба түүнээс их) байдаг хүмүүс бөөрний архаг дутагдлаар нас барж байна.

4. Цусны даралт ихсэх өвчтэй хүмүүсийг идэвхтэй эмчлэхийн зэрэгцээ жилд 1—2 удаа зурхний цахилгаан бичлэг хийх, нүдний уг шинжлэх, жин өндрийн харьцааг тодорхойлж байх нь өвчний явц, тавиланг төдорхойлоход чухал ач холбогдолтой байна.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Breckridge A., Dollery C. T., Rarry R. H. C.
Prognosis of reatted Hyper tension
Extract from The Quarterly
J. of Med. Volume XXXIX N 155

2. Bock K. D. Verlauf und Prognose des Nochrucks unter Dauertherapie mit Antihypertensiven. Therapiewoche 1980. 24. 34. 1657—1665.
3. Сидельникова Т. Я. Ледяшова Г. А. Добротворская Т. Я. Причины летальных исходов при гипертонической болезни. Кард. 1977. 8. 104—109.
4. Гуревич Т. З., Габинов Л. А., Кармазин И. Я., Володина М. В., Ридер Р. Е., Хмара Е. Г. Трудовой прогноз и исход заболевания у лиц умственного труда, страдающих гипертонической болезнью. Кард. 1972. 73—76.
5. Г. Дэжэхүү. Цусны даралт ихсэх өвчтэй хүмүүст хийсэн диспансерийн идэвхтэй хяналт эмчилгээ, түүний алсын үр дүн "эрдэм шинжилгээний ажлын тайлан". 1982. УБ., Анагаах ухааны хүрээлэн

КЛИНИЧЕСКОЕ ПРОЯВЛЕНИЕ ГИПЕРТОНИЧЕСКОЙ БОЛЕЗНИ И ЕЁ ПРОГНОСТИЧЕСКОЕ ЗНАЧЕНИЕ

Г. Дэжэхүү

Гипертоническая болезнь (ГБ) является одной из основных причин смертности людей от сердечно—сосудистых заболеваний.

Осложнения ГБ обычно наблюдаются тогда, когда систолическое давление превышает 200 мм рт. ст., диастолическое 110 мм рт. ст.

У больных, скончавшихся от инсульта, при жизни обнаруживаются ангиосклероз и ретинопатия глазного дна, преобладающие жалобы со стороны нервно-сосудистой системы; от инфаркта—выраженные изменения ST сегмента и зубца T на ЭКГ-ме, ожирения, преобладающие жалобы со стороны сердечно-сосудистой системы; от уремии, высокое давление (диастолическое) и нейроангиропатия глазного дна.

Осложнения ГБ наиболее часто (80 %—90 %) встречаются у больных старше 50 лет.

М. ОТГОН

ХЭТ АВИАГААР ОНОШЛОХ АСУУДАЛД АНАГААХ УХААНЫ ДЭЭД СУРГУУЛЬ

Хэт авиааг анагаах ухаанд хэрэглэж эхэлснээс хойш 30 гаруйхан жил өнгөрсөн боловч, сүүлийн жилүүдэд оношилгоо, эмчилгээний зорилготой олон төрлийн аппарат багаж хэрэгслийг Пикер, Сименс, Алока фирмуудэд үйлдвэрлэн (1,2) дэлхийн олон улс оронд хэрэглэж байна. Эдгээр аппарат багаж хэрэгсэл нь дотроо А, В хоёр аргын зориулалттай, 600000—15 сая герцийн давтамжтай авиа гарган, эргэх цуурайг мэдрэн хүлээн гвч дурс бичлэгээр илэрхийлэх хүчин чадалтай нь дээр дотор, мэс засал, бөөр, эх барих эмэгтэйчүүдийн өвчнийг оношлох 4 үндсэн чиглэлд төрөлжин үйлдвэрлэгдэж байна. (I) Хэт авианы тусламжтайгаар олон янзын өвчин эмгэгийг эрт илрүүлж, хундрэлээс урьдчилан сэргийлэх боломжтой юм. Хэт авианы шинжилгээ нь ямар нэгэн хор аюулгүй учир рентген шинжилгээг халах тавилантай. Иймд бид өөрийн улсын анагаах ухааны практикт хэт авиаагаар оношлох кабинетыг ДЭХБ-ын тусламжтайгаар байгуулж тодорхой судалгаа хийж шат дараалсан арга хэмжээ авч байна.

СУДАЛГААНЫ ЗОРИЛТ—Юны өмнө хэт авианы эхокамерийн тусламжтайгаар эх барих эмэгтэйчүүдийн практикт тохиолдох өвчнийг оношлох арга эзэмших дараа нь удамшилын өвчинийг эрт илрүүлэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, үүний тулд: 1. Хэт авианы эхокамерийн ажиллагааг анагаах ухааны практикт нэвтрүүлж тусгай кабинет байгуулах. 2. Эх барих, эмэгтэйчүүдийн өвчиний заалтаар үзүүлсэн хүмүүст судалгаа хийж мэдээлэх. 3. Эхокамерт оношилж болох зарим өвчиний ачааллыг тодорхойлох гол зорилготой ажиллав.

СУДАЛГААНЫ АРГА БА МАТЕРИАЛ—Японы Алока фирмд үйлдэврлэсэн хэт авианы ССД—202 маркийн Эхокамер (3) дурс санах төхөөрөмж (4) поларойд зураг авах хэрэгслийн (5) зааврыг орчуулсан аппаратыг ажилд оруулав. Уг эхокамерыг 1982 оны сүүлчээр ажиллуулж эхлэн, үзүүлсэн хүмүүсээс 106 хүнийг энэхүү судалгааны материал болгон авав. Судалгаанд 20—41 насны жирэмсэн 100, эмэгтэйчүүдийн өвчин, жирэмсний хүндрэлтэй 6 хүн хамрагдзав. Бүх хүмүүсийг В-аргаар судлав.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН—Судалгаанд онош тодруулах зорилгоор явуулсан хүмүүс нь жирэмслэлтийн янз бүрийн хугацаатай (5—41 долоо хоног) байв. Бидний ажиглалтаар уг эхокамерын дэлгэцэнд жирэмслэлт 6—7 долоо хоногтой байхад ураг эс харагдаж, 8—9 долоо хоногтойд хөврөлийн мөчний хөдөлгөөн, зарим үед зүрхний лугшилт харагдаж байв. Ураг-эсийн хуваагдал дуусан, ургийн эрхтэн үүсч, эсийн ялгарал явагдаж дуусах үеэс жирэмслэлтийн 25—26 долоо хоногтой байхад ихэс 2—3 см болон зузаарсан байх нь ажиглагдаж байв.

Умайн хөндийд байгаа ургийн байрлалыг энэ үеэс тодорхойлсныг хүснэгт 1-д харуулав.

**Хүснэгт 1
Ургийн байрлалын тодорхойлолт**

№	Ургийн хөгжил, байрлал	Тохиолдлын тоо %
1	Дагуу байрлалтай, толгой түрүүлсэн	74. (74 %)
2	Дагуу байрлалтай. Ааргаар түрүүлсэн	10. (10 %)
3	Хөндлөн байрласан.	1. (1 %)
4	Ташуу байрласан.	1. (1 %)
5	Үр зулбасан	5. (5 %)
6	Байрлал тодорхойгүй. Ураг эс	3. (3 %)
7	Хоёр ихэр	4. (4 %)
8	Умай дотроо эндсэн	2. (2 %)
9	Жирэмсний хүндрэл, эмэгтэйчүүдийн эмгэг хавсарсан Нийт	6. 106

Дээрх судалгааг хийхэд нэг хүнд дунджаар 4—5 мин, зураг авахад 6—8 мин, ургийн хүйсийг илрүүлэхэд 10—25 минутын хугацаа шаардагдаж байв. Харин ургийн хүйсийг энэ багажаар тодорхойлох нь зохимжгүй бөгөөд хүн тутамд үзэх шаардлагагүй гэж үзэж болох юм. Энэ үнэ ихтэй аргын оронд ургийн хүйсийг эхийн хэвлийд байхад нь оношилдог люминесцентийн микроскопын аргыг практикт нэвтрүүлж, шаардлагатай хүмүүст шинжилгээ хийх нь илүү үр дүнтэй юм.

Ихэнх хэвлэлд (6, 7, ургийн байрлал 32—33 долоо хоногтойд тогтвортой болдог тухай ойлголт байдаг боловч, судалгааны явцад 28—29 долоо хоногтойд ургийн хөдөлгөөн ихэд тогтвортжин умайн хөндийд бүтэн эргэж, чөлөөт хөвөлт хийх нь багасдаг гэсэн урьдчилсан дүгнэлт гарч байна. Үнд цаашид дин.мик судалгаа хийж тодруулах нь чухал ач холбогдолтой юм.

Ургийн хөгжлийн явц, байрлал, ихэс, хүйс дэлгэцэд тодорхой харгадаж байгаа учир ургийн усыг тусгай засалтын дагуу хатган авч удашлын өвчиний эрт илрүүлж зохих арга хэмжээ авах бололцоотой боллоо. Эхокамерын дэлгэцнээ эх барих, эмэгтэйчүүдийн өвчнүүд (савны гадуур жирэмслэлт, савны хавдар, өндгөвчний хавдар г. м.) болон хөхний хавdryг амархан оношлох, ургийн биометрийн хэмжилтийг хийж олохын зэрэгцээ ургийн болон удамшлын зарим нэгэн эмгэгийг илрүүлэх шаардлагатай байна.

Орчин үед энэ аргыг анагаах ухааны өдөр тутмын практикт байнга нэвтрүүлж, эх, нялхсын эрүүл мэндийг сахин хамгаалах ажилд үр дун өгөхүйц ажиллахын тулд зохион байгуулалт арга зүйн их ажил шаардагдаж байна.

ДҮГНЭЛТ. 1. Анагаах ухааны дээд сургууль, клиникийн нэгдүгээр амаржих газар хамтран хэт авиаагаар оношлох кабинет байгуулж, ажилд оруулав.

2. Хэт авианы эхокамерт эх барих, эмэгтэйчүүд, анагаах ухааны удамшил зүйн практикт тохиолдох зарим нэгэн эмгэгийг эрт илрүүлж, зохих арга хэмжээ авах бололцоотой болов.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Чех Э., Папеж. Л., Тарабе. О. Ультразвуковая диагностика в акушерстве и гинекологии. М. 1979
2. Хентов Р. А., Скорунский И. А., Флорианович Н. М., Тимофеева Т. Е. Ультразвуковые аппараты и методы диагностики в акушерстве и гинекологии. М. 1974
3. Aloka Instruction Manual for Electro-Multicrystal Scanner Echo Camera, Model SSD—202 D, 1—15
4. Aloka Image Memory Model UIM—101 operation manual I—10
5. Asunuma Instruction Manual for King CRT Camera ACR—75024
6. S. G. Clayton, D. Fraser, T. L. Lewis. Obstetrics, London, 1975, 5—66
7. C. I. Dewhurst. Integrated Obstetrics and Gynaecology for Post-graduates, London. 1976, 112—150

К ВОПРОСУ УЛЬТРАЗВУКОВОЙ ДИАГНОСТИКИ

М. Отгон

В результате обследования 100 беременных женщин с использованием ультразвуковой ЭХО-камеры выявлены: положение плода продольное с головным предлежанием в 74%, с тазовым предлежанием в 10%, с косым и попечечным положением в 2% случаев. Кроме этого, диагносцировано наличие близнецов в 4%, мертвого плода 2%, выкидыша в 5% и плодного яйца в 3% случаев. Излагаются методики обследования.

МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨ ЛГӨӨ, ЛЕКЦ, ТОЙМ

Ш. БАЯРТОГОХ

ХЭРЛЭГ ТӨСТ ҮЕНИЙ ҮРЭВСЛИЙН ҮЕД ҮЕНД СТЕРОИД ГОРМОН ХИЙЖ ЭМЧЛЭХ

АНАГААХ УХААНЫ ХҮРЭЭЛЭН

Үений үрэвсэлт өвчнийг эмчлэх хамгийн ур дунтэй аргуудын нэг нь стероид гормоныг хэрэглэх арга юм. Гэвч кортикостероидыг удаанаар уух ба булчигд тарьж хэрэглэх нь заримдээ гаж нэлээ үзүүлж, гюультай хүндрэл өгдөг.

Иймээс үений архаг үрэвсэл, ялангуяа хэрлэг төст үений үрэвслийн үед кортикостероидыг үенд тарьж хэрэглэх нь ашигтай ба өвчиний эдгэрлийг сайжруулдаг. Энэ аргыг хэрэглэхийн тулд хэрэглэх шаардлага, хэрэглэж болохгүй үе, тарих арга зүй зэргийг сайн мэдэж эзэмшилсэн байх ёстой.

ҮЕНД ЭМИЙН БОДИСЫГ ХИЙХ. Хэрлэг төст үений үрэвслийн үед үений хэсэг газрын үрэвслийг эмчлэхэд үенд эмийн бодисыг шууд хийж эмчлэх нь хурдан хугацаанд сайн үйлчилгээ үзүүлдэг. Үүнд: Кортикостероид гормоны бэлдмэл гидрокортизон, ультракортенол, аддерсон зэргийг үенд тарина.

Гидрокортизоныг том үенд 10—25 мг, жижиг үенд 2—5 мг-зар тус тус тарина. 1—2 долоо хоногийн дараа давтан тарина. Эмчилгээний курс нь 3—5 тарилга байна.

Ультракортенолын дундаж тун 10 мг байдаг. Түүнийг 3—5 хоногийн зйтай давтан тарьдаг. Том (өвдөгний) үенд 10—20 мг, жижиг үенд (хурууны) 5—10 мг-аар тус тус тарина.

Хэсэг газрын мэдээ алдуулагч бодисын хамт хэрэглэж болно.

Үений уутанд кортикостероид тарихад өвчиний 90% орчимд эхний хоногоос (6—12 цагийн дараа) үений хавдалт, өвдөлт багасч үений үрэвслийн шингэн арилж, үений хөдөлгөөн сайжирдаг.

Бид хэрлэг төст үений үрэвсэлтэй 32 хүнд кортикостероид гормоныг үенд хийж эмчилсэн ба гидрокортизон, ультракортенол, аддерсон зэргийн аль нэгийг тарьж байлаа. Жишээ нь өвчтөн Да. 54 настай, эрэгтэй, баруун гарын шуу, сарвууны үе, мөн эрхий ба дунд хурууны үенд аддерсоныг 2—3 удаа тарихад тэдгээр үений өвдөлт, хавдалт ул мөргүй арилж сайжирсан. Энэ өвчинөөс болж уг өвчтөн хөдөлмөрийн чадвар алдаж, тахир дутуугийн группээс гарч ажилдаа орсон бөгөөд өвчин нь одоо хүртэл дахилтгүй, биеийн байдал сайн, ажлаа хийж байна.

Мөн өвчтөн Сэ. 45 настай, эмэгтэй олон үений хэрлэг төст үрэвслийн 2 өвдөгний үе өвчлөн явахад бэрхшээлтэй болж таяг тулахад хүрсэн байна. Иймээс үефд ультракортенол 1 курс тарихад үений хавдалт, өвдөлт арилж эмчилгээнээс хийш жил хагасын хугацаанд биеийн байдал сайн байна.

Өвчтөн Жа. 27 настай, эрэгтэй, хөлийн шагай ба өлмий хурууны үенд ультракортенол курсээр тариулсан ба өвдөөд доголж гишгэж

чадахгүй байсан нь тариа хийсний дараа богино хугацаанд эдгэрч 1980 оноос хойш одоо хүртэл өвчний дахилт даамжралын шинжгүй, биеийн байдал сайн, ажлаа хийж байна.

Бидний ажиглалтаас үзэхэд аддерсон ба ультракортенол нь гидрокортизонос илүү сайн үйлчлэлтэй байна.

Дээр дурдсан гормон эмчилгээг «унд тарихын зэрэгцээ өрөнхий эмчилгээ (резохин, алтын давс, делагил) хослуулан хэрэглэх нь чухал. Үений тариаг урьд нь тарьсан туигаар давтан тарихад эмчилгээний үр дүн нь хэвээрээ байвал давтан тарихдаа эмийн тунг нэмж болно.

ҮЕНД ГОРМОН ХИЙХ ТУН ХЭМЖЭЭ. Энэ нь гормон эмчилгээний өрөнхий зарчмитай ижил төсөөтэй ба хангалтай үйлчлэл өгөх, их тунгаас эхлэн багасгаж хэрэглэх чиглэлийг баримтлана. Үйлчлэл сайн өгөх тунгийн хэмжээ нь үений хэмжээ, үрэвслийн идэвхжил, костикостероидод өвчтөний мэдрэг байдал зэргээс хамаарна. Мөн тухайн сонгож авсан гормоны үрэвслийн эсрэг үйлчлэх хүчинээс хамаарна.

Гидрокортизоныг тарихад сайн үйлчлэл үзүүлэх дундаж тун хэмжээг яиз бурийн үнд дараахь байдлаар байж болохыг тогтоосон байна.

Хүснэгт 1.

Гидрокортизоныг үнд тарихад сайн үйлчлэл үзүүлэх дундаж тун хэмжээ

Үе	Тун мг-аар	Үе	Тун мг-аар
тунхний өвдөгний шагайны бэлбэрхий үе өлмий хурууны мөрний	37,5 25—37,5 20—25 10—15 5—10 25	Тохойны Шуу сарвууны алганы хурууны гарын хурууны маяа эгэмний өвчүү эгэмний эрүүний	20—25 15—25 5—10 5—10 15 15 10—15

ҮЕНИЙ ШИНГЭНИЙГ АВАХ. Хэрлэг тэст үений цочмог ба цочмогдуу үрэвслийн үед хөндийд их хэмжээний үрэвслийн шингэн цугларах нь үений уут, үе орчмын зөөлөн эдийг сунгаж эсвэл хөшүүн болгодог. Энэ нь үений өвдөлтийг ихэсгэж, хөдөлгөөн нь муудсаар бүр хөдлөхгүй ч болгож болдог. Ийм нөхцөлд үнд хатгалт (пункц) хийж үений шингэннийг соруулж авах нь өвчтөнд амархан сайжрах нөлөө үзүүлдэг. Үений шингэн дахин цугларвал түүнийг давтан авч болно. Үнд шингэннийг авсаны дараа эмийн бодисыг үнд тарьж эмчилдэг.

КОРТИКОСТЕРООИДЫГ ҮЕНД ТАРЬЖ БОЛОХ БА ТАРЬЖ БОЛОХГҮЙ НЭХЦЭЛҮҮД

I. ТАРЬЖ БОЛОХ НЭХЦЭЛҮҮД.

1. Олон үнд үрэвслийн процесс тогтонги сайжралтай байхад өөр газар нэг буюу хэд хэдэн үнд экссудат шингэн бүхий илэрхий үрэвсэлтэй байх.

2. Хэд хэдэн том үнд үрэвслийн экссудат давамгайлсан үрэвсэлтэй байх, түүнд эм гормоны иж бүрэн эмчилгээ хийсэн боловч экссудат шингэн удаанаар арилахгүй байх.

3. Чухал үйл ажиллагаатай үенүүдэд үрэвслийн процесс явагдаж байхад ерөнхий гормон эмчилгээг хийж болохгүй нөхцөлүүд (цусны даралт ихдэх өвчин, хodoод ба 12 хуруу гэдэсний шархлаа, сэтгэл мэдрэлийн ба судас хатуурах өвчин) байх.

4. Ихэнх эмийн бэлдмэлүүдэд харшилтай учраас тэднийг хэрэглэж чадахгүй байх.

5. Урт хугацаагаар хийгдэж байсан ерөнхий гормон эмчилгээг гэниэт зогсоох буюу гормоны тунг багасгах шаардлага гарсан үед.

6. Үений хэлбэр өөрчлөгдөж, нугаларч хөдөлгөөн нь муудах контрактур үүсч буй үе шат. Тэгэхдээ тэр үе нь хэсэг газрын идэвхтэй үрэвслийн процессоор хүндэрсэн, контрактур үүсч эхэлснээс хойш 10—12 сараас дотогш хугацаанд байх.

7. Үений байнгын деформац, контрактуртай өөрчлөлтийг ортопед-мэс заслын эмчилгээгээр засах процесцд үений үрэвсэл хурцдахад.

8. Үеийг мэс заслаар эмчилсний дараахан ба мэс заслын эмчилгээ хийхийн өмнө тухайн үенд үрэвслийн идэвхтэй процесс явагдаж байхад.

9. Бүлхний хালьсны хэрлэг төст үрэвслийн үед шөрмөсний гадуур бүрхүүл уутанд үрэвсэл явагдаж экссудат шингэн цугларах, ялангуяа сарвуу ба тавхайн ар талын тэнийлгэх шөрмөсний уут үрэвсэхэд.

10. Үенд хийсэн эмчийн янз бүрийн ажилбар (үенд хий ба будагч бодис шахаж, зураг авах, үенд эмийн бодис тарих, тухайлбал: ТИО-ТЕФ, делагил, реопирин зэрэг) арга хэмжээний дараагаар үенд байсан үрэвслийн процесс хурцдаа зэрэг тохиолдолд тус тус тарина.

II. ТАРЬЖ ОГТ БОЛОХГҮЙ НӨХЦӨЛҮҮД.

1. Үений идээт үрэвсэлтэй байх

2. Үений сурьеэтэй байх

3. Сирингомиели мэтийн мэдрэлийн өвчиний үед хундрэл маягаар үений үрэвсэл ба эмгэгшил үүссэн байх.

4. Бие махбодод ялангуяа үенд ойрхон идээт үрэвсэл явагдаж байх.

5. Үений яс-мөгөөрсний хэсэгт бүтэц эвдрэх (деструктив) процесс хурдан явагдаж буй хэрлэг төст үений үрэвслийн яс хайлах хэлбэрийн үед.

6. Үенд ясны хэсэг хугарч бяцрах, тэр нь хоёрдогчоор үрэвсэн байх.

7. Гуяны ясны толгойд мөгөөрсний дор хэсэгт үхжил үүссэхэд энэ нь биеэ даасан Пертесийн өвчин байх, эсвэл ерөнхий гормон эмчилгээг удаанаар хэрэглэсний улмаас хүндэрч ясны үхжил үүссэн байх үед тарьж болохгүй.

ҮЕНД ХАТГАЛТ ХИЙХ ТЕХНИК. Үенд хатгалт хийх нь практикийн эмч нарт хамгийн боломжийн, энгийн арга юм. Гол нь ангисептик ба асептикийн дурмийг чанд сахин халдварт болирдол үүсэхгүйгээр хийх нь чухал. Үений хатгалтыг цэвэр боолтын өрөөнд буюу мэс заслын өрөөнд хийх ёстой. Эмчийн гарыг Спасокукоцкийн аргаар ариутгана. Үений хатгалт хийх арьсны хэсгийг Гроссиофиончиковын аргаар арчиж цэвэрлэнэ.

Тэр ариутгасан хэсгээ цэвэр даавуугаар тусгаарласны дараа арьсан дээрх иодны үлдэгдлийг спиртээр арчих нь хатгасан зүүний үзүүрээр иод дотогш үед нэвтрэхгүй байх боломжийг олгодог.

Тэгээд 0,25%-новоканины уусмалаар үечлэн мэдээ алдуулж үений хөндийд зүүг ортол хатгалт хийж, үений дотор шингэн байвал аль болох бүрэн гүйцэт соруулж авна.

Ингээд үенд эмийн бодис хийж эмчлэх шаардлагатай бол түүнийг аажим шахаж хийнэ.

Үений шингэн шприцэнд татагдан ирж байвал үений хөндийд зүү орж, хатгалт зөв болсны шинж болно.

Үенд зүү орсон эсэх нь мэдэгдэхгүй эргэлзээтэй үед ариутгасан физиологийн уусмалыг үнд хийж шалгаж болно. Тэгэхэд уг уусмал нь саадгүйгээр шахагдан орж байх ёстой. Хэрэв саадтай шахагдаж байвал зүүг цааш хөдөлгөн уусмалыг шахаж шалгаж үзэх хэрэгтэй.

Үеийг хатгах үед зүүгээр цус сорогдон гарч ирвэл судас тааралдсанаас болох тул зүүг буцаан сугалж, өөр газар хатгалт хийнэ. Үнд хатгалт хийсний дараа зүүг сугалж аваад хатгалт хийсэн хэсгийг иодын уусмалаар арчиж ариутгаад цэвэр боолт хийх буюу пластыр наажүенний хатгалтыг дуусгана.

Д. СҮХЭЭ

ЭХ БАРИХ ЭМЭГТЭЙЧУУДИЙН ПРАКТИКТ АЛГАНЫ ХЭЭНИЙ ШИНЖИЛГЭЭНИЙ АЧ ХОЛБОГДОЛ

ЭХ НЯЛХСЫГ ХАМГААЛАХ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН


1926 оноос анагаах ухааны удэмшил судлалын практикт алганы хээг шинжлэх арга өргөн хэрэглэгдэх болжээ.

Алганы хээний дардсыг шинжилгээний зорилгоор авах олон арга байдгаас хамгийн энгийн хялбар нь хэвлэлийн будгийг ашиглаж цаасан дээр дардас авах арга юм.

Алганы хээний зураглалыг тэмдэглэхэд анатомийн зарим нэр томьёог хэрэглэдэг. Бугуйн нугалааснаас хуруунуудын уг хүртэлх зайл алганы талбай гэж үздэг. Алганы талбайд алганы хонхорыг тойрсон б товгор багтана. Үүнд: чигчий хуруу талын алганы зах хэсгийн товгор (гипотенар) эрхий хурууны суурь хэсгийн товгор (тенар) хуруунуудын угийн хоорондох жижиг товгор хэсгүүд (1—4) хамаарагдана. (Зураг 1—А)

Эрхий талын товгор, долоовор хуруу хоорондын товгорын зааг эрхий хурууны нугалаасны шугам (8) болно. 3, 4, 5-р хурууг нугалах атгах хөдөлгөөнөөр алганы 1 дүгээр шугам алганы талбайд үүснэ. Энэ нь алганы чигчий талын ирмэгээс 2 дугаар хуруу хоорондын товгороны чиглэлд үүссэн байна. Харин алганы 2 дугаар нугалаас шугам нь 1 дүгээр хуруу хоорондын товгороос алганы чигчий талын зах тийш дотогшоо бугуй руу хэлбийж алганы талбайн 2/3 орчимд төгсөнө.

Зураг 1.



(А) алганы талбайн гурвалжин зураасууд.


1—4 хуруу хоорондын зэй, I—IV хуруу хоорондын товгор, Г—чи чий талын товгор (гипотенар), Т—эрхий хуруу талын товгор (тепар), 5—хуруунуудын угийн сарвууны нугалаас шугам, 7—алганы 2 дугаар нугалаас шугам, 8—эрхий хурууны нугалаас шугам, 9—бугуй нугалаас.

(Б) *Cummins Midlo* нарын схем (1943).

1—13 алганы талбайнууд: а, в, с, хурууны угийн гурвалжингууд А, В, С, Д-алганы гол шугамууд, t , t' , t'' -захын, завсарын төвийн байрлал бүхий алганы тэнхлэгийн гурвалжин.

Тасархай шугамаар *atd*-өнцгийг үзүүлэв.

Заримдаа дээрх 2 шугам хоорондоо хөндлөн нэг шугам болон алганы талбайг хөндлөн гарна. (зураг 2). Ингэж хөндлөн шугам үүсэх нь удамшлын хүчин зүйлээс хамаардаг гэж үздэг талтай. 13, 18, 21 дүгээр хромосомын гурвалсан байдал „муурын хэржигнүүр“ төст хам шинж мэтийн хромосомын өвчтэй хүмүүсийн 40%-иас дээш тохиолдолд нь дээр дурдсан алганы хөндлөн шугам ажиглагддаг байна (Зураг 2)



ЗУРАГ 2

АЛГАНЫ ХӨНДЛӨН ШУГАМ
/СҮМААР ЗААЖ ТЭМДЭГЛЭСЭН/

ЗУРАГ 3

Хурууны угийн гурвалжин-
гүуд а, в, с, д /СҮМААР ЗААСАН/

Алганы талбайд сарвууны нугалаас хурууны уг орчимд мөн зураглал бүхий хээ байна. Үүнд 2—5-р хуруунуудын уг хэсэгт З чиглэл бүхий нарийн зураасан хээний дунд тус бүр гурвалжингууд үүсдэг. (Зураг 3). Эдгээр гурвалжинг латини а. в. с. д үсгүүдээр тэмдэглэнэ. Энэ гурвалжингуудын дотор талын оройг үүсгэж цаашаа ургэлжилж алганы аль нэгэн талбайд очиж төгсч байгаа зураасыг алганы гол шугам гэж нэрлэх ба латини талбайн аль хэсэгт төгсч байгааг тодруулахын тулд алганы талбайг 13 хэсэгт хуваан байрлуулж болно. (Зураг 1Б, Зураг 3)

Алганы эрхий талын товгороос 1 дүгээр талбай эхлээд 1 дүгээр хуруу хоорондын товгорын хэсэг болох 13 дугаар талбайгаар дуусна.

Хурууны угийн а. в. с. д гурвалжингуудын аль нэг (голдуу С) нь хээнд илэрч гараагүй байх ба алганы гол шугам „А“ нь 1, 2 5 дугаар талбайд төгсөх зэрэг нь ховор тохиолдох боловч голдуу Шеревский Тернерийн хам шинж мэтийн хромосомын өвчний үед ажиглагддаг юм.

Алганы талбайд хурууны угийн гурвалжингаас гадна эрхий ба чигчий товгорын хооронд алганы тэнхлэгийн гурвалжин (*t*) гэж байдаг. Тэнхлэгийн гурвалжныг байрлалаас нь хамааруулж захын, завсрин, төвийн (*t*, *t'*, *t''*) гэж ангилна. Тэнхлэгийн гурвалжны байрлалыг тогтоохын тулд хурууны угийн *a*, *d* ба тэнхлэгийн гурвалжнуудын хооронд үүсэх өнцгийн хэмжээг тодорхойлно. (Зураг 1Б. <*atd*>). Хэрвээ *atd* өнцөг 40°-ба түүнээс бага байвал тэнхлэгийн гурвалжныг захын байрлалтай (хэвийн) *t* гэж үзэх ба уг өнцөг 41°—60° байвал завсрин (*t'*), 60°-аас их байвал төвийн (*t''*) (Зураг 1Б). байрлалтай гэж үзнэ.

Хромосомын эмгэг өөрчлөлтийн үед тэнхлэгийн гурвалжин дотогшоо шилжиж завсрин ба төвийн байрлалтай (*t'*, *t''*) болсон байдаг.

Алганы хээг шинжлэх явцад заавал хурууны өндөгний хээг тодорхойлох шаардлагатай. Хурууны өндөгний хээг нуман хээ (А-задгай хээ (*z*—7-oop), битүү хээ (*W—Whorl*) ба нийлмэл хээ (*C—compositte*) гэсэн 4 хэлбэрт ялгана. (Зураг 4).

Хурууны өндөгний хээний үндсэн хэлбэрүүд.



А—нуман хээ, Б—задгай хээ, В—битүү хээ
Шулун шугамаар өндөгний хээний мөрийн
тоог гаргана.

Дурдсан эдгээр хэлбэрээс битүү, задгай хээнүүд хамгийн элбэг тохиолдоно. Хурууны хээний хэлбэрийг хээний мөрийн тоогоор тодорхойлно. Нуман хээний уед мөрийн тоо 0 байх ба битүү, задгай хээнүүдэд 2—25 хүртэл байна. Харин 10-аас доош мөртэй хээг бага хээ гэж нэрлэнэ.

Эрдэмтдийн судалгааны материалаас үзэхэд хурууны хээний мөрийн тооны нийлбэр эрэгтэй хүнд 130—150, эмэгтэй хүнд 110—140 байна.

Хурууны хээний ерөнхий тоонд удамшилын хүчин зүйл нөлөөлдөг. Ялангуяа бэлгийн хромосомын эмгэг өөрчлөлтийн уед хурууны хээний мөрийн тоо өөрчлөгддөг.

Хүснэгт 1,

**ХЭВИЙН БА БЭЛГИЙН ХРОМОСОМЫН ЭМГЭГТЭЙ ХҮМҮҮСИЙН
ХУРУУНЫ ХЭЭНИЙ МӨРИЙН ТОО**

Судлаачдын нэр Судалсан он	Бэлгийн хромосомын бүтэц	Хурууны хээний мө- рийн дундаж тоо
Муравьева М. В.	хх	140
Трёпаков Е. А.	ху	150
Penroze	хо, xo/xx	166—178
Ichida и Soltan	хху	122
Alter	хуу	102
	ххуу	89
	хххуу	73
	хххху	43

Хүснэгтээс үзэхэд „Х“ хромосомын тоо цөөрөхөд хурууны хээний мөрийн тоо олшрох ба „Х“ хромосомын тоо олшроход мөрийн тоо цөөрч байгаа нь ажиглагдаж байна. (хо—199) байсан бол xxxxу-ийн үед 43 болсон байна.

Хромосом генийн өөрчлөлтийн үед алганы хээний зураглалын нийлээд элбэг тохиолдох өөрчлөлтийг хүснэгт 2, 3-д үзүүлэв.

Хүснэгт 2.

Хромосомын өөрчлөлтийн үе дэх алганы хээний зураглалын онцлог

Хромосомын өвчин	Алганы хээний онцлогууд
13-р хромосомын гурвалсан байдал (Патаугийн өвчин)	Эрхий товгорт нэмэлт хээ гарна. Тэнхлэгийн гурвалжин дотогшилж шилжинэ. (108°). Алганд хөндлөн шугам үүснэ.
18-р хромосомын гурвалсан байдал (Эдварсын өвчин)	Хуруу нуман хээтэй байна. Алганы хөндлөн шугам түүний хэлбэр илэрнэ. Хурууны хээний мөрийн тоо цөөрнө.
21-р хромосомын гурвалсан байдал (Дауны өвчин)	Хуруунд задгай хээ голчилно. Алганы хөндлөн шугам 2 гарг ижил илэрнэ. Тэнхлэгийн гурвалжин дотогшилно.
„Муурын хэржигнүүр“ төст хам шинж (5-р хромосомын богино мөрийн тасралт)	Хурууны хээнд битүү ба нуман хээ голчилно. Тэнхлэгийн гурвалжин дотогшилно. Хурууны угийн гурвалжин „С“ угүй болно. Алганы хөндлөн шугам түүний хэлбэр илэрнэ.
Шерешевский—Тернерийн өвчин (45, xo)	Хурууны битүү, задгай хээний аль нэг голчилно. Тэнхлэгийн гурвалжин дотогшилно. (61°). Хурууны хээний мөрийн тоо олширно. Хурууны угийн гурвалжин „С“ угүй болох ба „В“ гурвалжин чигчий тал руу хазайна.
Клейнфельтерийн өвчин (47, xxy)	Хуруу нуман хээтэй байна. Хурууны хээний мөрийн тоо цөөрнө. Тэнхлэгийн гурвалжин гадагшилж шилжинэ.

**Хромосомын өөрчлөлттэй холбоогүй тажиг хөгжлийн үеийн
алганы хээний зураглалын онцлог**

Гажиг хөгжил	Алганы хээний онцлог
Зүрхний төрөлхийн тажиг	Тэнхлэгийн гурвалжин дотогшилж шилжинэ.
Умайн тажиг хөгжил	Хуруун нуман хээтэй байна. Хээний мөрийн тоо цөөрнө. Тэнхлэгийн гурвалжин дотогшоо шилжинэ. Алганд хөндлөн шугам үүснэ.
Умайн дутмаг хөгжил	Хуруунд нум хэлбэрийн ба задгай хээ голчилно. Хээний мөрийн тоо цөөрнө.

Хүснэгтээс үзэхэд хромосом болон генийн өөрчлөлтийн үед алганы хээний дор дурдсан өвөрмөц шинжүүд илэрдэг байна. Үүнд:

1. Бүх хурууны өндөгийн хээ ижил байх
2. Хурууны хээний мөрийн ерөнхий тоо олшрох буюу цөөрөх
3. Тэнхлэгийн гурвалжны байрлал өөрчлөгдөх (ихэвчлэн дотогшоо шилжих)
4. Хурууны угийн гурвалжин үгүй болох эсвэл байрлалаа өөрчлөх.
5. Алганы хөндлөн шугам, түүний хэлбэр үүсэх зэрэг юм.

Орчин үед дерматоглификийн буюу алганы хээний шинжилгээг шинжилгээний бусад (цитогенетикийн) аргуудтай хослон хэрэглэж эх барих-эмэгтэйчүүд, хүүхдийн өвчин судлал болон анагаах ухааны бусад салбарт удамшлын холбогдолтой зарим өвчний цаг хугацаанд нь оношлоход өргөн ашиглаж байна.

Л. БАДАМХАНД

УХАМСРЫН МӨН ЧАНАР БА ТҮҮНИЙ ҮҮСЭЛ ГАРАЛ

АНАГААХ УХААНЫ ДЭЭД СУРГУУЛЬ

Хүний ухамсар, оюуны бүхий л үйл ажиллагаа материаллаг үүсэл гаралтай бодит үнэн боловч түүнийг энгийн рефлекст үйл ажиллагаатай адилтгэн үзэж тайлбарлаж болохгүй юм. (1)

Нөгөө талаар уураг тархины нарийн төвөгтэй механизмын тухай бидний одоогийн мэдлэг бүрэн бус хязгаарлагдмал учраас ухамсар, сэтгэхүй, сэтгэл зүйн талаар бүх нийтээр хүлээн зөвшөөрч баталсан нейрофизиологийн тодорхойлолтууд хараахан тогтоогүй байна.

Орчин үед ухамсар, сэтгэхүйн материалыст үндэслэлийг тодорхой судлалын баримттай тайлбарлан хөгжүүлэхэд И. П. Павловын шавь суут физиологоч П. К. Анохин, Болгарын философч Тодор Павлов, А. И. Опарин, П. В. Симонов нар ихээхэн нөлөө үзүүлжээ. (2—4)

П. К. Анохин, Тусгалын онол ба уураг тархины тухай орчин үеийн ойлголт "гэдэг бүтээлдээ ухамсын физиологийн мөн чанарыг ойлгохын тулд түүний эх үүсвэрийг өмд өртөнцийн түүхэн хөгжил Дарвина хувьслын онолын үүднээс авч үзэх нь зүйтэй юм гэж бичсэн билээ. (4)

Манай дэлхий ертөнц, түүн дээр амьд амьтад бий болохоос хэдэн миллиард жилийн өмнө байсан органик биш ертөнц нь өөрийн мөнхийн хууль зүйгээр оршин тогтнож байсан нь дамжиггүй.

Газрын таталт, орсн зайн хуулиуд, газар дэлхийн орчим атмосфер ба түүний хийн найрлага бий болсон нь бүгд байгалийн зүй тогтоолд захирагдана. Гэтэл ертөнцийн мөнхийн хууль жамын явцад амьдрал ямар замаар орсон бэ, гадаад орчны ямар шинж чанар анхны амьд системд эхний сэрэхүй үүсгэхэд тулхэц өгсөн бэ гэсэн асуултуудаас П. К. Анохин өөрийн дэвшүүлсэн онолоо (4) эхэлсэн байна. Сэрэхүйн анхдагч хэлбэр бөгөөд түүний хөгжил хувьслын шийдвэрлэгч хүчин зүйл нь амьд амьтдын орчиндоо дасан зохицож амьдрах явдалтай шуд холбоотой юм.

Орчиндоо дасан зохицохыг өргөн ойлголтоор нь авч үзвэл амьд амьтад үүссэн цагаасаа эхлэн газрын таталтын хүч, дэлхийн орчны температур, агаарын хийн найрлага гэх мэтийн хүчин зүйлтэй зайлшгүй зохицон амьдрахыг хэлнэ. Дасан зохицлын хууль бол амьд бүхнийг хамрах түгээмэл хууль мөн бөгөөд энэ нь алдагдвал амьдрал зогсоно. Амьтдын улирэх хувьслын явцад эхлээд будуулэг сэрэхүй үүсч дараа нь аажмаар байгалийн шалгарлаар сэрэхүйн өндөр хөгжлийн үр дүнгийн бүтээгдэх үүн сэтгэхүй бий болжээ.

Анхны сэрэхүй ямар учраас хөгжив? Энэ бол юуны өмнө орчин тойрны түг түмэн нөхцөл дунд амьд систем оршин тогтнох уу, хөнөөгдөх үү гэдэг асуудалтай шууд холбоотой байв. Өөрөөр хэлбэл тэдгээр нөхцөлийн цочролууд амьд биед ашигтай юу, хортой юу гэдгээс амьдрал шийдвэрлэгдсэн байна. Амьд материйн энэ цоо шинэ чанар нь гадаад орчинос нөлөөлөх бүх хүчин зүйлийг таатай буюу тааламжгүй (хортой) гэсэн хоёр категоороор ангилах бололцоо олгосон байна. Уг хоёр чанар нь анхны эгэл бүдуулэг амьтнаас хүн хүртэл хөгжихдөө айх-зориглох, уурлах-инээх, гуних-хөөрөх гэх мэт сэтгэл хөдлөлийн дээд шатанд хүрчээ. Ингэж гадаад орчны хүчин зүйлүүд хортой буюу ашигтай болох нь энгийн амьтан түүнээс ч өмнөх биологийн бүдуулэг бүтцүүдийн анхны субъектив тусгал болсон байна. Анхны субъектив сэрэхүй бий болохын хамт амьтад гадаад орчинд дасан зохицох нь идэвхтэй хэлбэрээ олжээ. Тухайлбал, амьтад тохиромжтой температурын орчинд орших, хэт халуунаас зайлсхийн зугатаах мэтээр хортой эсвэл хэрэгтэй юмын дохио буюу цочролыг ялган салгах чадвартай болж улмаар хувьсал хөгжлийн шалгарлаар орчинд зохицоход ашигтай талууд нь хөгжиж, хэрэггүй нь устаж үгүй болж мөхсөн байна. Хүн ба дээд зэргийн хөгжилтэй амьтдын орчиндоо дасан зохицож амьдрах хэрэглүүр нь болзолн рефлексийн механизм юм.

И. П. Павловын нээсэн болзолн рефлексийн зарчим бол дээд мэдрэлийн үйл ажиллагааг судлах үндсэн арга нь юм. Болзолн рефлекс 2 чухал зарчим дээр суурилагдана. Үүний нэг нь дохиоллын зарчим, нөгөө нь бататгалын зарчим юм. Болзолн рефлекс болзолн төрөлхийн рефлекс дээр суурилагдах бөгөөд болзолн дохио (гэрэл, хонхны дуу) болзолн бус цочролоор (хоол) бататгагдсан хавсарч үйлчилдгээс шинэ рефлекс үүсдэгийг бид мэнээ. Амьдралын явцад шинээр үүссэн болзолн рефлекс олон удаа давтагдан бататгагдаж амьдралд хэрэгтэйгээ үзүүлж байх бөгөөд уул рефлексийг бататгахгүй бол тэр аяндаа замхарна. Дохиоллын зарим бие махбодыг ирээдүйн амьдралын үйлдэлд бэлтгүүлэх боломжийг олгодог онцгой ач холбогдол бүхий И. П. Павловын санааг П. К. Анохин бүтээлчээр хөгжүүлж „бодит байдлыг урьдчилан тусгах онолыг“ дэвшүүлсэн билээ.

П. К. Анохин „Бодит байдлыг урьдчилан тусгах“ онолыг нээснээр (4) философи, байгалийн шинжлэх ухааны хөгжилд дорвийт хувь нэмэр оруулсан юм. Энэ онолдоо амьд амьтдын оршин тогтоох ба хөг-

жин хувьсах үндсэн нөхцөл бол ертөнцийн үечлэн давтагдах үзэгдлийг урьдчилан тусгах чанар мөн гэсэн билээ. Урьдчилан тусгах онол нь амьдралын үүсэл хөгжлийг ирээдүйн цаг хугацааны категорийг холбож тайлбарласнаараа диалектик материализмын тусгалын онолыг байгалийн шинжлэх ухааны үүднээс улам баяжуулан гүнзгийрүүлсэн юм.

Орчин үеийн мэдээллийн онолоор (2,4) мэдээлэл дамжуулалт (амьд бие, техникт) нэн чухал хуульд захирагдана. Энэ хуулиар аливаа нэгэн мэдээлэл дамжихдаа түүний параметрүүд нь эхний болон эцсийн шат хүртэл яв цав тохирсон байх ёстой. Өөрөөр хэлбэл ямар нэгэн объектын параметрүүд нь их тархины гадарт хүрэхийн өмнө хичнээн ч мэдрэлийн бүтцүүдээр дайран боловсрогдож, дамжихдаа уг чанараа алдахгүй мэдээллийнхээ эквивалентыг хадгалахыг хэлнэ. Үүний үр дунд уг объектын жинхэнэ бодит үнэн зөв субъектив дур бүтнэ. Энэ үзэгдлийг техникийн талаас авч үзвэл телевизийн нэвтрүүлгийн ажиллагаатай адилтгаж болно. Объектын гадна, дур, дуу чимээний физик хэлбэлзлийн параметрүүд замдаа олон дахин өөрчлөгдөн хувирдаг боловч телевизийн дэлгэц дээр нэгдэн нийлснээс бодит үнэн зөвөөрөө гарна. Орчин тойрны төрөл бүрийн юмс ба үзэгдлийн тухай мэдээллийг (гэрэл, чимээ, температур, үнэр, хэл, яриа) бие махбод мэдрэхийн эрхтнээр хүлээн авч төв мэдрэлийн системд дамжуулна. Мэдрэлийн хүлээн авагчид (рецептор) нарийн зохион байгуулалттай аппарат бөгөөд тэрээр адекват (тохирсон) цочролуудад өндөр мэдрэг чанартай. Хүлээн авагчид гаднын цочруулын физик-хими механик энергийг мэдрэлийн сэргийн импульс (сэргийн түлхэлт) болгон хувиргаж объектын параметрийг өөрийн өвөрмөц зохиомол тэмдэгт шилжүүлэхийг мэдээллийг кодчиллох чанар гэнэ. (Код-нууцлуур). Ийм зарчмаар бие махбод одорчны юмс мэдрэлийн янз бүрийн шатанд эхлээд задлан тусгагдаж, дараа нь нэгтгэн дүгнэгдсэний үр дүнд тархины дээд хэсгүүдэд объектын дүр бүрдэнэ.

Объектыг параметрээр нь задалж тодорхойлох нь тусгалын онолын материаллаг чанарыг шинжлэх ухааны үндэслэлтэй ойлгох гол нөхцөл бөгөөд энэ утгаар ухамсар бол мэдээллийг хүлээн авч боловсруулах ба нэгтгэн дүгнэх дээд мэдрэлийн системийн интегратив үйл ажиллагааны үр дүн юм.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Г. Дашиевэг, Ц. Эрдэнэсамбуу. Тусгалын онолын нейрофизиологийн үндэслэл. „Үнэн“ сонин, 1976.
2. Симонов В. П. Потребностно-информационная деятельность мозга. Журнал высшей нервной деятельности имени И. П. Павлова, 1979, Т. 29- № 3.
3. Опарин А. И. Возникновение жизни на земле—М. 1957.
4. Анохин П. К. Теория отражения и современная наука о мозге М: Знание, 1970.

П. ОНХУУДАЙ

ГАММА КАМЕРЫН ОНОШИЛГОО

УЛСЫН ҚЛИНИКИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

Улсын клиникийн төв эмнэлэгт изотопын лаборатор 1975 онд байгуулагдаж тэмдэгт атом-изотопыг манай орны эрүүлийг хамгаалахын практикт анх хэрэглэж улмаар өвчнийг оношилж эхэлсэн юм. 1983 онд тус лабораторт цөмийн анагаах ухааны оношилгоо

ны иж бүрэн төхөөрөмж болох Гамма камерыг суурилуулан тавьж оношилгоо хийж байна. Гамма камераар оношилгоо хийж буй оронг дэлхий дээр тоолбол тийм ч олон бишээ. Түүгээр ч үл барам Ази тивд тсотой хэдхэн оронд байгаа юм. Энэ нь МАХН, засгаас ард түмнийхээ эрүүл энх, сайн сайхны төлөө хичнээн их анхаарал халамж тавьж байдгийн бодит илрэл юм.

Гамма камер нь иж бүрэн электроник систем бөгөөд өндөр мэдрэмтгий асар том талсттай, цөмийн анагаах ухааны оношилгооны гол аппарат, орчин үеийн цөмийн физик, электроникийн хөгжлийн ололт амжилтын илрэл мөн. Үйл ажиллагааны ба байршлын оношилгоог зэрэг явуулж чаддагаараа бусад клиникийн ямар ч оношилгооны аргаас давуугаараа онцлог юм.

Орчин үед тэмдэгт атом-изотопыг улс ардын аж ахуйн гол салбарууд, түүн дотроос ялангуяа эрчим хүч, геологи, уул уурхайн, микроэлектроник, хэмжих техникийн үйлдвэрлэл болон эрүүлийг хамгаалах, хөдөө аж ахуйн байгууллагад өргөн ашиглах боллоо.

Физик хими, электроник, инженер-электроник нь биологи, анагаах ухаантай хамтран цөмийн анагаах ухааны суурь болж өгдөг.

Цөмийн анагаах ухаан нь тэмдэгт атом-изотопоор хийгдэх онош зүй, эмчилгээ, судалгаа гэсэн 3 салбараас бүрдэнэ.

Цөмийн анагаах ухаан хөгжлийнхээ дөнгөж хоёр дахь арван жилийг өнгөрөөгөөд байна. Орчин үеийн цөмийн анагаах ухааны онош зүйг дотор нь тэмдэгт атомоо хүний бие махбодод оруулж шинжилгээ хийх үү, аль эсвэл оруулахгүй хийх үү гэдгээр нь инвиво, инвирто оношилгоо гэж 2 хуваана.

Онош зүйн аргын технологийн хувьд инвиво оношилгоог дурсэлдэг (байршлын) ба дурсэлдэггүй (үйл ажиллагааны) гэж ялгаж үздэг. Дурсэлдэг оношилгоог (хөдөлгөөнтүй) зураглах шинжилгээ ба (үйл явцтай) зураглах шинжилгээ гэж тус тусад нь авч үздэг.

Сүүлийн 10 жилд инвирто оношилгооны радио иммунологийн бичил анализын аргууд шинээр бий болов. Энэ нь хүний бие махбодод байдаг биологийн идэвхит бодисыг тодорхойлдог анагаах ухааны сүүлчийн үеийн онцгой ололтын нэг мөн. Ийм ч учраас түүнийг нээгчийн нэг Розалин Ялоу өнгөрсөн жил Нобелийн шагнал хүртсэн нь санамсаргүй зүйл биш билээ. Одоо 300 язын аргаар шинжилгээ явуулах боломжтой боллоо. Хэдэн жишигээг дурдвал, ЗХУ-д радиоиммунологийн шинжилгээг 1975 онд 400000 хүнд хийж байсан бол 1979 онд 1500000-аас даваад байна. 1990 он гэхэд ЗХУ-д 18—19 сая хүнд жил бүр цөмийн анагаах ухааны оношилгоо, эмчилгээ хийх болно гэж ЗХУ-ын Москва хотын эмч нарын мэргжил дээшлүүлэх институтын орлогч захирал профессор И. Л. Касаткин бичиж байна.

Гамма камер гэж юу вэ? Энэ тухай товч дурдья

Анагаах ухааны практикт хэрэглэж буй Гамма камерын эх үүсвэр болох сцинтиляцийн камерыг инженер Ангер 1952—1965 онуудад зохион бүтээж, клиникийн оношилгоонд шилжүүлж өгсөн байна. Аххны сцинтиляцийн камерыг Нуклеер Чикаго фирм 1965 онд үйлдвэрлэж түүнийгээ „Гамма камер“ нэрлэжээ. Орчин үед улам төгөлдөржин сайжирсан Гамма камерыг тооцон бодох машин-компьютертай үйлдвэрлэж байна.

Манай эмнэлэгт суурилуулан тавьсан Гамма камерыг (Сиймэнс) фирм үйлдвэрлэсэн ба энэ нь 45 см-ийн голчтой сцинтиляцийн талсттай 37 ширхэг фото электрон өсгөгчтэй юм.

Гамма камер төхөөрөмж нь үндсэн 3 хэсгээс бүрдэнэ. 1. Электрон тоолуур, 2. Удирдлагын систем, 3. Мэдээлэл боловсруулах, компьютер (ЭВМ) хэсэг.

Электрон тоолуур нь иж бүрэн, гол хэсэг бөгөөд фото электрон өсгөгчтэй (ФЭУ) сцинтиляцийн талст байх ба цацрагийг сонгон оруулах буюу тоолуурыг хамгаалах төмөрлөг бүрхүүлтэй байдаг. Зөвхөн электрон тоослууран хэсэг гэхэд хагас тонн жинтэй. Тэр нь тусгай тогтоогч баганад бэхлэгдсэн байх ба электрон тоолуурыг шинжилгээний үед янз бүрийн шаардлагатай зайд хөдөлгөх, эргүүлэх өөрийн мотортой зохион бүтээгджээ. Тоолуурын сцинтиляцийн дугуй талст нь голдуу 1,27 см зузаан, 26—45 см голчтой натри иодидоос бүтсэн байна.

Фото электрон-өсгөгч төхөөрөмж бүр дээр 19,37,61 ш г.м. янз бүр байна.

Электрон тоолуурт ирсэн цэнэгжүүлэгч цацраг нь фото электрон-өсгөгчөөр цахилгаан импульс (лугшилт) болж хувирч өөрчлөгддөг.

Гамма камерын чадал чансааг түүний электрон тоолуурын талстын голчийн хэмжээ, фото-электрон-өсгөгчийн тоогоор үнэлэн үздэг.

Электрон тоолуур нь удирдлагын систем, мэдээлэл боловсруулах компьютертай холбогдоно. Удирдлагын системд анализатор, дискриминатор, мэдээллийн импульс бүртгэгч болон хүний бие маҳбодын тодорхой хэсэгт тэмдэгт атом авагдахад түүний байдлыг дүрсэлсэн зургийг үзүүлэх дэлгэц зэргээс бүрдэнэ. Мөн социллоскоп, микродот байх ба тэдгээрийн туслалцаатайгаар фото ба гэрэлтэгч хальсан дээр (рентген хальстай төстэй) шинжлэгдэж буй эд эрхтэн, системийн зураг буудаг байна.

Фото зураг нь өнгөтэй, өнгөгүй байх ба агшин зуур 30 сек-д бэлэн болох чадвартай. Ямар ч фото-лабораторийн оролцоо шаардагдахгүй юм. Гэрэлтэгч хальс нь тусгай угаагч аппаратаар орж 2 мин-ийн дараа бэлэн болно. Фото ба гэрэлтэгч хальсан дээр нэгэн зэрэг зураг авч бслдог учир үйл ажиллагааны ба байршлын оношилгоог нэгэн зэрэг хийж болно гэсэн уг юм. Мөн удирдах системийн өөр нэг дэлгэц дээр шинжилгээний бүхий л явцыг нүдээр байнга ажиглаж байх боломжтой юм.

Гамма камер дээр хийж буй бүх шинжилгээний аргыг сцинтиграф гэж нэрлэдэг. Фото зураг буюу гэрэлтэгч хальсан дээр буусан тэрхүү дүрс зургаа сцинтиграмм гэнэ.

II. Гамма камераар юут шинжлэн оношилж болох вэ? Гамма камер нь хүний бие маҳбодын ямар хэсгийг, жишээлбэл ямар эрхтэн системийг шинжлэх гэж буй, түүний чухам юугий нь аль хэсгийт нь сонирхож буйгаас болон юу гэдэг изотопоор, хэдий хугацаанд хир хэмжээний, хэдэн зураг буулгаж авах зэргээс шалтгаалж доорхи үндсэн З аргаар шинжилгээт явуулна.

1. Байршлын буюу статик сцинтиграф
2. Үйл ажиллагааны буюу динамик сцинтиграф
3. Түргэн сцинтиграф

Өвчтөнд эхлээд тэр шинжлэх гэж буй эд эрхтэнд зориулагдсан тусгай изотопоо тарьж оруулна. Байршлын буюу статик сцинтиграф нь хүний бие маҳбодын шинжилж буй эрхтэний тэр байгаа төрх байдлыг зураг болон дэлгэцнээ үзүүлэх зорилготой. Онцлон хэлбэл тэр эрхтэн чухамхуу үнэн бодит байрлал, хэлбэр, хэмжээ болон түүний цуллагийн эмгэгийн нэвчимтгий ба голомтот байдлыг бараг (дотроос нь) харж байгаа юм шигээр дүрсэлдэг гэж ойлгож болно. Үйл ажиллагааны буюу динамик сцинтиграф нь хүний бие маҳбодод явагдаж буй тодорхой хэсгийн (удаавтар) үйл ажиллагааг сонгож авсан мөчид дэс дараалсан олон шат бүрээр зураг дээр буулгаж авах юм. Жишээлбэл: 30 сек-ээс хэд

хэдэн мин-ийн завсарлагатай хийж болно. Тэгэхдээ эрхтэнээ байгаа байдлаар нь байршил, хэлбэр, хэмжээг хамт дүрсэлдэг байна. Энд эрхтэний тухай тооны болсон чанарын үнэлэлт өгөх бөгөөд энэ нь тодорхой хугацаагаар хязгаарлагдаж явагдах шинжилгээний арга юм.

Түргэн сцинтиграф гэдэг нь хүний бие махбодод асар хурдан явагддаг физиологийн үйл явц, тухайлбал цусны эргэлтийн байдал, эрхтэнүүдийн цусан хангамж, зүрхэн дэх ховдол, тосгуурын ажиллагаа зэргийг шинжлэхэд зориулагдсан, тасралтгүй явагдах шинжилгээний арга юм. Энд голдуу 16—32 зураг авах ба шинжилгээний үр дүнг электрон тооцон бодох машинд хүлээн авч боловсруулдаг. Ер нь дээрх аргаар хийж буй шинжилгээний тухай мэдээллиуд, гамма камерын мэдээлэл боловсруулах компьютер-электрон тооцон бодох машинд очсоноор оношилгоо тавихад эмчид тухай бүрийд үнэлж баршгүй тусламж үзүүлэх болно. Бид одоогоор гамма камераар өлг, цөс, бөөр, бамбай ба нойр булчирхайн өвчинүүдэд үйл ажиллагааны ба байршилын оношилгоо хийж байна. Цаашид уушги, тархи, яс, зүрх, судас зэрэг эрхтэний өвчинийг оношилж эхлэх юм. Анагаах ухааны салбарын оношилгоо нь эмчилгээнээс түрүүлж явах үүрэгтэй бөгөөд энэ зорилгод ч цөмийн анагаах ухаан зохих хувь нэмрээ оруулсаар байгаа юм. Сүүлийн үеийн шинжлэх ухаан-техникийн ололт-микро электроник, тэмдэгт атом изотопыг манай орны эрүүлийг хамгаалахын практикт амжилттай нэвтрүүлж буй гэрч нь гамма камер болж байна. Мөн тус эмнэлэгт радиоиммунологийн ондөр нарийвчлалтай бичил анализын лаборатори мөдхөн нээгдэж өнөө үеийн электроникийн амжилт болсон хэмжих микроэлектроник, санах программтай микропроцессортойгоор ажиллах болно.

Цөмийн оношилгооны арга нь анагаах ухааны бүх салбарт асар хурдан нэвтэрч байгаа ба түүний ирээдүйд эмч, эрдэмтэд их найдлага тавьж байна.

Энэ бүхэн нь МАХН-ЫН XVIII их хурлаас... Эрүүлийг хамгаалахын практикт орчин үеийн анагаах ухааны цоо шинэ ололт, тэргүүн туршлагыг бүтээлчээр нэвтрүүлэх хэрэгтэй... гэсэн намынхаа заалтыг амьдралд хэрэгжүүлж буйн нэг жишээ билээ.

С СОНИН

ХЭТ АВИАГААР ОНОШЛОХ АРГА

(Хэвлэлийн той.)

АНАГААХ УХААНЫ ДЭЭД СУРГУУЛЬ

Сүүлийн 10-15 жилд хэт авиаагаар оношлох арга эмнэлгийн практикт амжилттай нэвтэрч, оношилгооны янз бүрийн аргын дотор чухал суурийг эзлэх боллоо. Энэ нь оношилгооны аппарат хэрэгсэл улам боловсронгуй болж, шинжилгээний үр дүнг боловсруулахад тооцоолон бодох электрон машиныг ашиглах болсонтой холбоотой юм.

Хэт авиааны сийсон долгионыг ашиглан дотор эрхтэнийг шинжлэх аргыг авиа-бичлэгийн арга гэж нэрлэнэ.

Хэт авиааг анх 1889 онд К. Кониг камертоны тусламжтайгаар гарган авчээ. Орчин үед пъезо талстыг ашиглан гаргаж байна. Энэ зорилгоор ихэвчлэн титанит циркони, титанит бари, кварц, керамикийн талстыг хэрэглэдэг.

Хэт авиаг оношилгооны зорилгоор анх 1942 онд австрийн эрдэмтэн ах дүү Дуссик нар тархины эмгэгийг оношлоход хэрэглэжээ. (1). 16000 гц-ээс их давтамжтай дууг хэт авиа гэнэ. Түүний орчинд тархах хурд нь долгионы урт ба хэлбэлзлийн давтамжтай шууд хамааралтай. Хүний биеийн зөвлөн эдэд хэт авианы тархах хурд нь ойролцоогоор 1540 м/с, ясны эдэд-3370 м/с байдаг. (2)

Оношилгооны зорилгоор ихэвчлэн 2,25 мгц хэлбэлзлийн давтамжтай, 0,6 мм долгионы урттай хэт авиа хэрэглэдэг. Нэг төрлийн эдэд хэт авиа нь шулуун шугамаар тархах ба хэрвээ долгион нь өөр өөр акустик эсэргүүцэлтэй хоёр орчны (эдийн) заагт хүрвэл (жишээ нь; элэгний эд болон элэгний доторхи судас, цөсний сувгууд, элэгний эруул эд болон элэгний доторхи хавдар, бэтэг гэх мэт) долгионы хагас нь эргэн ойж, үлдсэн хэсэг нь хугарна. Хэт авианы оношилгооны арга нь түүний хоёр орчны хилээс эргэж ойдог чанарт үндэслэгдэнэ. Пьеzo талст дундуур цахилгаан хүчдэл нэвтрүүлэхэд талст нь тэлэх буюу агшиж хэт авиа үүсгэдэг. Хэрэв хэт авианы эргэж ойсон долгион талст руу ирж мөргөн цахилгаан хүчдэл үүснэ. Хэт авианы оношилгооны аппарат нь хэт авианы долгионыг үүсгэн шинжилж буй эрхтэн руу цацуулж, эргэн ойсон долгионыг дахин цахилгаан хүчдэл болгон хувиргаж, осциллоскопын дэлгэцэнд эрхтэний дүрсийг гаргадаг. Хэт авианы нэг төрлийн эдэд тархах хурдыг мэдсэний үндсэн дээр шинжилж буй эрхтэний хэмжээ, түүнийг ойлгож буй биетийн хир зэрэг гүнд байгааг доорхи томъёогоор тодорхойлно.

$$S = \frac{c \cdot t}{2} \quad S - \text{долгионы эрхтэн хүртэл туулсан замын урт.}$$

$$t - \text{долгионы эрхтэнд хүрээд эргэн ойж ирэх хугацаа}$$

$$C - \text{хурд}$$

(долгион нь шинжилж буй эрхтэнд хүрэх замыг 2 дахин туулах тул 2-т хуваана). Оношилгооны зорилгоор хэрэглэж буй хэт авианы дундаж чадал нь 0,04 Вт/см² бөгөөд хүний эд эсэд хортой нөлөөгүй юм. Хэт авианы оношилгооны аргыг зүрх, элэг, цөсний хүүдий, нойр булчирхайн болон бусад дотор эрхтэн, эх барих эмэгтэйчүүд, нүд, бөөр, тархины өвчинүүдийг оношлоход өргөн хэрэглэж байна. Түүний оношилгооны аппаратыг ашиглан дотор эрхтэнийг З хэлбэрээр шинжилнэ. Үүнд; I. RT эрхтэний дүрс зүрх, амьсгалын хөдөлгөөнгэй хамт өөрчлөгднө.

2. В эрхтэний хөдөлгөөнгүй дүрс гарна. З. TM зүрхний булчин, хавхлагуудын хөдөлгөөнийг бичнэ. Орчин үед оношилгооны зорилгоор хэт авиаанаас гадна рентгенограф, цацраг идэвхт изотопын аргаар дотор эрхтэний дүрсийг гарган авч шинжилдэг. Дээрх хоёр шинжилгээг хийхэд цацраг идэвхт тuyaаг цацуулдаг бөгөөд өвчтөнийг шинжилгээнд урьдчилан бэлтгэх шаардлагатай. Харин хэт авианы шинжилгээ нь өвчтөнд хоргүй, зовиургүй, өвчтөнийг урьдчилан бэлтгэх шаардлагагүй бөгөөд богино хугацаанд шинжилж буй эрхтэний талаар илүү тодорхой мэдээлэл авдаг. Цацраг идэвхт изотопын шинжилгээгээр оношийг 72—90%-д зөв тавьж байна. (5). Цацраг идэвхт изотопын аргыг рентген шинжилгээтэй хослуулан хэрэглэхэд 90—92%-д онош зөв тавигддаг. (6). Тэгвэл хэт авиа хэрэглэснээр оношийн тохироо 98%-д хүрч байгаа юм. Энэ оношилгооны аргын тусламжтайгаар элэгний хавдар, уулинхай, буглааг 98%-д (7), цөсний чuluуг 97,7-98%-д (8, 9, 10) тус тус зөв тавьжээ. Судлаачдын үзэж байгаагаар дээрх З аргыг хослуулан хэрэглэх нь илүү ур дүнтэй ажээ. Хэт авианы оношилгооны аппарат нь хялбар ажиллагаатай поликлиникийн нөхцөлд мөн хөдөө орон нутагт зөөврөлөн хэрэглэж болох сайн талтай юм.

Эмнэлгийн практикт амжилттай нэвтэрч, үр дүнгээ өгч буй оношилгооны энэ аргыг манай орны эмнэлгийн практикт эрчимтэй нэвтрүүлснээр оношилгооны үр дүн улам сайжрах юм.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Исаков Ю. Ф., Гераськин В. И., Милехин А. П.. Дмитриенков Б. Н. "Хирургия" 1983. № 2, 40-44
2. Эльлинер И. Е. Ультразвук, физико-химическое биологическое действие. М, 1963
3. Мухарлямов., Н. М., Беленков. Ю. Н. Ультразвуковая диагностика в кардиологии М. 1981
4. Зарецкий. В. В., Бобков В. В., Ольбинская Л. И.. Клиническая эхокардиография М. 1979
5. Зубовский Г. А.. Гаммасцинтиграфия М, 1978
6. Ризаев М. Н., Мясник Б. Н., Миранов Д. М., Маликова З. М. "Хирургия". 1980, № 6. 75-77
7. Бабичев С. И., Скорунский И. А.. Давитадзе Ш. А., Хирургия, 1983, № 1 20-24
8. Кузин М. И.. Шкраб. О. С., Стручкова Т. Я. Хирургия, 1980, №1, 3-7
9. Милонов О. Б., Зарецкий В. В. Лебедева О. Д.. Хирургия, 1980, 6., 31-34
10. Фукуда Моримити Ультразвуковая диагностика заболеваний печени, желчного пузыря и поджелудочной железы. Саппоро. Япония, 1981.

Б. ОДОНХҮҮ

УУШГИНЫ ЦОЧМОГ ҮРЭВСЛИЙН ҮЕ ШАТ, ХҮНДРЭЛИЙН ЗЭРГИЙГ ТОДОРХОЙЛОХ, ЭМЧЛЭХ

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛЭГ

Сүүлийн 20 жилд сульфаниламид антибиотикийг эмчилгээнд өргөн хэрэглэх болсноор эмчилгээний практикт уушгины дэлбээг хамарсан эмнэл зүйн явц, шинж тэмдэг нь тодорхой үрэвсэл цөөрч, харин стафилакоккийн гаралтай голомтод үрэвсэл эмнэлзүйн явцаар хүнд; хордлогын шинж ихтэй үрэвслийн тохиолдол аль ч оронд ихэссэн тухай ном хэвлэлд олонтоо бичиж байна.

Уушгины цочмог үрэвслийн эмчилгээг цаг алдах, эмчилгээний зарчмыг буруу баримтлах зэргээс шалтгаалж, уушги хатуурэн сорвижих, улмаар халдварт харшлын гаралтай уушгины өвчин, гуурсан хоолийн багтраа зэрэг архаг хүнд явцтай өвчин олчиирч, эцэстээ уушги тэлэгдэх, сорвижих, уушги зүрхний ажиллагааны дутагдал болсноос, уг хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг их бага ямар нэг хэмжээгээр нэмэгдүүлнэ.

Эмчилгээ хангалтгүй болох нилээд шалтгаан байна. Энэ нь цаг алдаж оношлох, эмчилгээг хожуу эхлэх, эсвэл дутуу эмчлэх, шийдвэрлэх эмчилгээг зөв сонгоогүй, эмчилгээг эрт хасах, эмчилгээний явцад бактериологийн оношийн ач холбогдлыг анхаараагүй, антибиотик, химиийн бодисуудад микробын мэдрэг чанарыг тодорхойлоогүй, эмчилгээг таамаг байдлаар явуулж байгаа зэргээс микробын эмийн бодист дасах чанар ихсэж, цочмог үрэвсэл архагшин эдгэрэлт удааширч байна.

Эдгээр хүчин зүйлээс шалтгаалж уушгины цочмог үрэвслийг эмчлэх тактикийг боловсруулан мөрдэж ажиллах нь дээд, дунд аль ч мэртэгэжлийн эмч нарын анхаарвал зохих асуудал юм. Уушгины үрэвсэл эмгэг жамын тухайд ганцхан тухайн эрхтэний үйл явцаар тодорхойлоход бус, бүх эрхтэн системийг хамарсан эмгэг процесс явагддагийг анхаарах ёстой.

Иймээс уушгины цочмог үрэвслийн үйл явц, хүндрэлийн зэргийг дараах хүчин зүйлээр үе шат болгон авч үзэх нь зүйтэй.

1. Халдвартын идэвхжил
2. Эмнэлзүйн эмгэг илрэлийн тогтвортжилт
3. Эрхтэн системд явагдаж байгаа үйл ажиллагааны болон бутцийн хам өөрчлөлт

Эдгээрээс үндэслэн эмчилгээний төлөвлөгөөг боловсруулвал зохино. Халдвартын идэвхжилийг тухайн үед нь дараах түүний хорт үйлчлэлээс бие махбод эрхтэн системийг хамгаалахад антибиотикийг микробын мэдрэг чанараар зөв сонгож идэвхжүүлэгч эдийн эмчилгээний бодистой хослуулан хэрэглэх нь чухал.

Өвчин үүсгэгчийн хоруу чанарыг шөгөхгүй байх, дахин халдвар авч хурицааас урьдчилан сэргийлэхэд антибиотикийг өндөр тунгаар хавсрнуулан хэрэглэх нь чухал. Гэхдээ өвчиний явц үе шат, хүнд хөнгөний байдлаас шалтгаална. Үүний тулд бодит байдалд ойр дөт эмгэгийн хүнд хөнгөний зэргийг илтгэж чадах тийм магадлагаа тогтоож хэрэгжүүлэх нь зүйтэй.

Иймээс эмнэлзүйн илрэлийг иш татах амьсгалын тоо, судасны лугшилтын тоо, халуурлын хэмжээ, үрэвслийн процессын байрлал, хордлогын илрэл, явц зэргээс үндэслэн уушгины цочмог үрэвслийг явцаар нь хөнгөн, дунд, хүнд гэж гурван зэрэг болгон хуваана.

Хөнгөн хэлбэр

1. Амьсгал 1 минутанд 25-аас доошгүй
2. Судасны лугшилт 1 минутанд 90 орчим
3. Халуун 38 градус
4. Үрэвслийн процесс уушгинд нэг талдаа 1-2 сегмент хамарсан
5. Хордлогын илрэлгүй

Эмчилгээнд: Норсульфазол, сульфадимезини г ердийн тунгаар болон удаан үйлчилгээтэй сульфаметоксазон ба натрийн давс бүхий сульфадиметоксийн зэргийг эхний өдөр 2 г, цаашид 7-10 хоног 1 г-аар 4-6 цагийн зайдтай өгнө. Эмчилгээний үр дүн сайтай бэлдмэл бактрим эсвэл бисептол (энэ нь сульфаметоксазон ба триаметоприм юм)-ийг насанд хүрэгчдэд 2 шахмалаар хоногт 2 удаа, нийтдээ 5-12 хоног өгнө.

Үүнээс гадна уушгины цочмог үрэвслийн хөнгөн хэлбэрийн үед нитрофураны уламжлэл, фурагин, фуразолин зэргийг 0,12-оор хоногт 3-4 удга өгнө. Нэг курс нь 7-10 хоног. Дээрх эмууд (сульфаниламид) бисептол, нитрофураны бэлдмэлүүд (тохигохгүй буюу эхний 5 хоногт эмчилгээний үр дүн илрэхгүй бол пенициллин 300000-500000 нэгжээр 4-6 цагаар, стрептомицин 500000 нэгжээр 12 цагаар булчинд тарих ба эсвэл олеандомицин, эритромицин, оксациллин, метициллин зэргийн аль нэгжээс 1 сая нэгжээс багагүй тунгаар хэрэглэнэ.

Дээрх эмчилгээний зэрэгцээ ханиалга дарах, цэр шингэрүүлэн ялгаруулах, татах сорох рефлексийн үйлчилгээтэй болон өвчтөний өвчин эсэргүүцэн хамгаалах чадварыг дээшлүүлэх эмүүдийг хэрэглэвэл зохино.

Дунд зэргийн хэлбэр

1. Амьсгал 1 минутанд 30 орчим
2. Судасны лугшилт 1 минутанд 100 орчим
3. Эмгэг процес 1 талдаа 1 дэлбээ буюу 2 талдаа 1-2 сегментийг хамарсан
4. Халуун 39 градус
5. Хордлогын шинж нилээд тодорхой илэрсэн

Эмчилгээнд бактерийн эсрэг эмийн тунг нэмэгдүүлнэ. Пенициллин хоногт 2-3 сая нэгжээр удаан үйлчилгээтэй сульфаниламидын бэлдмэлүүдтэй хавсрнуулан хэрэглэнэ. Стрептомицин 500000 нэгжээр сигмамицин 500 мг, морбоциклин 200000 нэгж зэргээр 12 цагаар булчинд тарина.

Хүнд хэлбэрийн үед

1. Амьсгал 1 минутанд 40 орчим
2. Судасны лугшилт нэг минутанд 100-аас дээш
3. Эмгэг процесс нэг бүтэн дэлбээ буюу эсвэл нэг буюу хоёр талдаа хэд хэдэн сегмент гэмтсэн
4. Халуун 40 градус

5. Хордлогын илрэл гүнзгийрч, цусны бага эргэлт зогсонгитож хүчилтөрөгч дутагдаж эс, эд эрхтэний хийн солилцоо хямарна.

Эмчилгээнд Пенициллинийг 3-5 сая нэгжээр хоногт 2 удаа судсанд дуслаар хийж, цусан дахь пенициллины үйлчилгээг бууруулах-гүйн тулд 4 цагаар 300000-600000 нэгжээр булчинд тарина.

Гентамициныг 0,8-1 мг-аар 1кг жинд бодож хоногт 3 удаа булчинд тарина. Хүнд хэлбэрийн үед антибиотик эмчилгээг өндөр тунгаар хавсруулан хэрэглэх зарчмитай. Пенициллинийг канамицин, мономицин, гентамицин стрептомицин зэрэгтэй хавсруулан хэрэглэх ба харин тетрациклин эритромицин, олендомицин зэрэгтэй хавсруулан хэрэглэж болохгүй. Бактериологийн онош тавьж коккийн төрлийн микробоор үүсгэгдсэн ушшины үрэвсэлд тетрациклиний их тунгаар стрептомицнэтэй, протей энтерококкоор үүсгэгдсэн бол левомицетин ампициллин, гентамицин зэргийг ерийн тунгаар, ногооруулагч савханцараар үүсгэгдсэн бол гентамицин полимиксин зэргээр эмчлэх гэхчилэн төлөвлөнө.

Эмчилгээний зарчим зөв бол өвчтөний халуун буурч тав дахь хоногиос хэвээндээ орно. Антибиотик ихээр хэрэглэж байгаа үед мөөгөнцрийн өвчнөөс урьдчилан сэргийлж нистатин леворин зэргийг хэрэглэнэ.

Бактерийн эсрэг эмийг ихээр хэрэглэж байгаа үед A, C, R, B булгийн витаминуудыг эмчилгээнд хэрэглэх шаардлагатай. Мөн уургийн солилцоо хямардаг тул аноболитик бэлдмэлүүд (неробол, нероболил 5 мг-аар хоногт 2 удаа 2-3 долоон хоногт) хэрэглэнэ.

Харглаас сэргийлж гистамины эсрэг бэлдмэлүүд ба кортикостероидын даавар хэрэглэнэ. Преднизолоныг (ходоод гэдэсний шарх байхгүй бол) 15-20 мг-аар 7-10 хоног өгч цаашид тунг багасган барих тунгаар үргэлжлүүлж, үрэвслийн эсрэг идэвхтэй үйлчилдэг салицилат, реоприн, анальгин пиromидон зэрэг эмийг өгч байгаад хасна.

Иммун системийн урвалж чанрыг идэвхжүүлэх зорилгоор биологийн идэвхжүүлэгч (алое, фибс, шиллэг эд, плазм, пентоксил, амин хүчлүүдээс) хэрэглэнэ.

Цусны бүлэгнэлт ушшины үрэвсэлт өвчний үед ихэсдэг учир цусны дэлгэрэнгүй шингилгээний үндсэн дээр гепарин 5000 нэгжээр хоногт 3-4 удаа 7-10 хоногоос хэтрүүлэлгүйгээр хэрэглэнэ.

Хордлого тайлах зорилгоор гемодез, неокомпенсан бусад шингэнийг 250-500 мл-ээр судсанд дуслаар хийж, фуросемид, лазикс тиазидын булгийн шээлгэх эм өгнө.

Амьсгал, цусны эргэлтийн эрхтэний үйл ажиллагаанд дутагдал илэрч байвал зурхний түргэн үйлчлэлтэй гликозид строфантин, коргликон зэргээс гипертоник уусмал 40%-ийн глюкоз, 10% -ийн бромт натри, 40%-ийн уротропин зэргийн аль нэгтэй судсанд хийх ба манитол хэрэглэж болно.

Хийн солилцооны хямарлын үед хүчилтөрөгч эмчилгээг хэрэглэнэ, Харин цусны бүлэгнэлт сайнгүй бол дээрх эмүүдийг хэрэглэхгүй. Цэр шингэрүүлэн ялгаруулахаар 3-6%-ийн калийн иод тарваган шийр зэргийг өгнө.

Шүлтлэг утлага шаардлагатай. Татах, сорох, дүйвүүлэх рефлексийн эмчилгээний ач холбогдолтой дүнг бууруулан үзэж болохгүй. Хордлого арийлж халуун буураад эдгэрч буй үед физик эмчилгээ хийх нь бүрэн эдгэрэхэд ач холбогдолтой. Мөн энэ үед амьсгалын дасгал чухал үүрэгтэй. Ямар нэг хэмжээгээр архагшуулахгүйн тулд диспансерийн хяналтанд авах шаардлагатай.

АМЬСГАЛЫН ЭРХТЭНИЙ УРВАЛЖ ЧАНАРЫН АСУУДАЛД

АРДЫН АРМИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

Онолын иммунологийн хөгжил нь амьсгалын эрхтэнийг биений ерөнхий болон хэсэг газрын дархлалын үүднээс авч үзэх бололцоог олгоноо.

Амьсгалын эрхтэний урвалж чанар асар их бөгөөд ерөөсөө уушгийг иммуны нэг эрхтэн тэж үзвэл зохино. Энэ чанараар нь ч элэг, дэлүү, чөмөг мэтийн эрхтэнүүдтэй жишиж үзэж болох юм. Хувьсал хөгжлийн явцад бүрэлдэн тогтсон амьсгалын замын эрхтэний дархлан хамгаалах чанар нь бүтэц зохион байгуулалтын гүнзгий үндэстэй ажээ. Цагаан мөгөөрсөн хослойн шуурлийн нян хөнөөх чадвар нь зөвхөн салс гаргах, механик аргаар няяг зайлцулахаар хязгаарлагдах бус энэ шүүрэлд агуулагдах иммуноглобулин А-гийн шууд үйлчлэлтэй ихээхэн хэмжээгээр холбоотой юм. Бронхийн салст бүрхүүлийн хучуур эсүүдийн доогуур байрласан лимфоцитууд нь чухамдаа энэхүү А иммуноглобулиныг «үйлдвэрлэгч» В-ийн терлийн лимфоцит эс болох нь тогтоогдоо. Иммуноглобулин А нь бронхийн шүүрэл дэх бусад бодисын хамт нян болон вирусийг устгах үйлчилгээтэй. Харин бронхийн шүүрэл ба цусны ийлдсэн дэх иммуноглобулин А-гийн тодорхой шутэлцээ мэдэгдээгүй байна.

Бронхийн шүүрэлд иммуноглобулин M ер тааралддаггүй бол иммуноглобулин Г нь ялангуяа уушгины үрэвслийн үед ихсэх нь олонтоо. Амьсгалын замын төгсгөлийн хэсэгт орсон агаарыг „цэвэрлэх“ үүргийг цулцангийн макрофаг эс гүйцэтгэдэг. Амьсгалын эрхтэнүүдийн дархлал чанарт цулцангийн хучуурын суурийн мембранны болон үүний дотор байрласан лимфойд байгууламжууд чухал үүрэг гүйцэтгэдэг болох нь тогтоогджээ.

Ихэнх дархлалын процессын үед уг суурийн мембранны үндсэн бодис зузаардаг нь чухам лимфоцитуудын хуримтлалаас болдог. Зарим судлаач эдгээрийг T лимфоцит эсэд хамруулж байна.

Амьсгалын эрхтэний дархлал ба харшлын урвалж чанарт нөлөө бүхий нөгөө нэг хэсэг эс бол базофиль, эозинофиль, үүлэн бөөмт болон плазмоцит эс юм.

Бие махбод дархлан хамгаалах хэрэглэлүүдээ ингэж дайчлан ашиглах нь үрэвслийн бүхий л үе шатанд харилцан адилгүй байдаг. Дархлалын хариулт нь олон хүчин зүйлийн нийлбэр, харилцан шутэлцээний үндсэн дээр явагддаг. Үүсгэгчийн шинж чанар нь иммуны анхны хариултыг тодорхойлж өгдөг. Жишээ нь: микоплазм нь бронхийн шүүрлийг амархан гэтэлж суурийн мембранд очдог. Энэ үед бронхийн шүүрэлд A болон M иммуноглобулин ихэснэ. Уг M иммуноглобулин нь уушги, зурх, судасны эдийг гэмтээх чанар бүхий цус наалдуулагч мэтийн бусад эсрэг биесээс бүрэлдэн тогтсон байдаг.

Иймээс ч микоплазмаар үүсгэгдсэн хатгалгаатай хүмүүст зурх, судас, шээсний замын өвчний шинж илрэдэг нь санамсаргүй хэрэг биш бололтой.

- ? **Риносинцитигд** вирус Т—лимфоцитын тогтолцоог „ажиллуулж“ эхэлдэг. Ингэж нэг талаас бие махбодын, нөгөө талаас амьсгалын эрхтэнүүдийн дархлалын тогтолцооны харилцан уялдаа шутэлцээ нь үрэвслийн процесийн эцсийн дүнг тодорхойлогч болдог. Уушгини үрэвсэлт өвчинүүдийн хүндрэл болох архагчих, харшил үүсэх, аутоиммуну байдал зэргийг өвчтөний дархлалын тогтолцооны онцлог байдалтай холбож үзвэл зохино.

Уушгины эмгэгүүдийн үед В, Т лимфоцит, фагоцит, бусад комплементийг тодорхойлж байх нь зүйтэй.

В тогтолцоог иммуноглобулин болон гаммаглобулинээр, „хэсэг газрын“ дархлалыг цэрэн дэх иммуноглобулин А, Г болон макрофаг, плазмоцит эс үзэх замаар тодорхойлдог. Ингэж судлах нь байнга дахидааг буюу сунжуу явцтай үрэвсэлт процессуудын цаана үргэлж байдаг төрөлхийн буюу олдмол иммуно дутмагших байдлыг илрүүлэхэд туйлын ач холбогдолтой. Ийм нөхцөлд гаммаглобулин болон дархлалыг „сэдээх“ эмчилгээ хийх нь зүйтэй гэж үзэж байна.

Дархлалын Т тогтолцоог цэр болон цусанд байгаа энэ эсийн абсолют тоог гаргах замаар тодорхойлдог. Энэ тогтолцооны дутмагшлын үед дархлалыг тогтоо зорилгоор левомизол (декарис)-аар „хатгаж“ болох юм. Мөн бласттрансформациын сорилуудаар мэдэж болдог.

Фагоцитын байдлыг эхний үе шатаанд нейтрофилын тоогоор, мөн фагоцитын индекс, шүлтлэг фосфатазын харьцаагаар үздэг байна. Фагоцитын үйлдэл муудсан үед пентоксил, метиллурацилээр дэмжиж болох юм.

Д. АЛИМАА

БИЛИРУБИН

АНАГААХ УХААНЫ ХҮРЭЭЛЭН

Цөсний нөсөө болох билирубиниг анх 1864 онд нээжээ. Билирубин ихэвчлэн элэгний, эсүүдэд үүсдэг. Тодорхой хэлбэл чөлөөт билирубин элэгний кумферийн эсүүдэд, чөлөөт бус нь гепатоцитуудад үүсдэг байна. Цөсний хүчлүүдийн тусламжтайгаар билирубин ялгарч, цөсний хүүдийн рүү орно.

Цусны улаан цогцсууд 110—130 хоног амьдраад, чөмөг, элэг, дэлүү болон бусад эрхтэний торлог эсүүдэд (Ретикул эндотелийн) мөхөхөд, задралаар нь түүнд агуулагдагч гемоглобин чөлөөлөгднө.

Гемоглобин нь глобин гэсэн уураг ба гемийн 4 молекулаас тогтоно. Гемийн молекул хүчилтөрөгчтэй нэгдэх буюу түүнийг алдах чадвартай төмрийн атомыг агуулсан байдаг. Гем бол гемоглобини идэвхтэй хэсэг бөгөөд глобин түүнийг зөөвөрлөх үүрэгтэй. Төмрийн задралаар гемээс билирубин үүсдэг. Хоногт гемоглобини нэг илүү хувь буюу 7,5 г орчим нь задарч, түүний 1 г тутмаас 35 мг орчим, нийтдээ 260 мг билирубин ялгардаг.

Гемоглобини задралын үр дүнд үүсэх, ногоон өнгөтэй энэхүү нөсөөг вердоглобин, холеглобин, хуурамч гемоглобин гэх зэргээр нэрлэдэг. Цаашид энэ нь мөн л хувирч, бас л ногоон өнгөтэй цөсний нөсөө болох биливердин болно.

Түүнээс улаан шир өнгөтэй цөсний нөсөө-билирубин үүсч цусны сийвэнгийн бүрэлдэхүүнд орно. Энэ нь усанд уусдаггүй бөөрөөр ялгарч шээсэнд ордоггүй. Ван-Ден-Бергийн урвал шууд өгдөггүй учраас холбоот бус (чөлөөт), ул уусгагч, шууд бус билирубин гэж нэрлэдэг. Энэ нь тоссонд уусах шинж чанартай, бие маходод хортой, альбуминтэй нэгдмэл байдлаар цусаар чөлөөтэй эргэж байдаг. Энэхүү нөсөө элэгний эсүүдэд глюкуронилтрансфераза ферментийн нөлөөгөөр глюкурони хүчилтэй нэгдэж чөлөөт бус, (холбоот). уусгагч шууд билирубин үүсгэнэ. Энэ нь моно ба диглюкуронидаас бүрдэх бөгөөд диглюкуронид түүний 75—80%-ийг эзэлнэ. Элэгний хоргүйжүүлэх үйл ажиллагаа нь билирубини ийнхүү холбогдсоны үр дүнд хэрэгждэг билээ.

Энэхүү үүссэн билирубин бие махбодод хоргүй, тосонд уусдаггүй шинж чанартай. Харин усанд уусч, бэөрөөр ялгарч шээсний өнгийг хувиргана.

Ван-Ден-Бергийн урвалын дүнгээр билирубиныг шууд ба шууд биш гэж ялгадаг. Диазо-урвалж хийхэд шууд өнгө өгвэл Ван-Ден-Бергийн урвал эерэг буюу шууд билирубин гэнэ. Харин диазо-урвалж нэмэхэд шууд өнгө өгөхгүй, зөвхөн диазо-урвалжийг спиртэнд уусгасны дараа хийхэд түүнтэй урвал өгвэл Ван-Ден-Бергийн урвал сөрөг гэж тооцох буюу шууд бус билирубин байна гэж үзнэ.

Үүссэн холбоот билирубин цөстэй хамт нарийн гэдсэнд орно. Тэнд гэдэсний дегидрогеназа ферментийн тусlamжтайгаар уробилиноген болтлоо антижирна. Үүссэн уробилиноген агаарт гэрлийн нөлөөгөөр уробилин болж хувирдаг.

Билирубины бүтээгдэхүүнийг ерөнхийд нь уробилиноидууд гэж нэрлэдэг. Уробилиноидуудыг З бүлэгт хуваадаг. III уробилиноген хаана үүсдэг ямар ач холбогдолтой болох нь тодорхойгүй. Mash бага хэмжээтэй үүсдэг. Оношийн ач холбогдолгүйд тооцогддог.

Уробилиноидын II бүлэг (i-уробилиноген) бүдүүн гэдэсний дээд хэсэгт үүсч, түүний ханаар шимэгдэж элгэнд орно.

Уробилиногены I бүлэг (d-уробилиноген)—Стеркобилиноген бүдүүн тэдэсний доод хэсэгт үүсэх бөгөөд эргэн шимэгдэж V. portae-гоор дамжин элгэнд очих төдийгүй uv. haemorrhoidales-aар цусны их эргэлтэнд орж, бэөрөөр ялгарч шээсний өнгө хувиргана. Гэвч стеркобилиногены ихэнх хэсэг нь стеркобилин болон хувирч өтгөний хэвийн өнгө бүрдүүлэгч нөсөө болно.

Элгэнд уробилиноидууд задарч зарим нь цөсөөр дахин ялгарна. Шээсэнд тун өчүүхэн хэмжээний уробилиноидууд ордог.

Билирубиныг ийлдсэнд тодорхойлох янз бүрийн арга байдаг боловч тоо хэмжээг нь тодорхойлох хамгийн хялбар тохиромжтой өргөн хэрэглэгдэж байгаа нь Иендрашек Клеггорны арга юм.

Холбоот билирубин диазо урвалжтай ягаан өнгө үүсэхэд түүнийг ФЭК-д хэмжиж экстинкцийн хэмжээгээр түүний ийлдсэнд агуулагдах нийт хэмжээг олоход энэ арга үндэслэгджээ. Диазо-урвалж бол Диазо I (сульфанилын хүчил) ба Диазо-II (Азот хүчлийн натри)-ын холимог болох диазофенилсульфонын хүчил юм.

Холбоот (чөлөөт бус) шууд уусгагч билирубин диазо-холимогт ягаан өнгө үүсгэнэ.

Кофеины уусмал хийхэд холбоот бус (чөлөөт) шууд бус, үл уусгагч билирубин диссоциаци болж дараа нь диазо урвалж нэмэхэд ягаан өнгө үүсгэдэг. Энэ нь шууд ба шууд бус билирубини нийлбэр болох нийт билирубини хэмжээг илэрхийлнэ.

Нийт билирубинээс шууд билирубиныг хасч шууд бус билирубини хэмжээг гаргана. Нийт билирубини хэвийн хэмжээ 5,1—19 мкмоль/л. Үүнэг 75%-ийг шууд бус, үлдсэн 25% буюу 0,8—5,1 мк моль/л-ийг шууд билирубин эзэлдэг.

БИЛИРУБИНЫ ОНОШИЙН АЧ ХОЛБОГДОЛ Билирубин нь төрөл бүрийн шаралтыг ялган оношлоход чухал ач холбогдолтой.

1. **ГЕМОЛИТИК (ЦУС ХАЙЛАЛТЫН) ШАРЛАЛТ.** Ийлдсэнд чөлөөт билирубин ихэнэ. Шээсээр билирубин гарахгүй. Дэлүү томрох, цус багадаа, ретикулоцитууд олшрох шинкүүд илрэх бөгөөд харин элэгний үйл ажиллагаа алдагдахгүй хэвийн байдаг.

II. **ЭЛЭГНИЙ (ПАРЕНХИМАТОЗ) ШАРЛАЛТ.** Хурц ба архаг гепатитууд, элэгний хатуурал, цөсний замын үрэвсэлт өвчинүүдийн үед тохиолдоно. Өвчний анхны өдрөөс эхлэн элэгний үйл ажиллагааны сорилуудад өөрчлөлт илэрнэ. Холбоот билирубин давамгайлж ихэнэ. Шээсээр билирубин гарна.

III. МЕХАНИК ШАРЛАЛТ. Цөсний чулуу, нойр булчирхайн толгой, фатерийн хөхлөг, элэг, цөсний ерөнхий цоргын хавдрууд, түүний түгжрэл, цөс, нойр булчирхайн хорхойтох (гельминтоз) зэрэг өвчинүүдийн үед тохиолдоно. Цөсгүйжих (ахоли), шээсэнд уробилин илрэхгүй байх, холестерин ихсэх, дэлүү ул томрох зэрэг онцлогтой. Элэгний үйл ажиллагаа, өвчиний эхний 10—15 хоногт хэвийн байх боловч цаашид хямрана. Цөсний хүүдий томорч Курвуазье-ийн шинж илэрнэ.

Жильберийн (энгийн холеми), Мейленграхтын (хөвгүүд охидын түр зуурын шарлалт,) Дабин-Джонсны (архаг идиопатик шарлалт) роторын хам шинжүүдийн үед тус тус илрэх хоргүй хэлбэрийн шарлалт гэж бий.

Мөн элэгний янз бүрийн өвчин, ялангуяа вируст гепатитын төгсгөл, томуу, сальмонеллез болон бусад халдварт өвчин, цөсний замын өвчинүүдийн улмаас болох гепатитууд, хордлогын улмаас болох элэгний гэмтэл, элэгний архаг үрэвсэл зэрэг өвчиний үед хоргүй хэлбэрийн энэхүү шарлалт түр зуур тогтмол биш илрэх явдал бий. Эдгээр хоргүй хэлбэрийн шарлалтын үед ийлдсэнд чөлөөт билирубин давамгайлж ихэсдэг нь элэгний эсүүдийн үйл ажиллагаа алдагдсантай буюу эсвэл глюкоронилтрансфераза ферментийн дуталтай холбоотой. Энэ үед нийт билирубины хэмжээ бага зэрэг ихсэвч 50 мкмоль/л-ээс төдийлөн хэтэрдэггүй онцлогтой. Бас төрсний дараах эхний 10 хоногт нярай хүүхдийн элэгний эсүүдийн глюкоронилтрансфераза фермент идэвхжиж хараахан гүйцээгүй байдагтай холбоотой илрэх нярайн гемолитик шарлалт гэж бий.

Үүнээс гадна Криглер-Наджарын хортой хэлбэрийн шарлалт гэж байдаг. Элэгний эсүүдэд глюкоронилтрансфераза фермент байдаггүй учраас энэ хэлбэрийн шарлалтын үед ийлдсийн билирубин хэт ихэсч бие махбод чөлөөт билирубинд хордож өвчин үхлээр төгсдөг жамтай.

Гемолитик шарлалтын үед хэдийгээр дээрх шинж илрэвч оношлоход амаргүй тохиолдол цөөнгүй байдаг. Тэрээр цөсний хүүдийд чулуу үүссэндийн улмаас болох механик шарлалттай хавсран тохиолдох явдал бий. Мөн түүнийг цөсний гаралтай элэгний анхдагч хатуурлаас, элэг хатууралгүй, төдийлөн томроогүй байдлаар нь ялган оношлох хэрэгтэй.

Элэгний ба механик шарлалтыг хооронд нь ялган оношлох нь практикт тохиолдох амаргүй асуудлын нэг. Элэгний шарлалтын ид үед цөсний жижиг цоргууд тагларсны улмаас элэгний дотор цөсний зогсонгишрол болдог. Механик шарлалтын бас ид үед элэгний паренхим гэмтэж элэгний үйл ажиллагааны дутагдлын шинжүүд илэрдэг. Иймээс энэхүү 2 хэлбэрийн шарлалтыг хооронд нь ялгахын тулд элэгний үйл ажиллагааг өвчиний эхний 10 хоногт шинжлэх шаардлагатай. Энэ үед элэгний үйл ажиллагааны хямрал илэрвэл элэгний шарлалт, эс илэрвэл гемолитик шарлалт гэж үзнэ.

Үүний дараа шарлалтын гарал үүслийг харгалзаж ялган оношлолтыг үргэлжлүүлнэ. Элэгний шарлалт элэгний үрэвсэлт өвчиний улмаас болов уу, аль эсвэл хатуурлаас уу гэдгийг ялгах хэрэгтэй. Дохиур хэлбэрт хуруу, судасны одонцорууд, улаан толбууд, удаан үргэлжлэх шар, хатуу элэг зэрэг нь элэгний билиар хатуурлын шинж юм.

Механик шарлалт голдуу чулуу, хавдар, хааяа цөсний ерөнхий цорго түгжирсний улмаас болдог тухай дээр өгүүлсэн билээ. Ийм өвчтөн/үдэд элэгний өвчиний зовиур илэрч болно. Тэд гэнэтийн хүчтэй өвдөлтөнд нэргэдэх цюултай юм. Цөсний хүүдий тэмтрэгдэхгүй боловч цөсний цэгүүдэд өвдөлт илэрнэ. Нойр булчирхайн толгойн хорт хавдрын улмаас үүссэн механик шарлалтын үед 12 хуруу гэдсэнд орох түүний фермент гаатах учир цусанд диастаза, липаза ферментүүд ихэс-

нэ. Энэ үед рентген зураг авч нарийн гэдэсний эргэж мушгирсан цагираг илрүүлэх нь ялгах оношийн маш их ач холбогдолтой. Мөн хуурамч шарлалт (жишээлбэл акрихины) гэж байдаг. Энэ үед нүдний салст шарладаггүй онцлогтой.

Ц. ЖАМБАЛДОРЖ, Х. ГЭЛЭГЖАМЦ

БРОНХОФИБРОСКОПИЙН ШИНЖИЛГЭЭ, ЭМЧИЛГЭЭНИЙ АРГА

УЛСЫН КЛИНИКИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

Манай орны цаг уурын эрс тэс нөхцөл, хүн амын суурьшил, үйлд вэржилт болон амьсгалын зам, уушгины эмгэгийг цаг алдаж хожуу, дутуу эмчлүүлэх зэргээс болж уушгины өвөрмөц бус архаг үрэвсэлт өвчинүүд ихэсч, түүний оношилгоо эмчилгээний асуудал чухлаар тавигдах боллоо. Анагаах ухааны хөгжлийн одоогийн түвшинд өвчний оношилгоо эмчилгээнд шинжилгээний цөөн тооны хэвшмэл аргыг хэрэглэх нь хангалтгүй болж орчин үеийн чухал хэрэглүүр болсон эндоскопийн болон эд эсийн шинжилгээний аргыг хавсран хэрэглэснээр оношилгоо эмчилгээнд чанаарын дэвшил гарч байна. Сүүлийн хэдэн жилд манай орны төвлөрсөн эмнэлгүүдэд эндоскопийн болон эд эсийн шинжилгээний аргудыг өргөн хэрэглэх боллоо. Үүний нэг нь уушгины өвчний эмчилгээ сношилгоонд хэрэглэж байгаа бронхофиброскопийн арга юм. Бронхофиброскоп гэдэг нь (*rhino -*уян хатан, *broncho -*гуурсан хоолой, *Scopi -*харах) гуурсан хоолой дурандаж харах гэсэн утгатай уг юм. Манай эмнэлгүүдэд Япон улсад үйлдвэрлэсэн “ОЛИМПИАС” маркийн аппарат хэрэглэж байна. Энэ аппарат нь гэрэл уүсгэгч дуран хоёроос бүрдэх бөгөөд хaa ч авч явахад боломжтой юм. Шинжилгээ эмчилгээнд өвчтөнг бэлтгэхдээ өлөн байлгах ба шинжилгээ эхлэхээс 20—30 минутын өмнө өвчтөнд промедол 1%—1 мл, атропин сульфат 0,1%—0,5—1 мл, димедрол 1%—1 мл булчинд тарина. Өвчтөнд урьдчилан дикаины тохироо үзсэн байх шаардлагатай. Бронхоскопийн шинжилгээг ерөнхий ба хэсгийн мэдээ алдуулалттай хийнэ. Хэсгийн мэдээ алдуулалтад 1—2 хувийн дикаины уусмал, 10 хувийн новоканины уусмал тус тус хэрэглэнэ. Эдгээр уусмалын хэрэглэх хэмжээ нь хувь хүний онцлог, нас, хүйс, жин, биеийн байдал, өвчний явцаас хамаарч янз бүр байна. Ерөнхий мэдээ алдуулалтыг бага насын хүүхэд, шинжилгээнээс айж байгаа өвчтөн, хэсгийн мэдээ алдуулах эмийн зүйлс тохирохгүй өвчтөн, шинжилгээ эмчилгээг удаан хугацаагаар хийх онцлог тохиолдолд тус тус хэрэглэнэ.

Үг шинжилгээг өвчтөнийг суугаа буюу хэвтээ байрлалд хийх ба үргэлжлэх хугацаа нь шинжилгээ эмчилгээний шаардлагаас болж 30 минутаас 2 цаг хүртэл байж болно. Бронхоскопийн шинжилгээг оношилгооны, эмчилгээний, урьдчилан сэргийлэх гэж 3 хуваана.

1. ОНОШИЛГООНЫ БРОНХОСКОПИ НЬ амьсгалын зам, уушгины өвчний оношилгоонд чухал хэрэгтэй. Ялангуяа гуурсан хоолойн эмгэгийн байрлал, шинж чанар, тархалтыг мэдэх, тэрчилэн уушгины зах хязгаарын хэсгүүдэд байрлаж байгаа эмгэгийг дашрамын шинж тэмдгээр нь илрүүлэх зорилготой юм. Оношилгооны бронхоскопийг мөгөөрсөн ба гуурсан хоолойн хавдар, гуурсан хоолойн гэмтэл, гаж хөгжил, сүрьеэ, уушгины өвөрмөц бус үрэвсэлт өвчинүүд, гуурсан хоолойн болон уушгины архаг үрэвсэл гуурсан хоолойн тэлэлт, уушгины буглаа,

уушгины цус алдалт, цустай ханиалгах, гуурсан хоолойн багтраа, үүсгэгч нь тодорхой бус уушгины өвчинүүдийн үед хийнэ. Оношилгооны бронхоскопийг дараах үе шатаар явуулна. Үүнд:

1. Нүдээр харж эмгэг процессын байрлал, тархалт, шинж чанар, гуурсан хоолойн хэлбэр, үйл ажиллагаа, шинж тэмдгийг тодорхойлох.

2. Эмгэг хэсгээс эд эсийн шинжилгээ авах.

3. Гуурсан хоолойн доторхи цэр, салс, идээнээс бактериологийн шинжилгээ шинжлэх.

4. Мөөгөнцөрийн шинжилгээ авах

5. Бронхоскопийн шинжилгээг бронхографийн шинжилгээтэй хавсран хийх зэрэг болно.

Оношилгооны бронхоскопийг зүрхний шигдээс, зүрхний титэм суудасны дутагдал, цус эргэлтийн алдагдал бүхий зүрхний гажиг, зүрхний хэм алдагдал, цусны даралт ихдэх өвчний II, III үе, амьсгалын дээд замын хурц халдварт өвчинүүд болон биеийн ерөнхий байдал хүнд үед хийхгүй.

II. ЭМЧИЛГЭЭНИЙ БРОНХОСКОПИЙГ уушгины архаг идээт өвчнүүд, гуурсан хоолойн багтраа өвчний эмийн эмчилгээнд үр дун өгөхгүй байгаа угдрэлт, уушгины цус алдалт, сурьеэ, гуурсан хоолойд гадны биет орох, уушгины бусад өвчний үед өргөн хэрэглэж байна. Энэ эмчилгээ нь гуурсан хоолойн доторхи зүйлийг соруулж цэвэрлэх, эмийн бодисыг эмгэг хэсэгт шууд хийх зорилготой юм. Ингэснээрээ эмийн үйлчлэлийг уртасгах, өвчний голомтод шууд үйлчлэх эмийн хэмжээг ихэсгэх, эм хэмнэх зэрэг сайн талтай юм. Эмчилгээний бронхоскопийг дараах үе шатаар явуулна. Үүнд:

1. Гуурсан хоолойн дотор тэлыг харж эмчилгээний тактик боловсруулах.

2. Гуурсан хоолойн дотор байгаа цус, цэр, салс, идээг соруулж цэвэрлэх

3. Гуурсан хоолойг антисептик уусмалаар угаагаад соруулж авах.

4. Эмгэг үүсгэгч нянгийн мэдрэг антибиотик буюу бусад шинж тэмдгийн эмчилгээний эмийг шууд хийх

5. Эмчилгээ бүрийн эхэнд гуурсан хоолойноос нянгийн шинжилгээ авах ба эмчилгээний үр дүнг харж тогтоон. Эмчилгээний бронхоскопи нь өвчний явцаас хамаарч яз бүр байх ба идээ ихтэй үед 2—3 хоногт 1 удаа, идээ цэр багатай үед 4—5 хоногт 1 удаа хийнэ. Нийт 3—8 удаа хийхэд дунджаар 1 курс эмчилгээ болдог. Эмчилгээнд хэрэглэх эмүүдийг нянгийн эсрэг цэр, идээ хайлуулах, үрэвслийн эсрэг гуурсан хоолой өргөсгөх гэж хуваана.

III. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БРОНХОСКОПИ НЬ уушгинд мэс заслын эмчилгээ хийхэд бэлтгэж гуурсан хоолойг цэвэрлэх, мэс заслын дараа хүндрэлээс сэргийлж бронхоскопи хийхийг хэлнэ. Энэ нь мэс заслын эмчилгээний үр дүнг сайжруулах, эмчилгээний дараа гуурсан хоолойд байгаа цэр, салс, цусыг соруулж цэвэрлэх, мэс засал хийсэн хэсгийн байдлыг хянах зорилготой юм.

Улсын клиникийн төв эмнэлэгт 1981 оноос эхлэн бронхоброскопийн эмчилгээ оношилгооны аргыг хэрэглэж одоогоор 400 гаруй өвчтөнд хийсэн нь эмчилгээ оношилгооны сайн үр дүнтэй болж байна.

ЛАБОРАТОРИЙН АЮУЛГҮЙН ДҮРЭМ

Удиртгал. Бичил амь судлалд аюулгүйн арга хэмжээг хангах талаархи ДЭХБ-ын тусгай программд лабораторийн ажилтан, ажилчдын эрүүл мэндийг хамгаалах, хүн ам, гадаад орчныг бичил биетэн болон судалгаа шинжилгээнд хэрэглэдэг биологийн халдварт материалыар са-

намсаргүй бохирдуулах аюулаас сэргийлэхийн тул лабораторийн аюулгүй байдлыг хангах хэм хэмжээг боловсронгүй болгон хөгжүүлэх шаардлагатайг онцлон заасан байна.

1. Тодорхойлолт:

1.1. Лабораторт мөрдөх шаардлагыг хязгаагүйгээс гарах аюулыг учруулах хор нөлөөнөөс нь хамаарч 4 бүлэг болгон хуваана.

1. Хувь хүнд өөрт нь болон нийгэмд хор багатай аюул.

2. Хувь хүнд дунд зэргийн хортой нийгэмд хязгаарлагдмал хор хүргэх аюул,

3. Хувь хүндээ хор ихтэй, нийгэмд бага хортой аюул

4. Хувь хүнд ч, нийгэмд ч хор ихтэй аюул

1.2. Институт ба лаборатори.

1.2.1. Лабораторийн өрөөнүүдтэй нэг буюу хэд хэдэн барилга байгууламжийг институт гэх бөгөөд энэ нь дотроо албаны өрөө, номын сан, эмч ажилчдын өрөө тасалгаатай байн.

1.2.2. Зөвхөн бичил амь судлалын буюу бусад шинжилгээ судалгааны ажилд зориулагдсан нэг буюу хэдэн өреөг лаборатори гэнэ.

1.2.3. Бичил амь судлалын үүсүүлэлт. Гэдээд орчныг санамсаргүй буюу санаатайгаар нянггаар бохирдуулах элдэв шалтгаанаас болж хүн амьтын сиед хэлдвэр үүснэ. Хэлдвэр нь амьсгалын зам, гэдээс ходоолны зам, гэмтээн буюу гэмтээгүй цэвэртэй салбараар нэвтэрч болно. Лабораторийн үүсүүлэлт нь шууд мэдэгдэх буюу мэдэгдэхгүй байсаар нийлээд хожим үлрэх ч байдаг. Энэ тохиолдолд лабораторт эмгэгтерэгч нян түүний хор хүн сиетэйд хэлдвэрлэж (амьсгалын болон хоол боловсруулах замаар) улмаар гэдээд сирынг Сохирдуулахад хүрч буй явдлыг лабораторийн үүсүүлэлт гэж сийлгено. Энэ нь лабораторийн үүсүүлэлт дурмийг өөрчссенээс, багаж техникин гэмтээ болон хэлдвэрлүүлсан амьтэн, үе хөлтнийг алдсанас болж үүснэ.

2. Аюулгүйн зөхион байгуулалт.

2.1. Үүрэг. Бүх төрлийн аюулгүй байдлыг хангах үндсэн үүргийг институтын захидал хүлээнэ. Лабораторийн аюулгүй байдлыг бусад мэргэжилтэнд хариуцуулж ажиллуулж бслох боловч үндсэн үүргийг захидал хариуцна.

2.2. Биологийн аюулгүй байдлыг хянаагч. Энэ нь институтын захирын нэрийн өмнөөс үүрэг гүйцэтгэгч хүн юм. Зохих хэмжээний мэдлэг мэргэжилтэй аюулгүйн байцаагч энэ үүргийг гүйцэтгэж болно. Нян судлалын өргөн хэмжээний шинжилгээ хийдэг, байгууллагад орон тооны аюулгүйн байцаагч байх нь чухал.

2.2.1. Аюулгүйн байцаагч нь тухайн байгууллагад ажиллаж буй хүмүүсийн ажлыг хортой аюултай эсэхэд үнэлэлт өгөхийн хамт хамгаалах төхөөрөмж, үйл ажиллагааны байдлыг нь шаардлага хангаж буй эсэхэд үнэлэлт өгнө.

2.3. Аюулгүйн зөвлөл. Институтын хэмжээнд аюулгүйн зөвлөлийг байгуулах хэрэгтэй бөгөөд энэ зөвлөл нь аюулгүй байдлыг хангах чиглэл, ажлын төлөвлөгөөг институтын захирагаанд танилцуулж хэрэгжүүлэхээс гадна аюулгүйн дурмийг боловсруулж лабораторийн үйл ажиллагаан дахь аюулгүй байдлыг хянана.

2.4. Аюулгүйн дүрэм. Аюулгүйн дүрмийг бүх ажилтан ажилчид болон гаднаас ирж ажилласгадаа унишиж гарын үсэг зурсан байна.

2.5. Гэнэтнийн аюул, яаралтай авах арга хэмжээ.

2.5.1. Бичил нянгийн улмаас үүссэн үүсүүлэлт нь аюулгүйн байцаагчид яаралтай мэдээлнэ.

2.5.2. Халдвартай нян асгарах, агаараар тархах, харилдуурын гэмтлээс болж босхирдуулах, тариагаар хэлдвэрлах болон санамсаргүй 69

залгих зэрэг яиз бүрийн штлтгаанаар уусч болох аюулын үед яаралтай үзүүлэх анхны тусламж болон эмнэлгийн арга хэмжээг боловсруулна.

2.5.3. Лабораториудэд яаралтай авах арга хэмжээг бэлтгэж протоколыг ажилчдаар уншуулж гарын үсэг зуруулсан байна.

2.5.4. Гал түймэр, үер болон бусад золгүй тохиолдлын үед авах арга хэмжээг боловсруулсан байна.

3. Эрүүл мэнд, эмнэлгийн хяналт. Ажилтан ажилчдын эрүүл мэндийн байдал нь эрхэлсэн ажилд шууд хамаатай бөгөөд эрүүл мэндийн шаардлага хангаагүйгээс бусдын эрүүл мэндэд аюул учруулах талбий. Хүүхэд төрүүлэх настны эмэгтэйчүүдийг болзошгүй аюулаас сэргийлж жирэмсэн үед нь халдварт нянтай ажиллуулахгүй байх хэрэгтэй.

3.2. Шаардагдах эмнэлгийн хяналтыг явуулна. Үнд:

- Лабораторийн аюулаас хамгаалах хэрэгслэлээр х нгах
- Лабораторт тохиолдсон золгүй явдалтай холбоотой эмнэлгийн асуудлыг шийдвэрлэх.

3.3. Эмнэлгийн хяналтанд хамрагдах зүйлс.

- Эмнэлгийн төлөвлөгөөт үзлэг
- Золгүй тохиолдлын бүртгэл
- Чөлөөт хуудас

3.4. Лабораторийн ажилнуудэд тэдний хариуцан ажиллэдаг нянтай холбоотой ийлдэс судлалын шинжилгээг үе үе хийж байх ёстой. Маш халдвартай нянтай ажилладаг ажилчдад тусгай карт олгох нь зүйтэй. Учир нь өвчилсөн үедээ энэ картыг эмчдээ үзүүлж тэр эмч лабораториос халдах халдвараас сэргийлэх арга хэмжээ авах юм.

3.5. Лабораторийн ажилтан ажилчдад шаардлагатай үед нь вакции тарих буюу бусад урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

4. Ажилтан, ажилчдыг аюулгүй арга хэмжээнд сургах.

4.1. Ажилтан ажилчдыг сургаж бэлтгэх нь лабораториос халдаж болох аюулаас сэргийлэх үндсэн зүйл юм. Халдварт эмгэгтөрөгч нянтуй халдвараас сэргийлэх талаар үе үе курс хийж байх хэрэгтэй.

4.2. Аюулгүй арга хэмжээнд сургах программ нь ажилтан ажилчдын ажил мэргэжлийн түвшинд тохирсон байна.

4.3. Аюулгүйн практикт хэрэглэх, ажилчдыг сурган бэлтгэхэд зориуулан гарын авлага гаргасан байна.

4.4. Ажилтан ажилчдыг химийн бодис болон радио идэвхт бодис соор хордсон тохиолдлыг мэддэг, түүний эсрэг арга хэмжээ авч чаддаг болгох.

5. Эрүүл ахуй.

5.1. Лабораторийн эрүүл ахуй шаардлагын хэмжээнд хүрч байгаа эсэхийг хянана.

5.2. Ажилтан, ажилчид лабораторт ажиллах бүхий л хугацаанд зориулалтын хувцас өмсвөл зохино.

5.3. Лабораторт юм идэх, уух, тамхи татхыг хориглоно.

5.4. Лабораторт урвалж, аливаа бодисыг амаар сорохыг хориглоно.

6. Техникийн аюулгүй байдал.

Лаборатори бүрийн үйл ажиллагаанд нэвтэрсэн шинжилгээний арга ажиллагаа нь аюулгүй байдлыг дээд зэргээр хангасан байвал зохино. Эдгээр арга нь хорт бүтээгдэхүүн үүсгэх, амьсгалаар халдварлах аюулыг аль болохоор бага байхаар зохиогдсон байна.

7. Халдварт хаягдлыг хадгалах, устгах.

Бүх халдвартай материал, бохирдсон багаж хэрэгслийг институтийн зориулалтын байранд нь ариутгаж, халдвартай болтол нь байлгана.

8. Тоног төхөөрөмжийн аюулгүй байдал.

Лабораторийн тоног төхөөрөмж нь ажилтан ажилчдын болон орчны аюулгүй байдлыг бүрэн хангасан байх ёстой. Тоног төхөөрөмж нь агаараар халдвар тарах нөхцөлийг аль болох бага байхаар угсралдана.

9. Туршилтын амьтны нөхцөл.

9.1. Энэхүү дүрмийн түрүүчийн бүлгүүд нь лабораторийн амьтны нөхцөлд нэгэн адил хамаатай.

9.2. Туршилтын амьтдыг хэрэглэгч нь эдгээр амьтдыг сайтар арчлах үүрэгтэй.

9.3. Туршлагын амьтдын байр нь тусдаа байх шаардлагатай бөгөөд хэрэв лабораторий хамт бол тусгаарлагдсан байвал зохино. Амьтдын байранд энгийн хүмүүс орж гарахыг хориглоно. Амьтны байранд мэргэгид, уе хөлтөн извтрэн орох боломжийг хаасан байх ёстой.

9.4. Туршлагын амьтны байранд орж гараадаа лабораторт өмсдөг гутал хувцсаа солих хэрэгтэй. Хамгаалах хувцас, бээлий, нүүрний болон амны хаалт хэрэглэж ажиллах хэрэгтэй. Далд хэлбэрийн халдварт хөдгэлэгч зэрлэг мэргэгид, сармагчин зэргээс хүнд өвчин халдах аюултай.

10. Лабораторийн төхөөрөмж.

Шаардлага хангасын лабораторийн төхөөрөмж, тохилог тоноглол, зориулалтын аюулгүй багаж хэрэгслэл нь лабораторийн ажлыг чанартай гүйцэтгэх, лабораторт гарч болзошгүй гэнэтийн аюулыг багасгах ач холбогдолтой.

11. Лабораторийн зааг.

11.1. Үүнд нэг, хоёрдугаар зэргийн аюул үүсгэж болох материалыудтай ажилладаг лабораториуд багтана. Лабораторийн эмч нар туслах ажилчид, яаралтай тусламжийн групп орохыг зөвшөөрнө. Энгийн хүн ам хяналтын дор нэвтэрнэ.

11.2. Өндөр хяналтын дор ажиллах лаборатори.

Гуравдугаар зэргийн аюул учруулж болох материалтай ажилладаг лаборатори юм.

а. Нарийн мэргэжлийн хүмүүс ажилланцаа.

б. Биологийн аюулгүй байдлыг хянагчадаас хариуцаж халдвартай материалыг халдвартайжүүлж ариутгасны дараа туслах ажилчид нэвтрэхийг зөвшөөрнө.

в. Яаралтай тусламжийн групп хяналтын дор нэвтэрнэ.

11.3. Дээд зэргийн хяналтанд байх лаборатори.

Дөрөвдүгээр зэргийн аюул учруулж болох материалтай ажилладаг лаборатори үүнд багтана.

12. Халдвартай буюу халдвартай байж болзошгүй материалыг тээвэрлэх, хүлээн авах.

12.1. Халдвартай материалыг тээвэрлэхдээ орон нутгийн шуудангийн газар болон Дэлхийн шуудангийн холбоо, Олон улсын агаарын тээврийн нэгдлээс зөвшөөрсөн дүрмийн дагуу савлаж баглавал зохино.

12.2. Халдварт материалыг савлаж баглах, задлах, зэргийг зөвхөн мэргэжиж дадлагажсан хүнээр гүйцэтгүүлнэ.

Англи хэлнээс орчуулсан Э. Пүрэвдаваа

ТУРШЛАГА СОЛИЛЦЬЁ

Г. ДЭМИД, Н. ХУЯГ

НӨХӨН СЭЛБЭХ ЭМЧИЛГЭЭНД АЛЛО ЯСЫГ БЭЛТГЭЖ ХЭРЭГЛЭХ НЬ

ГЭМТЭЛ СОГОГИЙН БОЛЬНИЦ

Ясны хавдар үрэвсэлд нэрвэгдсэн ясыг тайрч аваад дутмагийг нөхөх, бороололт удааширсан хугарлыг хадаж бэхлэх, гэмтлийн улмаас мэс заслын эмчилгээний явцад гавал ясанд үүссэн их бага хэмжээний цоорхойг таглах зэрэгт алло ясыг өргөн хэрэглэж байна.

Гэтэл алло ясыг хаанаас яж олж бэлтгэх асуудал шийдэгдээгүй байна. Тайрагдсан мөчний бслон хагалгааны үед таслаж авсан яснаас бэлтгэж болох боловч энэ нь их төлөв харшилах шалтгаантай байдаг. Эрүүл хүмүүсээс донорын журмаар ясыг нь авч хэрэглэж болох боловч энэ нь хувь хүн болон эмнэлгийн эдийн засагт багагүй хохирол учруулдаг юм.

Харин цогцосны яснаас авч бэлтгэх нь хамгийн бололцоотой арга юм. Нөхөн сэлбэх хагалгаанд хэрэглэхээр бэлтгэж хадгалсан ясны ферментүүд хадгалагдан тур амьдрах чадвар нь буураагүй байхаас гадна бүрэн ариутгагдсан байдаг учир хүний биед муу нөлөө үзүүлдэггүй байна.

ЗХҮ-д алло ясыг тусгай хөргөгчинд түргэн хөлдөөх буюу бага дараалтанд хөлдөөж хадгалан (нөхөн сэлбэх хагалгаанд) хэрэглэж байна. Мөн формалинын уураар буюу уусмалаар алло ясыг ариутган хадгалахад уг ясны зарим чанар алдагдахгүйгээс гадна бүрэн ариутгагддаг болох нь нотлогдсон учир энэ аргыг ч өргөн хэрэглэж байна.

1970 оноос гэмтэл согогийн больницид зөвлөлтийн эрдэмтдийн алло ясыг формалины уураар ариутгах, 1977 оноос формалины уусмалаар ариутгах туршлагыг тус тус нэвтрүүлэн хэрэглэсэн нь сайн үр дунтэй байгаагаас гадна хот хөдөөний эмнэлгүүдэд нэвтрүүлэн хэрэглэж болох хялбархан найдвартай арга болох нь нотлогдож байна.

Эмнэлгийн нарийн мэргэжлийн тусламж, эмчилгээний шилмэл аргууд хөдөө орон нутгийн эмнэлгүүдэд өргөн дэлгэр нэвтэрч байгаа орчин үед доорхи өргөчлөлийн алло ясыг бэлтгэн хадгалж нөхөн сэлбэх хагалгаанд хэрэглэх нь эмчилгээний чанарыг сайжруулахад нөлөө үзүүлж болно гэж үзэж байна.

Алло ясыг бэлтгэн ариутгаж хадгалах 1-р арга

Эмчилгээнд хэрэглэх алло ясыг аваадаа тодорхой мэдэгдэх архаг өвчингүй, сүүлийн сард хурц халдварт өвчинеэр өвчлөөгүй, гэнэтийн ослоор нас барсан 18—40 насны үхдлээс авна. Алло ясыг дулааны улиралд бол нас барснаас хойш 12 цагийн дотор, хүйтний улиралд бол 24 цагийн дотор авна. Ясыг аваадаа яс авах талбай болон багаж хэргэслийг тусгайлсан ариутгах шаардлагагүй. Авсан ясаа ариутгахын тулд 800 хавтгай дөрвөлжин см суурь бүхий дуудуураа зэвэрдэггүй ган утсаар хийсэн торон тасалгаатай паалантай сав бэлтгэнэ. Савын ёроолд 40%-ийн 20 грамм формалиныг хийж бэлтгэсэн ясыг торон дээр тавиад савыг битүү таглана. 24 цагийн дараа уул ясыг автоклаваар ариутгат-

сан том амтай шилэн саванд шилжүүлэн хийж битүүмжлэн + 4 буюу — 4 градусын орчинд хадгална. Формалинын уурнаас авч шилэн саванд шилжүүлэн хийх үед яснаас бактериологийн шинжилгээ авна. Энэ ясыг 3 сар хадгалж болно. А лло ясыг нөхөн сэлбэх хагалгаанд хэрэглэхийн өмнө пеницилинийн 500000 нэгжээр бэлтгэсэн 0,25%-ийн новоканины уусмалд хийж 1—2 цаг байлгасны дараа хагалгаанд хэрэглэж болно.

Алло ясыг ариутгаж хадгалах 2-р арга

Ясыг үхдлээс дээрхийн адилаар авч том амтай шилэн саванд урьдчилан бэлтгэсэн 0,5%-ийн формалинын уусмалд хийж тагийг битүүмжлэн воск, парафин зэргээр хий нэвтрэхээргүй битүүмжлэнэ. Бэлтгэсэн он сар өдрийг шилэн дээр тодорхой тэмдэглэнэ. Ийнхүү ариутгагдаж байгаа шилтэй ясаа + 4 буюу — 4 градусын орчинд хадгална. 21 хоногийн дараагаар нөхөн сэлбэх хагалгаанд хэрэглэж болно. Гурван долоо хоног тутамд уусмалыг шинээр сольж шаардлагатай гэж үзвэл бактериологийн шинжилгээ хийнэ. Ясыг дээрх маягаар нэг жил хүртэл хадгалж болдог байна. Уусмалыг солих бүрийд асептикийн дэглэмийг хаттуу сахиж сар өдрийг тодорхой тэмдэглэж хариуцагч эмч сувилагч нар гэрэн үсэг зурсан байна.

Ж. ИДЭР

ЧЭЭЖНИЙ ХӨНДИЙД ХОС КАТЕТЕР ТАВИХ ЭМЧИЛГЭЭНИЙ АРГА

АЖИЛЧНЫ РАЙОНЫ ХҮҮХДИЙН ЭМНЭЛЭГ

Сэргүүн бүсийн хүн амын 30% нь жилдээ амьсгалын замын хурц халдвараар өвчилдгээс 60—70%-ийг хүүхдийн өвчлөл эзэлдэг юм. (1)

Хүүхдийн уушгины өвчнүүдийн дотор стафилакоккын хатгалгаа өвчин 8,5—15% байна. (1)

1977—1978 онд хүүхдийн клиникин төв эмнэлэгт хэвтэгсдийн 45,8% нь хатгалгаа өвчтэй байснаас 81,5% нь гурав хүртэлх настын хүүхэд байжээ. (2)

1975—1979 онд мөн эмнэлэгт эмчлэгдсэн мэс заслын өвчний 8,6% нь хүндэрсэн хэлбэрийн стафилакоккын хатгалгаатай байснаас 87,4% нь цээжний хөндийн хүндрэлтэй байжээ. (3)

Ингэж амьсгалын замын өвчнүүд түүний хүндрэлүүд их байгааг судлаачдын баримт харуулж байна. Гэтэл өвчний эмчлэх хэвшил болсон аргууд үр дүнгээ өгөхөө болж шинэ аргуудыг эрэлхийлэхэд хүргэж байгаа юм. Иймд орчин үед мэс засал сэхээн амьдроулахын практикт үр ашигтай шинэ эмчилгээ, оношилгооны аргуудыг санаачилж туршил болжээ.

Амьсгалын замын өвчнүүд түүний хүндрэлийн улмаас үүссэн уушги цээжний хөндийн үрэвслийн үед эмийн эмчилгээ, хатгалт хийх, гуурс тавих, мөгөөрсөн хоолийг дурандах болон төгс мэс заслын аргууд хэрэглэгдэж байна. Эмчилгээний энэ аргуудаас өвчний үе шатанд тохирсон тухайн үед оношлогдсон өвчний эдгээхэд хамгийн хялбар хямд өвчтөнд аль болох зовиургүй, гэмтэл бага учруулдаг, хамгийн ашигтайг нь сонгож авах чухал юм.

1975—1979 онд хүүхдийн клиникин төв эмнэлгийн мэс заслын тасгийн стафилакоккын хүндэрсэн хэлбэрийн хатгалгаатай өвчтөний 3,8%-ийг эмээр, 10,5%-ийг хатгалтаар, 51,9%-ийг гуурс тавих, 9,2% нь мөгөөрсөн хоолийг дурандах, 24,6% нь төгс мэс заслын аргаар тус тус эмчилжээ. (3)

ЗХУ-д чээжинд идээ, хий, хурсан өвчтөний 16,4%-ийг хатгалтаар 43,7%-ийг гуурс тавьж, 39,9%-ийг мэс засал хийж эмчилжээ. (4)

Гэтэл хатгалтаар эмчилсэн өвчтөний 47%-д, гуурс тавьж, эмчилсэн өвчтөний 51,6%-д, мэс засал хийж эмчилсэн өвчтөний 13,7%-д эмчилгээ үр дүн муу (4,5) байсан бөгөөд гуурс тавьж эмчилсэн өвчтөний 27%-нь, мэс засал хийж эмчилсэн өвчтөний 17,3% нь нас баржээ.

Ийнхүү харьцангуй үр дүн бага, нас барагт өндөр байгаа ч гэсэн уушги чээжний хөндийн идээт үрэвслийг эмчлэхэд чээжний хөндийд гуурс тавих арга одоо хүртэл тэргүүн байранд байсаар байна.

1970 оноос Москва хотын Н. В. Склифосовский нэрэмжит институт янз бүрийн байрлалтай идээт процесийг „битуу аргаар“ өргөн, эмчилж үүндээ хоёр нүхтэй гуурсыг ашиглажээ. (6)

Энэ аргыг идээт янз бүрийн шарх, буглаа, чөмөг ясны үрэвслийн үед хэрэглэсэн нь хуучин аргатай харьцуулж үзэхэд идээт өвчинөөр нас барах явдлын бодитойгоор бууруулах боломж олгосон байна (7—10).

Энэ аргын сайн тал нь:

1. Идээт голомт нь гадаад срчнисос бүрэн тусгаарлагдсан учир нэмэлт халдварт авахаас хамгаалах.

2. Шүүдэс, идээг тасралтгүй гаргаж байнга угааж оруулах.

3. Идээт хөндийг угааж антибиотикийн уусмал, уураг задлах фермент тогтмол хийх

4. Сиyrэгжилт болох нь үдээт хөндий үүсч, орчныхоо хавдсан үрэвсэлтэй хэсгээс эдийн хавангийн шингэнийг татаж, хортой бүтээгдэхүүний шимэгдэлтийг саатуулж, захын хавдар багасч, идээт голомтыг тойрсон эдийн хүчилтерегчийн бслон цусэн хангамж сайжирдаг.

5. Том, задгай шархгүй учир идээт хөндийг цэвэршингүүт анхдагч шарх мэт анидаг учир эдгэрэлт түргэн байдал,

6. Эдийн гэмтлийг багасгаж түүний байнгын дагавар, боолтын ажлыг хөнгөвчилдэг.

7. Антибиотик, ерөнхий эмчилгээг түргэн солих боломж олгодог учир өвчтөнд дисбактериоз, дархлаг ялгаралт сууралт зэрэг гажуу нөлөө үзүүлэх эмчилгээнээс чөлөөлөх зэрэг ашигтай талтай юм. (6)

Хүүхдийн мэс заслын практикт 1975 синисос эхлэн хүүхдийн чөмөг ясны үрэвслийн үед чөмөг цөөлборлож угаах эмчилгээний аргыг шинээр хэрэглэж нэвтрүүлсэн нь үр дүн егч байна. Энэ аргыг чээжний хөндийн өвчинд хэрэглэсэн тухай мэдээлэл байхгүй ч гэсэн бид энэхүү аргын дурдсан сайн талуудыг үндэслэн хатгалгаа өвчний хүндэрлийн улмаас үүссэн уушги цорох, чээжний хөндий идээлэх, хий шингэн хуралдах зэрэг өвчний үед сөрийн эмнэлгийн нөхцөлд зохицуулан 1980 оноос эхэлж 1—6 насны 7 өвчтөнд „лэваж“ байдлаар чээжний хөндийд хос катетер тавьж С. Ш. Шамсийвиин антисептик уусмалаар угааж, уураг задлах фермент, антибиотикийн уусмалыг хавсарган хэрэглэлээ. (II) Уул эмчилгээний эхний хоногуудад өвчтөний биеийн байдал дээрдэж, хоол нойрсндоо сайжирч, хэлүүн буурч, амьсгалын дутагдал, хордлого багасч, идээ шингэрч цэвэршин, уушги тэлэгдэж байгаа нь ажиглагдсан юм. Улмаар өвчний явц засарч 2—4 сарын дараа чээжний зураг авч үзэхэд идээт голомт, үлдэгдэл хөндий нэгэлдэц шварт зэрэг эмгэг процесийн үлдэц ажиглагдсангүй.

Үг эмчилгээг хэрэглэсэн 7 өвчтөн бүрэн эдгэрч байлаа.

Эмчилгээнд дурдсан өргүүг хэрэглэхэд дараахь багаж хэрэгслүүд шаардлагатай. Үүнд:

1. Нийлэг эдээр хийсэн онгитой катетер (1,0) 2 ш
2. Катетер тавих зүй (-1,0) 1 ш
3. Зөөлөн сэтгүүр (20—25 см) 1 ш
4. Пластир-бага
5. Катетерын бөглөө 2 ш
6. Хайч 1 ш

7. Мэс заслын ажилбарт ордог зүйлүүд 2 удаагийнх.

Чээжний хөндийд хос катетер тавихдаа дор дурдсан шаардлагыг биелүүлэх хэрэгтэй.

— Юуны өмнө цээжний хөндийд хос катетер тавих гэж байгаа өвчтөнд онош тавигдсан, тайвшируулах, өвчин намдахаар: супрастин-2%, пипольфен-2,5%, димедрол-1%, аминазин-2,5%, альгин-50%, новокаин-0,25—0,5% зэрэг эмнүүдээс хольц байдлаар тунг тохиуулан хийж бэлтгэсэн байна.

— Өвчтөнөө биеийн байдал, өвчний байрлал зэргээс хамаарч хэвтээ юмуу суугаа байдалд байлгана.

Хэрвээ хэвтээ байдалд бол толгой талыг өндөр, өвчний эсрэг талаар нуруу, хажуу, хэвлийн аль нэг талаар хэвтүүлж тэр талын гарыг дээш авна.

— Суугаа байрлглд бол хоёр гарыг толгой дээр авч эсрэг хажуугаар нь тэвэрч барина.

— Онош, шинжилгээ, бодит үзлэгтээ үндэслэн өвчлөлд хамарсан хэсгийг тодорхойлж, дээд, доод талд нь катетер тавих цэгээ тогтооно.

— Уг орчиндоо ердийн аргаар ариутгаж хэсгийн мэдээ алдуулалтыг дээд хавирганы доод ирмэгийг дагуулан тэнд байгаа мэдрэлийн ширхэг, чээжний гялтанд үечлэн хийнэ.

— Мэдээ алдуулалтыг хийж, бэлтгэсэн зүүгээрээ доод талын хавиргын дээд ирмэгийг дагуулан хатгаж хий оруулалгүй соруулан нэмэлт сношилгоо хийж, зүүний нүхээр зөөлөн сэтгүүрээ оруулж зүүг авч, сэтгүүрээ дагуулан катетераа чээжний хөндийд оруулж дараа нь сэтгүүрээ сугалан авч, онгины доод хэсгээр зөөлөн чимхэж гараар барьж бөглөнө. Катетераа чээжинд пластырээр нэлж бэхлэнэ. 2 дахь катетераа адил аргаар тавина.

Чээжний хөндийд катетераа дээд талынхыг дээш, доод талынхыг доош чиглүүлж, чээжний хөндийд ороод нугарахгүй, уушги эдийг хатгаж, сугарахааргүй. дээд катетераар уусмал хийж угааж доод катетераар соруулахад саадгүй байхаар тааруулж тавина.

Эмчилгээний явцад гарч болох хүндрэл:

— Ажилбарын үед судас гэмтээснээс чээжний хөндийд цус алдах,

— Катетер дээр ажиллаж байгаа үед чээжний хөндийд хий сорогдсон орох.

— Катетер дарагдах, хавчийх, нугарах зэргээр ажиллахгүй болох,

— Өтгөн идээ, өнгөр, эдийн үлдэгдэл катетерийг бөглөх зэрэг нь өвчтөнд онцгой аюултай биш боловч хүндрэл өгч болно.

Дурдсан хүндрэлүүд нь ажиллагааны арга барилтай холбоотой учир, эмнэлзүй бодит үзлэг, соруулглт, гэрлийн шинжилгээ зэргээр бүрэн оношлогдож тохиолдсон хүндрэлд цус тогтоох эмчилгээ хийх бэхэлгээг авч катетерийг засах, антисептик уусмалаар угааж зайлх, хий шингэннийг соруулж антибиотик, ферментийн уусмал хийж бөглөх зэрэг зохих шаардлагатай арга хэмжээ авч үүссэн шинж тэмдгийн дагуу тухайн эмчилгээг хийхэд хүндрэлд хүргэж байгаа шалтгаан хялбархан арилна,

Энэ аргын ач холбогдол нь:

1. Өвчтөнд эдийн болон сэтгэл санааны гэмтэл бага учруулна.
2. Нарийн мэргжил, багаж хэрэгсэл шаардагдахгүй учир тохиолдсон эмнэлгүүдэд хийж болно.
3. Олон дахин хатгалт хийх, том гуурс тавих ажлаас чөлөөлнө.
4. Эмчилгээг тогтмол хийж боломж олгоно.
5. Хийсэн эм шууд голомтонд үйлчилнэ.
6. Наалдац шварц бага үүснэ.
7. Эмчээс өвчний явцад байнга хяналт тавих боломж олгоно.
8. Уушгины цооролт нь эмчилгээний хүчтэй механик соролтонд

томорч амьсалаар орсон агаар чээжний хөндийгөөр дамжин гадагш гарах явдлыг багасгаж цоргоны байдалд, өвчний явцад тохируулан эмчлэх боломж олгоно.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Рачинский С. В., Еренков В. А., Заболевания органов дыхания у детей. Киев, 1983
2. Данзан Г. Хүүхдийн уушгины архаг үрэвсэл. УБ, 1982
3. Жамъянжав Д. Лечения стафилококковой пневмонии у детей (Автореф. канд. дисс) УБ, 1982.
4. Лесницкий Л. С., Чепчерук Г. С. Пиопневмоторакс в хирургической клинике. Вестник хирургии, 1982, № 11.
5. Исакова Ю. Ф., Михельсон В. А. Проблемы детской хирургии и послеоперационной патофизиологии М, 1972.
6. Каншин Н. Н. О закрытом методе лечения нагноений. Вестник хирургии, 1981, № 4
7. Куш Н. Д., Кононченко В. П., Ткаченко Л. И., Вечерко В. Н., Симонов Е. В. Тимченко А. Д. Ранняя остеоперфорация при лечении острого гематогенного остеомиелита у детей. Вестник хирургии, 1981, № 3.
8. Мельник В. А., Аникина Т. П. Прямые иммуногемотрансфузии в комплексной терапии остеомиелита у детей раннего возраста. Хирургия, 1973, № 6,
9. Ормантаев К. С., Султанбаев Т. Ж. Внутриостные промывания при остеомиелите у детей. Л, 1979.
10. Жамбалжав Л., Даваа М., Сүхээ Д. Хэвлэйн гялтангийн угаалт хийх. И. И. Дерябины аргыг хэрэглэсэн дун. Анагаах ухаан, УБ, 1981, № 3.
11. Шамсиев С. Ш., Шабалов Н. П. Острые пневмоции у детей раннего возраста. Ташкент, 1978.

ЛЕЧЕНИЕ ЭМПИЕМ ПЛЕВРЫ МЕТОДОМ КАТЕТЕРИЗАЦИИ

Ж. Идер

Впервые внедрен метод двойной катетеризации при лечении эмпием плевры в 3-ей детской больнице г. Улан-Батора.

Достигнуто полное клиническое выздоровление 7 детей в возрасте до 6 лет.

После проведенного лечения не были обнаружены шварты и спайки в плевральной полости при повторной рентгенографии.

В работе изложены метод и результаты лечения. Установлено, что этот метод лечения безболезнен, эффективен, не вызывает осложнений, позволяет ускорить заживление раны и предупредить возникновение дисбактериоза. Кроме этого, выявлен экономический эффект, заключающийся в сокращении показателя койко-дней.

Д. МАЛЧИНХҮҮ

ХҮҮХДИЙН УУШГИНЫ ҮРЭВСЛИЙН БҮРДМЭЛ ЭМЧИЛГЭЭНД ГЕПАРИНЫГ ХАВСРАН ХЭРЭГЛЭХ

АНАГААХ УХААНЫ ДЭЭД СУРГУУЛЬ

Уушгини үрэвслийн хордлогот хүнд хэлбэрийн үед цусны гомеостаз байдал алдагдсанаас бичил эргэлтийн гүнзгий хямрал үүсэх нь өвчний явцыг хүндруулдэг эмгэг жамын нэг илрэл юм. Цусны бичил эргэлт нь нэг талаас судасны өөрчлөлтөөс хамаарах боловч, цусны урсах чанар, цус булэгнэлтийн байдлаас ихээхэн шалтгаалдаг. Уушгини эд өөрөө цус булэгнэлтийг идэвхжүүлэгч болон саатуулагч бодисоор баялаг учир уушгини эмгэгээс сэргийлэх, түүнийг эмчлэхэд цус булэгнэлтийн байдалд дүгнэлт хийх нь практикийн ач холбогдолтой юм.

5*

Ушгины цочмог үрэвслийн үед зарим судлаачдын судалгаагаар цусны булэгнэлт удаашрах, зарим судлаачдынхаар (2—5) цусны булэгнэлт түргэсэх үзэгдэл давамгайлдаг гэсэн зөрөөтэй санал байгаа боловч ихэх судлаачид, бидний эмнэлзүйн ажиглалтаас ялангуяа ушгины үрэвслийн хордлогот хүнд хэлбэрийн үеийн цусны бичил эргэлтийн хямрал нь цусны булэгнэлт түргэсэх үзэгдэлтэй холбоотой гэж үзжээ. Ушгины цочмог үрэвслийн ид үед гарах цусны булэгнэлт ихсэх хэмжээ нь уул өвчний явц, хүндэрэл тархалтын байдлаас хамаардагийг (5) уушгины стафилококк үрэвслийн үед цус булэгнэлтийн тогтолцоо өөрчлөгдөн (гипероагуляц), цусны бичил эргэлт хамаардгийг (6, 7) нярайн үжил өвчний үед цусны булэгнэлт ихэссэний улмаас цусны бичил эргэлт хямардгийг (8) хэвлэлд мэдээлжээ.

Булэгнэлт хэт ихсэлтийн үед гепарин хэрэглэх үндэслэлтэй бөгөөд үүний идэвх нь биологийн аргаар тогтоосон нэгжээр хэмжигдэнэ. Гепарин нь зөвхөн цус булэгнэлтийн эсрэг төдийгүй үрэвсэл, хүчилтөрөгч дутагдал, харшлын эсрэг үйлчлэлтэйгээс гадна липиод задлан үйлчлэлтэй. (8, 9) Гепарин нь цусны сийвэн дэх В-липопротеид ба холестерины хэмжээг бууруулна. Энэ үйлчлэл нь липопротеины липаза ферментийг идэвхжуулдгээс шалтгаална. Гепарин гиалуронидаза ферментийн идэвхийг дараангуйлж цусны фиброн хайлуулах чадварыг идэвхжүүлэн зүрхний өөрийнх нь цус хангамжийг сайжруулна.

Цусны булэгнэлт түргэсэх шинж нь клиникт цусны бичил эргэлтийн хямрал, коагулограммын өөрчлөлтүүдээр илрэх тул цус булэгнэлтийн дараах үзүүлэлтүүдийг эмчилгээ эхлэхийн өмнө эмчилгээний явцад шинжилж байх нь чухал.

Хүснэгт 1.

Эрүүл хүүхдийн коагулограммын зарим үзүүлэлт (А. В. Папаян, А. И. Алексеевынхаар (10))

Үзүүлэлтүүд	1—3 нас	3—7 нас	7—14 нас
Цус булэгнэлтийн хугацаа (Ли-Уайтаар, минут)	6,1+0,43	6,9+0,04	6,0+0,25
Эргэж кальцижих, хугацаа (секрекальцификаций)	106+3,5 IV—VI	110,1+3,0 IV—VI	108+4,1 V—VI
Тромботест зэрэг	90+2,2	93,5+1,6	89,0+1,1
Протромбины индекс			
Протромбины хэрэглээ (хувь)	94,0+1,5	96,8+1,1	98,0+0,7
У фак-оп %	90,6+2,1	91,8+0,8	90,0+1,5
У II фактор %	94,0+1,3	95,9+1,2	92,0—3,6
У III фактор %	104,0+1,7	103,7+3,2	102,0+2,8
Фибриноген мг %	302,0+17,6	287+16,9	253,0+12,0
Сийвэнгийн гепаринд тэс- вэр мин (толерантность)	7,5+0,3	7,0+0,1	6,0+0,2
Челеөт гепарин сек	4,4+0,05	4,5+0,01	5,0+0,02

Яаргалтай оношлоход туслах зорилгоор богино коагулограмм хийж болно. Үүнд булэгнэлтийн хугацаа, эргэн кальцижих, цус гоожилтын үргэлжлэх, тромбоцитын тоо, сийвэнгийн фибриногений хэмжээ зэрэг хамгийн чухал үзүүлэлтийг шинжлэх хэрэгтэй.

Ушги үрэвслийн хордлогот үжил хүнд хэлбэрийн үед бичил эргэлтийн хямрал цус булэгнэлтийн байдлыг харгалзан гепариньг хүүхдийн 1 кг жинд 150—200 ЕД нэгжээр хоногт тооцоолон 4—6 цагийн зайтай эхний тунг судсанд дараачийн тунгуудыг булчинд тарина. Курс эмч илгээ 5—7 хоног үргэлжилнэ. Хүнд үед гепарини тунг коагуло-

раммын үзүүлэлтийг харгалзан биеийн 1 кг жинд 300—500 нэгж хүртэл ихэсгэж, курс эмчилгээний хугацааг уртасгаж болох юм. Гепариньг судсаар тарихад үйлчилгээ нь тэр даруй илэрч б цагийн турш арьсан дор тарихад 40—60 минутын дараа үйлчилж, үйлчилгээ нь 8—14 цаг тус тус үргэлжилнэ. Гэхдээ гепаринь тунг цус бүлэгнэлтийн хямралын зэргээс хамааран тогтоох ба цус бүлэгнэлтийн хугацааг өдөр бүр тодорхойлж хяналт тавих шаардлагатай.

Гепариньг тарихад 0,85%-ийн физиологийн ариутгасан уусмалаар шингэлж, тунг тооцоолболж хялбар юм. Үүнд гепаринь үйлдвэрийн бэлдмэл нь 1 мл-д 5000, 10000, 20000 нэгж агуулсан байх боловч майд голдуу 1 мл-тээ 5000 нэгж агуулсан 5 мл-ийн шилтэй ирж байна. Үүнээс 1 мл-ийг авч 9 мл физиологийн уусмалаар шингэлбэл уул уусмалын 1 мл нь 500 нэгж 0,1 мл 50 нэгж гепарин агуулна. Уул уусмалаас 0,3—0,4 мл-ээр хүүхдийн биеийн 1 кг жинд бодон хоногийн тунг тооцоолно. Жишээ нь: 8 кг жинтэй хүүхдийн хоногийн тун 150 нэгж $\times 8$ кг = 1200 нэгж буюу 0,3 мл $\times 8$ кг = 2,4 мл үүнийг хоногт 4 удаа 6 цагийн зайдтай тарина гэвэл 24 : 4 = 0,6 мл болно. Хэрэв гепаринь 1 мл уусмалыг 4 мл физиологийн уусмалаар шингэлбэл 0,1 мл нь 100 нэгж гепарин агуулна. Үүгээр ч тооцоолж болно.

ГЕПАРИНЫГ ХЭРЭГЛЭХИЙГ ХОРИГЛОХ ҮЕ. Судасны нэвчимийн чанар ихэсч, цусны бүлэгнэлт удааширсан цусархаг эмзэгшилийн өвчинүүд, зурхний дотор хэсгийн нянгийн гаралтай цочмогдуу үрэвсэл, элэг, бөөрний уйл ажиллагааны хүнд хямрал цагаан цогцсын хурцархаг эмгэг, төлжилгүйдэл, төлжил-доройтон цус багасах, зурхний цочмог цүлхэн тараагуур судасны үхжил зэрэг өвчний үед гепариньг хэрэглэхийг хориглоно. Гепаринь эсрэг үйлчлэгч нь сульфат протамин учраас тун хэтэрсэн нөхцөлд түүнийг хэрэглэнэ. Иймд гепарин эмчилгээ хийдэг тасаг сульфат протамины нөөцтэй байх ёстой. Гепариньг тарьснаас хойш 15 минутын дараа сульфат протаминыг хийвэл 100 ЕД гепариньг 0,1—0,2 мл протамины уусмал саармагжуулж чадна. Шаардлагатай бол 15—30 минутын дараа давтан хэрэглэж болно.

Протамин сульфатын 1%-ийн 5 мл уусмалыг цусны даралт их буурсан, тробоцид эрс цөөрсөн, бөөрний дээд булчирхайн холтослогийн дутагдлын үед хэрэглэхийг хориглоно. 1930 оноос Улсын хүүхдийн клиникин төв эмнэлэгт уушгины үрэвслийн хүнд хордлогот хэлбэрт гепариньг дээрх тунгаар бусад эмчилгээтэй хавсран хэрэглэхэд ихэнхдээ сайн нөлөө үзүүлж байгаа ба гажуу нөлөө бидэнд ажиглагдаагүй байна.

Уушгины цочмог үрэвслийн хүнд, хордлогот хэлбэрийн үед судсан доторхи цус бүлэгнэлт түргэсгэх процесс, түүнээс үүссэн цусны бичил эрэглэтийн хямралыг эмчлэхэд гепариньг бусад эмчилгээтэй хавсран хэрэглэхэд сайн нөлөөтэй болох нь хэвлэлийн мэдээлэл, бидний клиникин ажиглалтаас харагдаж байна.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Лемберанская А. Ю., Габуция А. К. Учен. записки Азербайджан. Мед. ин-та 1976, Т—40, 51—59.
2. Живодеров В. М., Рычкова М. А. Клин. мед. 1971, № 7, 72—78
3. Опочинский Ф. С. Педиатрия, 1980 № 8, 36—37
4. Акопян М. Г. Педиатрия, 1980, № 7, 30—32
5. Шовкопляс Ю. А. Педиатрия 1980, № 10, 7—11
6. Абдурахмазова М. В. Труды Таджик. мед. ин-та, 1975, Т—126
7. Ситковский Н. Б., Ханес Г. С., Куценко Т. А. Ингибиторы протеолиза в хирургии детского возраста, Киев, 1977

8. Шиленкова В. И., Самсыгина Г. А., Выхристюк О. Ф., Цыбульская Г. В. Педиатрия, 1980 № 6, 57—60
9. Машковский М. Д. Лекарственные средства, М, 1977, Т—1, 159
10. Папаян А. В., Цыбулькин Э. К. Острые токсикозы в раннем детском возрасте, Л, 1979
11. Hardaway R. M. Syndromes of disseminated intra-Vascular Coagulation, Springfield, 1966.

ПРИМЕНЕНИЕ ГЕПАРИНА В КОМПЛЕКСНОЙ ТЕРАПИИ ТЯЖЕЛОЙ ПНЕВМОНИИ У ДЕТЕЙ

Д. Малчинху

Сообщается о физиологическом действии гепарина, показаниях, противопоказаниях включения его в комплексную терапию тяжелой пневмонии у детей раннего возраста. Обобщены литературные и собственные клинические наблюдения.

Отмечено, что в комплексную патогенетическую терапию тяжелой токсической формы острой пневмонии включать гепаринотерапию под контролем коагулограммы является целесообразным, так как это патогенетически оправдано при наличии синдрома внутрисосудистой гиперкоагуляции. Применение гепарина при этих пневмониях, протекающих с нарушениями гемостаза дает отчетливый клинический эффект, улучшает прогноз и течение заболевания.

[С. ДОРЖ]

КЕСАР ОГТЛОЛ ХИЙХ АРГА ТЕХНИК

АНАГААХ УХААНЫ ДЭЭД СУРГУУЛЬ

Кесар огтлолыг хэвлийгээр, утреэгээр, хэвлийн гадуур гэж үндсэн 3 хэсэгт хуваадаг.

УМАЙН ИХ БИЕД ХИЙХ КЕСАР ОГТЛОЛЫН АРГА ТЕХНИК.

Хэвлийн урд хананд умдаг яснаас эхлэн хүйсний зүүн талаар тойруулан гол шугамаар дагуу огтлол хийнэ. Зүслэгийн урт дунджаар 16 см байна. Хэвлийн хөндийг нээнгүүт умайн ба шарх хоёрын завсраар ёргөн марль чигжээс хийнэ. Энэ нь орчмын ус хэвлийд орохоос урьдчилан сэргийлж байгаа хэрэг юм.

Ингээд умайн урд хананд 12 см орчим урт дагуу огтлол хийж, хүүхдийг хөлөөс татах гаргана. Үүний дараа ихэс өөрөө салахгүй бол гарцаа умайд оруулан ихэсийг авна.

Энэ үед умай агshaах эмийг хэрэглэнэ. Дараа нь умайн хананд оёдол тавина. Энэ бол хамгийн хариуцлагатай үе байдаг. Шархыг оёхдоо асептикийг ихээхэн анхаарахаас гадна зөв бөх оёно. Мөн умайд халдвар орохоос болгоомжлох хэрэгтэй. Оёдлын гурван давхар, тэгэхдээ заавал кетгутаар оёдог дүрмийг баримтлана. Эхлээд булчинг булчинтай нь нийлүүлж оёно. Ингэж оёхдоо салст бүрхэвчийг оёссонд оруулахгүй, оёдол нь тус тусдаа бие биеэсээ 0,5—0,6 см хэмжээний зйтай тусгай занги уяа байх юм.

Хоёрдугаар оёог үүнийхээ дээгүүр давхарлан түрүүчийн оёдлуудын хоорондуур урьдах оёогоо бэхэлж булчин болон гялтан бүрхүүлийг нийлүүлэн оёно.

Мөн тусгай занги уяагаар уяж, оёдлын үзүүрийг тун богино хайчилбал зохино. Харин гуравдахь давхарын оёдол бол умайн хучсан гялтанг хооронд нь холбосон тусгай биш кетгутын оёдол юм.

Шарханд зөвхөн хоёр давхар оёдол тавьдаг аргыг сүүлийн жилүүдэд эх барих практикт зарим эрдэмтэд хэрэглэж байна.

Мэс заслын дараа 24 цаг юм уулгахгүй. Долоо ба найм дахь хоног дээр нь арьсны оёдлыг авна.

Умайн урд ханаар хийдэг кесар огтлол олон талын учир дутагдалтай. Хэвлэйн хөндийг нээж гэдсийг их цочроодог, зөвхөн умайд төдийгүй хэвллийн хөндий болон бүх биед халдварт орох аюултай юм. Нэгээ талаар их хэмжээний цус алдуулдаг. Харин умайд доод үеэр хийх кесар аргад судас бага огтлогддог сайн талтай.

УМАЙН ДООД ҮЕЭР ХИЙХ КЕСАР ОГТЛОЛЫН АРГА ТЕХНИК. Умайн доод үеэр огтлол хийх хоёр арга байдаг.

1. Умайн доод үед хөндлөн огтлол хийх

2. Умайн доод хэсэгт дагуу зүслэг хийх хэд хэдэн арга бий.

Умайн доод хэсэгт дагуу зүслэг хийх хэд хэдэн арга бий. Үүний дотроос нилээн өргөн хэрэглэдэг арга нь Дерфлерийн арга юм.

Дерфлерийн арга нь ердийн аргаар хэвллийн хөндийг дагуу зүслэгээр нээж умайн хэвллийн хөндийгээс марлин чигжээсээр сайтар тусгаарлана. Ингээд давсаг умайн хооронд үүсдэг гялтангийн нугалаасас дээш 1—2 см босоо зүслэг хийж, гялтанг хуулна. Гялтан хальс цайвартан гялалзаж харагдана. Үүний дараа умайд нум хэлбэртэй хөндлөн огтлол хийж үүгээр зүүн гарцаа оруулж, хуухдийн толгой болон их биеийг гаргана. Дараа нь умайн огтолсон шарханд оёдол тавьж, хэвллийн хөндийг хаана.

ЗАНЧЕНКО, ГУСАКОВ НАРЫН АРГА. Хэвллийн хөндийг ердийн аргаар нээж умайн урд талаар хучсан гялтанг хөндлөн огтолж, дараа нь умайн доод хэсэгт хөндлөн огтлол хийнэ. Үүний дараа долоовор хуруугаараа хагалгааны шархыг тэлж томруулна. Ингээд ихэс болон ургийг энэ огтлолоор гарган авч оёдол тавиад хэвллийн хөндийг ердийн аргаар оёж битүүлнэ. Үнээс гадна ЗХУ-ын эрдэмтэд сүүлийн үед арьс ба умайг хөндлөн огтлолоор нээх аргыг хэрэглэж байна.

УТРЭЭГЭЭР ХИЙХ КЕСАР ОГТЛОЛ Утрээгээр хийх кесар огтлолыг орчин үед голдуу жирэмсний хожуу үеийн хордлого уушги, зурх, бөөрний өвчний үед хийж байгаа юм. Ялангуяа 14 долоо хоногоос дээш хугацаатай жирэмслэлтийг таслахад хэрэглэдэг байна.

МЭС ЗАСАЛД БЭЛТГЭХ. Эмэгтэйг утрээний мэс заслын байрлаар хэвтүүлнэ. Гадна бэлиг эрхтэнд зохих ариутгал хийж, шээсийг катетерээр авна. Мөн хэд хэдэн хутга хавчуур, хайч, хямсаа, утрээний толь кетгүт, торгон у тас зэргийг бэлтгэнэ.

МЭС ЗАСАЛ ХИЙХ АРГА. Энэ мэс заслыг хийх хэд хэдэн төрлийн арга бий.

1. **КАКУШКИНЬ АРГА.** Суман хавчуураар утрээний дээд хэсгээс барьж досш нь татаад утрээний урд хананд „Ү“ буюу хөндлөн огтлолыг дотор зөвийн дээд хэсэгт хийж, түүнийгээ умайн их биерүү чиглүүлэн томсгоно. Үүгээрээ ураг ба ихсийг авч, шархыг ердийн аргаар оёно.

2. Умайн хүзүүг Гегарын тэлэгчээр нээнэ. Умайн хүзүүний гадна амсраас дээш 2 см хүнхийсний салст бүрхэвчийн умайн хүзүүтэй нийлсэн хэсэгт нум хэлбэртэй огтлол (4,5—5 см) хийнэ. Ингээд давсгийг буулгана.

Давсгийг буулгах үед холбогч эдийн нарийнхан судлууд тааралддаг түүнийг хайчилна. Тэгээд умайн давсгийн нугалаа хүртэл буулгана. Умайн хүзүүний дотор Гегарын хамгийн сүүлчийн номерыг үлдээ-

сэн байна. Ингээд умайн хүзүүний дагуу дээрээс нь доош умайд огтлол хийнэ. Энэ үед давсаг бслон бусад эрхтэнг гэмтээж болох аюултай тул мэс гжилбарыг бэлгосмжтой хийх хэрэгтэй.

Кетгутаар туслах сёдлуудыг тавина. Энэ нь бариул болгон ашиглахад тохиромжтой байдаг. Ийм уяа оёдлыг умайд хийсэн огтлолын дээд, доод хэсгүүдэд тавин. Үүнээсээ татаж умайг хэвлийн урьд хана руу ойртуулах ашигтай. Дараа нь умайд гарсаа оруулж ургийн хөлөөс барина. Утрээгээс толио авч, хүүхдийг доошилуулан толгой хүртэл татаад дахин толио утрээнд тавьж хүүхдийг эвдэх ажилбарыг гүйцэтгэнэ. Толгойг цоолдог багажаар цоолоод тархийг гаргаж сайтар цэвэрлэнэ. Тэгэхэд шархны нүхээр толгой амархан сугарч гарна. Дараа нь умайг аглаах эм хийнэ. Ихэс гарахгүй бол багажаар авах ёстой. Ингээд умайн хөнгийг хусуураар сайтар хусаж шалгана. Шархыг дээд талын захаас эхлэн кетгутаар тусгай занги оёдлоор оёно. Харин нум хэлбэртэй огтолсон гялтангийн хэсгийг голоос нь эхэлж оёх нь тохиромжтой байдаг.

УТРЭЭГЭЭР ХИЙХ КЕСАР ОГТЛОЛЫН ҮЕД ГАРАХ ХҮНДРЭЛ

1. Урьд нь үрэвсэлт өвчинөөр өвдөж их хэмжээний сорвижилт умайн хүзүү, параметрид үлдсэн нөхцөлд хүндрэл гарч давсаг болон бусад эрхтэнг гэмтээж болно.

2. Ураг гарч ирэхгүй. тасарч урагдаад байж болно. Тэгвэл шархыг оёж мэс заслыг хэвлийн хөндийгөөр хийнэ.

3. Умайн агшилт мудсанаас болж цус алдвал эхлээд эмийн эмчилгээ дараа нь мэс засал хийнэ.

3. НОРСМАА

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БЭЛИГ ЭРХТЭНИЙ ХОРТ ХАВДАР ӨВЧНИЙ ЭМЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ЗАРЧИМ

ХАВДАР СУДЛАЛЫН ТӨВ

Эмэгтэйчүүдэд тохиолддог төрөл бурийн хорт хавдрын дотроос бэлиг эрхтэний хорт хавдраар өвчлөх нь олонтоо байдаг бөгөөд энэ өвчний оношлох, эрт илрүүлэх, эмчлэх асуудал улам боловсронгуй болсоор байна.

Эмэгтэйчүүдийн бэлиг эрхтэний хорт хавдар өвчнийг шинжилгээний төрөл бурийн өргаар оношийг бүрэн илрүүлж эмчилгээний хавсарсан буюу хосолсон аргуудаар эмчлэн амжилтанд хүрч байна.

Хавдар судлалын практикт мэс засал, туяа, эмийн эмчилгээг өргөн хэрэглэж хорт хавдар өвчнийг амжилттай эмчилдэг ажээ.

Эмэгтэйчүүдийн бэлиг эрхтэний хорт хавдар өвчнийг эмчилгээд мэс заслын эмчилгээ чухал боловч ихэнхдээ биеэ даасан төгс эмчилгээ болж чаддаггүй.

Харин туяа ба эмийн эмчилгээтэй хавсан хэрэглэснээр эмчилгээний үр дүн сайжирдаг.

Хорт хавдар өвчний эмчилгээний аргыг сонгохдоо уг хавдрын шинж чанар, байршилт, тархалт, эсийн гарал, биологийн онцлог шинжүүдийг харгалзан үзэхээс гадна уг хавдар чухам ямар эмчилгээнд (эмийн ба туяаны) илүү мэдрэмтгий байх онцлог шинжүүдийг мэдэх нь чухал юм. Жишээлбэл: Өндгөвчийн зарим хавдар туяа эмчилгээнд илүү мэдрэмтгий байхад умайн хорионэпителiom өвчин эмийн эмчилгээгээр бүрэн эдгэрэх боломжтой.

Хавсарсан эмчилгээ гэдэг нь мэс заслын эмчилгээг эмийн юмуу туяа эмчилгээний аль нэгтэй нь нэг өвчтөнд хавсан хэрэглэхийг хэлнэ. Жишээлбэл: Өндгөвчийн хавдрыг мэс заслаар аваад дараа нь туяа юмуу химиин эмчилгээний аль нэгийг хэрэглэж болох юм.

Эмийн ба туяа эмчилгээг мэс заслын эмчилгээний өмнө хэрэглэж болно. Эмэгтэйчүүдийн өвчний практикт эмчилгээний хосолсон аргыг өргөн хэрэглэдэг бөгөөд энэ нь хавдарт ижил үйлчилгээ үзүүлэх эмийн бодис буюу туяа эмчилгээний хоёр ба түүнээс дээш аргуудыг хослон хэрэглэхийг хэлнэ. Жишээлбэл: Туяа эмчилгээний хоёр өөр аргыг ч юмуу хавдрын эсрэг хэд хэдэн эмийг хослон хэрэглэж болно.

Эмчилгээний эдгэрэх аргыг сонгохдоо эмчилгээ хийх заалт, хэрэглэх нөхцөл, эмчилгээний эцсийн үр дүн, үүсэх гаж нөлөөллийг нарийн тогтоосны үндсэн дээр шийдвэрлэнэ.

Эмэгтэйчүүдийн өвчний практикт умайн хүзүү, умайн их бие, гадна бэлиг эрхтэний зарим хорт хавдрыг мэс засал ба туяа эмчилгээгээр харин өндгөвчийн хавдрыг мэс засал ба эмээр тус тус хавсан эмчилнэ.

Өндгөвчийн хорт хавдрын үед тuya эмчилгээ төдийлөн сайн нөлөө үзүүлэхгүй. Харин хавдрын эсрэг эмийг мэс засал эмчилгээтэй хавсан хэрэглэхэд илүү сайн үр дүн үзүүлдэг бөгөөд төгс эмчилгээ ч болж чаддаг байна.

Хавдар судлалын практикт эмчилгээний үр дүнг эмчилгээ хийснээс хойш уг өвчин дахихгүй байх буюу өөр бусад эрхтэнд үсэргийлэл өгөхгүй байж амьдрах хугацааг тав таван жилээр тодорхойлон тогтооно.

Хорт хавдар өвчинеөр өвчлөгсдийн эмчилгээний үр дүн ба эмчилгээнээс хойш амьдрах хугацаа нь уг хавдрын бүтэц түүний тархалт, хэлбэр, хэмжээ, өвчтөний биений эсэргүүцэл, эмчилгээний үр чадвар, тuya эмчилгээний тун хэмжээ, арга барилаас шалтгаална.

МЭС ЗАСЛЫН ЭМЧИЛГЭЭ. Эмэгтэйчүүдийн бэлиг эрхтэний ихэнх хорт хавдрыг мэс заслын аргаар эмчилдэг бөгөөд ялангуяа эдгээр хорт хавдрыг өвчний эхний үе шатанд нь мэс заслын эмчилгээ хийвэл эмчилгээний үр дүн төдийчинээ сайн байж төгс эмчилгээ болж чаддаг.

Хавдрын процесс уг эрхтэнийхээ хүрээнээс гараагүй, орчныхоо эрхтэнд нөлөөлөөгүй, алсын эрхтэнд үсэргийлэл өгөөгүй тохиолдолд төгс мэс засал хийнэ.

Мэс заслын эмчилгээг хийхдээ уг эмчилгээг хийх заалгуудын үндэслэлийг зохих шинжилгээний үндсэн дээр бүрэн тодорхойлон дүн шинжилгээ хийж байж эцсийн шийдвэрийг гаргах ба хэрэв мэс засал хийх боломжгүй байвал эмчилгээний бусад аргыг зөв сонгон авах нь чухал юм.

Иймээс хорт хавдар өвчнийг мэс заслаар эмчлэх нь маш нарийн төвөгтэй асуудал бөгөөд бүх талын шинжилгээг бүрэн хийж оношиг нарийн тогтоож мэс засал хийх шаардлагуудыг нягт тодорхойлсон байх шаардлагатай.

Өвчтөн зүрх судас, амьсгалын замын ба шээс ялгаруулах зэрэг амьдралын чухал эрхтэний хүнд хэлбэрийн эмгэг өөрчлөлттэй байх юмуу эсвэл хэт өндөр настай байвал мэс засал хийх боломжгүй.

Хорт хавдар өвчний үед мэс засал хийхдээ хавдрын эсийг эрүүл эдэд тархаахгүй байх зарчмыг баримтлын эмгэг өөрчлөлттэй хэсгийг аваадаа эрүүл эдийг заавал оролцуулан авна. Орчны тунгалгийн булчирхайнуудад үүссэн эсэхийг харгалахгүйгээр бүрэн авах шаардлагатай юм.

ТУЯА ЭМЧИЛГЭЭ. Эмэгтэйчүүдийн бэлиг эрхтэний хорт хавдрын үед тuya эмчилгээг өргөн дэлгэр хэрэглэж байна. Тэгэхдээ тuya эмчилгээг дангаар нь буюу бусад төрлийн (мэс засал ба эмийн) эмчилгээтэй хавсруулан хэрэглэнэ.

Сүүлийн үед тuya эмчилгээнд аппарат хэрэгслэл боловсронгуй болж өндөр хүчтэй гамма-төхөөрөмжүүд цацраг идэвхт изотопыг эмчилгээнд хэрэглэн радиобиологи, физик дозиметрийн асуудлуудыг шийдвэрлэж, эмчилгээний арга барил боловсронгуй болсноор эмчилгээний үр дүн нь улам сайжирсаар байна.

Олон улсын эрдэмтдийн судалгаанаас узвэл хорт хавдар өвчний улмагс эмчлүүлж байгаа нийт хүмүүсийн 60—80 орчим хувь нь тuya эмчилгээг аль нэгэн барилаар хийж байна.

Тuya эмчилгээний гол зарчим нь хавдрын голомтыг бүрэн устгаж эрүүл эдийг хамгаалахад оршино. Цацраг идэвхт тuyaаны биологи үйлчлэл нь хавдрын эсийг шууд устгадаг ба түүнийг эмчилгээний тун гэж нэрлэнэ.

Туяа эмчилгээний үр дүн нь хавдрын туюанд мэдрэмтгий бэйх чанар, эсийн гарал, хавдрын хэлбэр, хэмжээ, тархалт, өвчтөний насын онцлог байдал бусад ямар нэгэн хоёрдогч өвчтэй байх эсэхээс шууд шалтгаална.

Туршлагаас үзэхэд хурдан ургацтай гадагшаа ургасан (эксофид хэлбэрийн хавдар туюаны үйлчлэлд мэдрэмтгий байхад, удаан явцтай том хэмжээний дотогшоо ургасан (энзофид хэлбэрийн) хавдар туюанд мэдрэмтгий бус байдаг. Туяа эмчилгээний үр дүн дээрх шалтгаануудаас хамаарахаас гадна хавдрын голомтод өгч байгаа туюаны тун хэмжээ, арга барилаас ихээхэн шалтгаална.

Умайн хүзүү ба эмэгтэйчүүдийн гадна бэлиг эрхтэний зарим хэлбэрийн хорт хавдар өвчний өвчний үе шатанд байхад нь тuyaа эмчилгээ хийхэд төгс эмчилгээ болж чаддаг.

Туяа эмчилгээгээ ихэвчлэн мэс заслын эмчилгээтэй хавсрان мэс заслын өмнө ба дараа нь хийнэ.

ЭМИЙН ЭМЧИЛГЭЭ. Эмэгтэйчүүдийн өвчний практикт эмийн эмчилгээ чухал байр эзэлдэг бөгөөд мэс засал ба бусад эмчилгээтэй хавсрان хэрэглэнэ. Хавдрын эсрэг эмүүд нь эсийн хуваагдах процессыг дарангуйлах (цитостатик), хавдрын эсийг устгах нөлөө үзүүлдэг (цитотоксик) байна. Хавдрын эсрэг эмүүдийг тодорхой зааврын дагуу хавдар тус бурийн онцлогийг харгалзан хэрэглэнэ.

Иймээс хавдрын морфологийн бүтцийг харгалзан ямар эмэнд мэдрэмтгий байх чанарыг баримтлан эмчилнэ.

Орчин үед олон хавдрыг эмээр бүрэн эмчилж чаддаг болжээ. Жишээлбэл: Өндгөвчийн зарим хавдар ба хорионэпителiom өвчнийг эмээр эмчлэн бүрэн эдгээж байна.

Химиин эмүүд нь ихэвчлэн цус төлжүүлэх эрхтэнд нөлөөлж цус багадаг ба ялангуяа миело ба тромбоцитопоэз буурдаг. Иймээс хорт хавдар өвчний эмчилгээг мэргэжлийн эмчийн хяналтанд эмчилгээний зохих дэг журмыг баримтлан хийх шаардлагатай.

Г. ГЭНДЭНЖАМЦ

ХОДООДНЫ АРХАГ ҮРЭВСЛИЙН ЭМЧИЛГЭЭНИЙ

ЗАРИМ ХЭЛБЭР

УЛСЫН НЭГДСЭН ТУСГАЙ ЭМНЭЛЭГ

Ходоодны архаг улаймал үрэвсэл (архаг гастрит) өвчин нь хоол боловсруулах эрхтэний өвчнүүдээс хамгийн их тархсан нь юм. Энэ өвчин хоол боловсруулах эрхгэний өвчнүүдийн 35 хувийг, ходоодны өвчнүүдийн дотор 80—85 хувийг нь эзэлдэг байна. Ходоодны архаг үрэвсэл нь ходоодны бусад хүнд өвчин үүсэх урьдал өвчин болдог. Хүн амын дунд түгээмэл байдаг энэ өвчинөөс урьдчилан сэргийлэх, эмчилгээг зөв зохион байгуулах асуудал чухал юм. Ходоодны архаг үрэвслийг урьдчилан сэргийлэхэд хоол ундны дэглэмиг нарийн баримтлахаас гадна хоолны хордлого, ходоодны хурц үрэвслийг тухайн үед нь тууштай гүйцэд эмчлэх явдал мөн. Хоол ундны эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хатуу сахиж, 4—5 цагийн зйтай витамин, ургийн зүйлээр баялаг, ходоодонд хэт ачаалал, цочрол үзүүлэхгүй хоол унд хэрэглэнэ. Сонгино, сармис зэрэг халуун ногооны төрлийг хэт ихээр буюу дангаар нь хэрэглэх хэрэггүй. Эмийн бодисуудыг түйлийн болгоомжтой хэрэглэнэ. Архи тамхи нь ходоодны архаг үрэвсэл үүсгэх шалтгаан болдог тул хэрэглэхийг цээрлэнэ.

Шүд амны хөндийн өвчнүүдээс байнга сэргийлж байх нь уг өвчинөөс сэргийлэхэд их дөхөм болно. Ажил амралтын дэглэмиг сахиж, мэдрэл, сэтгэл санааны хувьд байнга тайван байх нь чухал.

Элэг, цөс, гэдэсний өвчнүүд ба архаг олгой зэрэг бусад өвчиний үед хавсрсан тохиолдох нь элбэг тул тэр эрхтэнүүдийн өвчинийг тухайн бүр сайн эмчлүүлж байх ёстой. Ходоодны архаг үрэвслийг эрт илрүүлж, эмчийн хяналтанд байж эмчилгээ хийлгэх нь зүйтэй. Онош найдвартай тогтоо аргуудын дотроос ходоод дурандах, эс эдийн шинжилгээ авах. РН метрийн арга, ходоодны шүүсний дээд хэмжээ, доод хэмжээ зэргийг хэсэгчлэн авч тогтоох зэрэг нь их ач холбогдолтой юм. Ходоодны архаг үрэвслийн үед хоолоор эмчлэх нь хамгийн чухал. Хоол нь найрлагаараа ч механик байдлаараа ч ходоодны салст бүрхүүлийг цочрохгүй, амархан шингэхээр байх ёстой. Өдөрт 5—6 удаа бага багаар хооллоно. Мэдрэлийн системийн хэвийн ажиллагааг хангах зорилгоор валерины ханд, тайвшруулах, нойрсуулах эмүүдийг хэрэглэнэ. Мөн өвдөлт намдаах, агшилт сулруулах зорилгоор атропиныг 0,1% 5—8 дуслаар өгөх буюу 0,5—1 мл-ээр тарина. Метациныг 0,1% мл, платифилин 0,002—0,005 г буюу 1—2 мл, экстракт белладон 0,015 г тус тус хэрэг лэж болно. Эдгээр эмийг хоол идэхээс 15—30 минутын өмнө өдөрт 2—3 удаа 2—3 долоо хоног хэрэглэнэ. Ходоодны шүүс багасгах зорилгоор шүлтальмагель, альмагель А, буржийн холимог зэргийг хэрэглэнэ. Мөн трисиликат магнийг 1—2 цайны халбагаар магний ислийг 0,5—1,0 г-аар нүурсхүчлийн кальцийг 0,5—1,0 г-аар, викалин буюу викайрыг 1—2 шахмалаар хоолны дараа 1,5—2 цагийн дараа ууна. 2%-ийн содын уусмалаар буюу шүлтлэг рашаан усаар ходоод угааж болно. Мөн Боржом, Нарзан №7, Ессентуки № 20 зэргийг ууж болно. Өлөн уеэр юм уу унтахаас өмнө анестезин 0,3-аар новокайны 0,25—0,5 хувийн

усмалыг ууж болно. Ходоодны шүүс бага хэлбэрийн үрэвслийн үед дээрх эмчилгээ хийхгүй, өвчин намдаах агшилт, (сулруулах эм) жишпа 0,08 г, галидор 0,1—0,2 г, церукал 10 мг) хэрэглэнэ. Үрэвслийн эсрэг, эд эсийн ажиллагааг сайжруулах зорилгоор таван салааг хоолны халбагаар өдөрт 3 удаа, плантаглюцид гранул 0,5—1,0 г, метилурацил 0,5 г-аар өдөрт 1—3 удаа хоол идэхээс өмнө ууж, 2—4 долоо хоног хэрэглэнэ. Ходоодны шүүс бага үед лимонтой цай, алим, жимсний шүүс, ли-моны хүчил зэргийг хэрэглэх, давсны хүчил-пепсин, ходоодны цэвэр хүчил зэргийг хоолноос өмнө юм уу, хоолны үед ууна. Эсвэл ацидин-пепсин, ацидол, бетацид зэрэг эмийн аль нэгийг (0,25—0,5 г) хагас стакан усанд уусгаж өдөрт 3—4 удаа хоолны дараа юм уу, хоолны үеэр ууна. Сүүлийн үед ходоодны хүчлийг орлох ферментийн шинэ бэлдмэлүүд- пепсидил, сальпепсин зэргийг хэрэглэж байна. Эдгээр эмийг удаан (3 сарын) хугацаагаар курс байдлаар хэрэглэх ба хоол идэх үед ууна. Ходоодны шүүс ялгаруулах ажиллагаа өөрчлөгдсөн нөхцөлд түүнийг орлон нөхөх зорилгоор удаан хугацаагаар, өдөрт 3—4 удаа хоолны үед юм уу хоолны дараа панкреатин 1—2 г, абомин 0,2 г-аар өгнө. Абоминиг хоолны үед, панкреатиниг хоолны өмнө ууна. Мөн полизим, панцином зэргийг хэрэглэнэ. Нуурсхучлийн хий, хухэр, устөрөгч агуулсан рашаан ус (Ессентуки №17, Буровая №23 Жанчивлан) хэрэглэнэ. Эдгээрийг 30 градусын орчим бүлээнээр хоолноос 15—30 минутын өмнө аажим ууж хэрэглэнэ. Ходоодны архаг үрэвслийн үед витамин дутагдаг тул витамины комплексийг 3—4 долоо хоногоос доошгүй хэрэглэнэ. Витамин В-ийн групп (B_1 —5%—2,0 өдөр бүр; B_6 —5%—1,0 өнжөөд, B_{12} —2000 гамма булчинд ээлжилж) витамин С—0,3 өдөрт 3 удаа хоолны өмнө РР—0,02 г, өдөрт 3 удаа хоолны дараа мөн тосонд уусдаг витамин А-г 4—6 дуслаар өдөрт 3 удаа хоолны өмнө ууна. Фолийн хүчил 0,005-г-аар ууна. Ходоодны шүүс ихэдсэн буюу хэвийн үеийн ходоодны үрэвслийн үед витамин дутагдах нь бага байдаг. Хэрэв ходоод, гэдэсний шимэгдэх ажиллагаа бөөрчлөгдөөгүй бол олон витамины бэлдмэл (декамвит, тенлевит, аэровит, суммавит) өгч болно. Ходоодны шүүс дутагдалтай архаг үрэвслийн үед ходоодны үйл ажиллагааны хамгаалах чадвар буурсан байдаг тул цэс, нойр булчирхай, гэдэсний замын ба амны хөндийн өвчин үүсгэгч халдвараар өвчилдөг учир бактер няангийн эсрэг эмчилгээг хамт явуулах хэрэгтэй. Хоёрдогч гэдэсний халдварын үед буюу гэдэсний үрэвслээс үүсэлтэй бол колибактерин, бификол, бифидум бактерин, энтеросептол, интестопан, фталазол, сульгин зэргийг ерийн тунгаар ууна. Энэ эмүүд нь гэдэсний хэвийн нянд нөлөөлөхгүй. Трихопол болон бусад эмийг тухайн үед тохицуулан курсээр хэрэглэнэ. Ходоодны хүчил дутагдалтай ходоодны архаг үрэвслийн үед хоол идэх дур буурах, жин багасах байдал илэрдэг тул анаболитик гормон-нөрөбөл 5 мг өдөрт 2—3 удаа уух буюу нероболил 25—50 мг-аар 7—10 хоногт 1 удаа булчинд тарина.

Ретаболилыг (50 мг-аар 2—3 долоо хоногт 1 удаа булчинд тарих байдлаар) хэрэглэнэ. Мөн оротат калийг (0,25—0,5 г өдөрт 2—3 удаа хоол идэхээс өмнө өгнө. 3—4 долоо хоног түүнээс ч илүү хугацаагаар хэрэглэнэ. Гормон эмүүдийг элэг өвчтэй үед хэрэглэхгүй. Ходоодны шүүс гаргах ажиллагааг сайжруулах зорилгоор кокарбоксилаца, инсулин зэргийг захын цусны эргэлтийг сайжруулах компламин ба бусад, гипосталамус, гипофиз, бөөрний дээд булчирхайг зохицуул ах (атилизол зэрэг) эм хэрэглэнэ. Ходоодны архаг үрэвслийн үед физик-эмчилгээ, шилмууст вани, биений тамир, эдектрофорез чухал юм. Бүлээн жин, озокерит, парафин, шавар зэргийг хэрэглэнэ. Ходоод орчим диятерми, индуктотермин, эмтэй электрофорез тавих, сувиллын хоолны ба рашаан ус эмчилгээ зэрэг нь сайн үр дүнтэй.

ГАДААД ОРНУУДАД

ЗӨВЛӨЛТИЙН ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ: НАЯАД ОНЫ ЗОРИЛТ

ЗХУ-ын их эмч нарын тоо 1982 онд 33 мянгаар нэмэгдэж 1 сая 66 мянгад хүрлээ. Эмнэлгийн орны тоо 65 мянгаар нэмэгдэж нэг ээлжинд нийтдээ 134 мянган хүн хүлээн авах хүчин чадалтай амбулатори поликлиникүүд шинээр байгуулагдав. Энэ тоо баримтыг өнгөрсөн оны улсын нийгэм эдийн засгийн хөгжилтийг дүгнэн ЗСБНХУ-ын Статистикийн төв захиргаанаас гаргасан мэдээллээс авсан юм.

ЗСБНХУ нь эрүүлийг хамгаалах талаар хамгийн хөгжсөн орны нэг юм. Хэдийгээр ЗХУ-д дэлхийн нийт хүн амын арван зургааны нэг нь амьдардаг ч тус оронд европын эмч нарын хагас хувь нь дэлхийн нийт эмчийн гуравны нэг нь ажиллаж байна.

Ийнхүү эрүүлийг хамгаалах талаар их амжилтанд хүрсэн ч эмнэлэг урьдчилан сэргийлэх байгууллагыг барьж байгуулах, эмнэлгийн боловсон хүчнийг бэлтгэх ажлын хурд, далайц буурахгүй байгаагийн учир юунд байна вэ?

ЗСБНХУ-ын эрүүлийг хамгаалах яамны орлогч сайд Алексей Сафонов Статистикийн төв захиргааны мэдээг тайлбарлан,

— Бид тухайлбал, эмнэлгийн боловсон хүчний талаар орчин үед намиас дэвшүүлж байгаа зорилтын түвшинд хүрч чадаагүй байна. Зөвлөлтийн 270 гаруй сая хүн амын эрүүл мэндийг хамгаалах үндсэн хуулийн эрхийг хангахад (орчин үеийн анагаах ухааны дээд түвшингийн хэмжээнд эмнэлгийн тусlamж үзүүлэх талаар би ярьж байна) бидний тооцоолж байгаагаар 10 мянган хүн ам тутамд 40—41 эмч (одоо энэ үзүүлэлт 38,5 байгаа юм) шаардлагатай байна. Бид үүнийг тооцоходоо олсн хүчин зүйлийг харгалзан үзсэн юм. Жишээлбэл анагаак ухааны үсрэнгүй хөгжлийн дагуу эмнэлгийн тусlamжийн хэмжээ өсөх хүчин зүйл гэх мэт.

Хорь гuchaадхан жилийн өмрөө ховор, хүнд гэгдэж байсан зүрхний мэс заслыг хийхэд зүрхний мэс заслын төв байгуулах шаардлага байсангүй. Гэтэл өнөөдөр бид сахан хүртэл эмчлэгдэхгүй гэгдэж байсан хүнд өвчтөнүүдэд эмнэлгийн тусlamж үзүүлж байгаа нарийн мэргэжлийн тусlamжийн (зөрхөн зүрхний мэс заслынхаар хязгаарлагдахгүй гэдэг нь мэдээж) олсн төвийг ажиллуулж байна.

Өвчтөн зөвхөн ердийн эмчийн төдийгүй нарийн мэргэжлийн тусlamж үзүүлэхэд (энэ бсл суулийн жилүүдэд бидний эрчимтэй шийдвэрлэж буй гсуудлын нэг, юм) боловсон хүчнийг эрс нэмэгдүүлэх шаардлагатай байгаа юм. Одоо хот, хөдөөний томоохон төвүүдэд төрөл бүрийн тусlamж үзүүлж байгаа томоохон эмнэлэг олон ажиллаж, жил ирэх тутам нарийн мэргэжлийн тусlamжийн төв, диспансер, зөвлөлгөө өгөх газрын тоо есч, хүчин чадал нь нэмэгдэж байна. Мөн эмч нар ажиллахад бэрхшээлтэй тохиолдолд өвчтөнөө илгээдэг зөвлөх поликлиникүүдийг эрдэм шинжилгээний хүрээлэн, анагаах ухааны дээд сургууль болон нарийн мэргэжлийн туршилагатай өндөр боловсролтой боловсон хүчин төвлөрсөн томоохон эмнэлгүүд түшиглэн байгуулж байна. Үүний зэрэгцээ бид эмнэлгийн тусlamжийн өнхөн шатны гэж нэрлэгддэг хөдөө орон нутагт ажиллаж байгаа их эмчийн сэлбар (эдгээрийн тоо 15 мянга орчим юм) райсны поликлиникүүдийг өвчтөн бүрт шаардагдах үзлэг, шинжилгээг бүрэн хийдэг болгохын тулд ихээхэн бэхжүүлж байна. Энэ нь тэдгээр биохими, эс, багажийн шинжилгээ хийх лабораторийн хүчин чадлыг өргөжүүлэх төрөл бүрийн оношилгоог нэвтрүүлэхийг шаардаж байна.

Энэ талаар чухал алхамуудыг хийгээд байна. Төрөл бүрийн шинжилгээ хийх лаборатори, эндоскопийн зэрэг нарийн оношилгоо тавих кабинетыг олон зуун поликлиникт ажиллуулж эхэллээ. Эдгээр шинжилгээ оношилгоо урьд нь зөвхөн стационарт хийгдэж байсан юм. Түүний зэрэгцээ саяхан болтол зөвхөн эмнэлэгт хэрэглэж байсан эмчилгээний аргуудыг амбулаторийн эмч нар амжилттай эзэмшиж, нүдний даралт ихсэх, чихрийн шижин, үе мөч, тулах-хөдлөх эрхтэний гэмтэл зэрэг өвчтэй хүмүүсийн ихэнхийг эмнэлэгт хэвтүүлэлгүй эмчилж байна.

Ойрын ирээдүйд амбулаторийн нөхцөлд бөөрний архаг өвчтэй хүмүүсийн бөөрийг цэвэрлэж угаах, атмосферийн их даралттай барока метрт эмчлэх, лазерийн туюаны тусламжтайгаар мэс засал хийх болно.

Амбулатори-поликлиникийн эмчилгээний боломж хүрээ ийнхүү эсэн нэмэгдэж байгаа нь тэдгээрийг боловсон хүчин орчин үеийн техникийн хангаж бэхжүүлэхийг зүй ёссор шаардаж байна. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд сүүлийн жилүүдэд анагаах ухааны дээд сургууль төгсөгчдийн 60 хүртэлх хувийг амбулатори, поликлиникт илгээж байна. Орчин үеийн анагаах ухааны багаж техникийг үйлдвэрлэх хэмжээг 1981-1985 онд 1,4 дахин нэмэгдүүлэхээр төлөвлөөд амжилттай хэрэгжүүлж байна.

Амбулатори-поликлиникийн эмч нар аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг гардан хариуцаж, хүн амын эрүүл мэндийн байдлыг хянаж, ажиглглт урьдчилан сэргийлэх үзлэг хийдэг болохоор Зөвлөлийн эрүүлийг хамгаалахын энэ чиглэлд бид ийнхүү гоц анхаарч байна.

Иргэн бүрийг эмч нарын хараанд байлгахын тулд ЗСБНХУ-д хэсгийн эмнэлгийн үйлчилгээний зарчмыг аль эртиээс нэвтрүүлсэн юм, Үүнд, нийт газар нутгийг ижил тоотой хүн ам ногдохоор хэсгүүдэд хувааж хэсэг тус бүрт дотор, хүүхдийн эмч ажиллуулж байна. Арав, тэр байтугай таван жилийн ёмнө дотрын хэсгийн нэг эмчид хоёр мянга таван зуу, заримдаа түрвэн мянга шхам хүн, хүүхдийн хэсгийн эмчид мянга таван зуу хүртэл хүүхэд ногдож байлаа. Боловсон хүчиний хамгамж сайжрах тусам нэг эмчид ногдох хүний тоо цөөрч, эмчээс нэг өвчтөнд үзүүлэх өнхараглал хамжийг нэмэгдүүлэх боломж олгож байна.

Одоо дотрын хэсгийн нэг эмч дунджаар хоёр мянга орчим хүн (1985 онд гэхэд 1,7 мянгаас ихгүй болно), хүүхдийн хэсгийн нэг эмч 800 орчим хүүхдэд үйлчилж байна. Энд өвчтөний тухай бус, нэг эмчид ногдож буй хэсгийн бүх хүн амын тооны талаар ярьж буйг тайлбарлах нь зүйтэй биз ээ.

Үүний зэрэгцээ бид хэсгийн эмч нарын хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулж, хөнгөвчлөхийг хичээж байна. Одоохондоо тэд амбулатори-поликлиникт өвчтөнийг хүлээн авч үзэх, өвчтөнд гэрт нь үйлчлэх, архаг өвчтэй хүмүүсийг диспансерийн хяналтанд авах, тодорхой хугацаанд үзлэг, шинжилгээнд хамруулах, өвчиний дахилтийн эсрэг болон эрүүлжүүлэх эмчилгээ хийх зэрэг слон үүргийг гүйцэтгэж байна. Түүнчлэн хэсгийн нийт хүн амыг жилд нэг удаа флюорографийн шинжилгээ, зүрхний бичлэг 30-аас дээш насны эмэгтэйчүүдийг кабинетийн үзлэгт хамруулах үүрэг тэдэнд ногдож байна.

Урьдчилсан сэргийлэх үзлэг шинжилгээнд хяналт тавих, диспансерийн хяналтанд орох шаардлагатай өвчтөнийг тодорхойлох, нийт тоог гаргах зэрэг ажлыг эрхлэх урьдчилсан сэргийлэх тусгай тасгийг ойрын жилүүдэд бүх поликлиникт байгуулж болно. Ийм тасгуудыг байгуулахад мөн л өслөөсон хүчин их хэмжээгээр шаардагдана. Үүнд эмнэлгийн дүнд боловсролтой ажилтнууд үндсэндээ хэрэгтэй юм. Урьдчилсан сэргийлэх тасгийн срон тоонд лаборант (чихрийн шижинтэй хүмүүсийг илрүүлэхийн тулд сахарын хэмжээг тодорхойлох гэх мэт төрөл бүрийн шинжилгээ хийх), үзлэгийн кабинетийн ажилтнууд, эмчийн үзлэгийн өмнөх кабинетийн сувилагч нар (ийм кабинетад тухайлбал цусны, шаардлагатай бол нүдний даралт хэмжинэ)-ын зэрэг ажилтан оруула-

хаар тооцжээ. Эмчийн үзлэгийн өмнэх кабинет нь эмчид үзүүлэх өвчтөний талаар үндсэн мэдээлэл өгөх зорилготой юм.

Эрүүлийг хамгаалах албаны эмнэлгийн дунд мэрэгжилтийн хангамжийг сайжруулж, хэрэгцээг хангахын тулд (манай оронд тэдгээрийн тоо 2,5 саяас илүү болоод байгаа юм) анагаах ухааны дунд сургуульд элсэгчдийн тоог энэ онд 17 мянга, ирэх жил 20 гаруй мянгаар нэмэгдүүлэх болно гэж ярьсан юм.

(АПН) Хүрэлбаатар орчуулав.

O

1 Абу-Ибн Библиту	17	1) мэс засал	16) ишил, и операцийн тэсирхийн организатор учебистогийн
2 Абу-Ибн Бинжами	18	18)	17) ишил, операцийн организатор учебистогийн
3 ашавалин	19	19)	18) ишил, операцийн организатор учебистогийн
4 эмсэгчийн зөвлөхтэй	20	20)	19) ишил, операцийн организатор учебистогийн
5 энгэг, түрэ, садна	21)	21) шар, бэлэгтэй	20) ишил, операцийн организатор учебистогийн
6 шүүх чигилтэй	22)	22) эмсэгчийн?	21) ишил, операцийн организатор учебистогийн
7 багуу; эмсэгчийн	23)	23) танхимчолотуу ГН	22) ишил, операцийн организатор учебистогийн
8 пульмонологи	24)	24) вирусологийн	23) ишил, операцийн организатор учебистогийн
9 кардиологи	25)	25) эндохадакийн НМ	24) ишил, операцийн организатор учебистогийн
10 иодорхисиатр	26)	26) офтальмологийн НС	25) ишил, операцийн организатор учебистогийн
11 пульмонологи	27)	27) остео-артритологийн (1)	26) ишил, операцийн организатор учебистогийн
12 гнатологи	28)	28) идерлогийн	27) ишил, операцийн организатор учебистогийн
13 кардиологи	29)	29) психиатрийн ШД	28) ишил, операцийн организатор учебистогийн
14 иодорхисиатр	30)	30) акушерстъи	29) ишил, операцийн организатор учебистогийн

ЭМНЭЛГИЙН ХЭВЛЭЛИЙН НЭГДСЭН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

- 1 Ж. Раднхабазар (Эрхлэгч, доцент) ✓
- 2 Л. Буджав (Анагаах ухааны дэд эрдэмтэн) ✓
- 3 Б. Гоош (Анагаах ухааны дэд эрдэмтэн) ✓ + Зөвлөх, ишил, операцийн
организатор
учебистогийн
- 4 Ж. Дашибавх (Анагаах ухааны дэд эрдэмтэн) ✓
- 5 Б. Дэмбэрэл (Анагаах ухааны дэд эрдэмтэн) ✓
- 6 Г. Дашизвэг (Анагаах ухааны дэд эрдэмтэн) ✓
- 7 Ч. Долгор (Анагаах ухааны дэд эрдэмтэн, профессор) ✓
- 8 Ж. Купул (Анагаах ухааны дэд эрдэмтэн) ✓
- 9 Э. Лувсандалгва (Анагаах ухааны дэд эрдэмтэн) ✓
- 10 А. Ламжав (Эм зүйн ухааны дэд эрдэмтэн) ✓
- 11 Л. Хүрэлбаатар (Хариуцлагатай нарийн бичгийн дарга) ✓
- 12 П. Нямдаваа (Анагаах ухааны дэд эрдэмтэн) ✓
- 13 Б. Рагчах (Анагаах ухааны доктор, профессор) ✓
- 14 Г. Цагаанхүү (Анагаах ухааны дэд эрдэмтэн) ✓
- 15 Б. Шижирбаатар (Анагаах ухааны дэд эрдэмтэн) ✓
- 16 Н. Шура.

Техник редактор Б. Болат, Хянач Д. Наранчимэг.

Өрөлтөнд 1983 оны 6-р сарын 28-нд орж, 3047 ш хэвлэв. Цаасны хэмжээ 70x108 1/16. Хэвлэлийн хуудас 5,0 х.н.х. 5,6. А—89662 Зах № С—110
Д. Сүхбаатарын нэрэмжит Улсын Хэвлэлийн Комбинатад хэвлэв. Д. Сүхбаатарын талбай—6

ГЛАУВЕНТ

(БНБАУ-д үйлдвэрлэсэн)

Нэг шахмалд 40 мг глауцин тилрохорид агуулагдана.

Глаувентийг амьсгалын замын ба уушгинь үрэвслийн өвчний үед хэрэглэнэ. Ханиалгыг намдаах үйлчилгээ үзүүлдэг бөгөөд кодейноос ялгагдах нь амьсгалын төвийг дарангуйлахгүй, гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөнийг saatuuлахгүй, дасах чанар байхгүй сайн талтай.

Зарим үед толгой эргэх, дотор муухай болох зэрэг гаж нөлөө үзүүлнэ. Глаувентыг өдөрт 1—2 шахмалаар 3 удаа хоолны дараа ууна. Хүүхдэд 2—4 хувааж өгнө.

ХОЛЕВИД

(БНСЮУ-д үйлдвэрлэсэн)

Найрлагадаа 3 атом иод агуулсан органик нэгдэл бөгөөд 66,7 хувийг иод эзэлнэ. Холецистограф, холангиографийн шинжилгээний үед ууж хэрэглэдэг тохируулагч бодис юм. Холевидыг хэрэглэх арга нь энгийн учир өвчтөнд хэрэглэхэд тохиромжтой. Гаж нөлөө үзүүлэх нь ховор бөгөөд голдуу иодод мэдрэмтгий зарим хүмүүст бөөлжих, огиулах, суулгах байдлаар илэрнэ.

Элэг, бөөрний эд эсийн хүнд гэмтэл, иодод мэдрэмтгий буюу базедын өвчтэй хүмүүст хэрэглэхийг хориглоно. Ходоод гэдэсний зарим хүнд өвчний үед холевидын шимэгдэлт алдагддаг учир хэрэглэж болохгүй.

Нэг удаагийн шинжилгээнд 6 ширхэг шахмалыг хэрэглэх ба шаардлагатай үед 12 ширхэг хүртэл тунг нэмэгдүүлнэ. Шинжилгээг өлөн элгэн дээр хийнэ. Холевидыг ууж хэрэглэснээс хойш шинжилгээ хийж дуустал хоол хүнсний зүйл идэх, уух, тамхи татахыг хориглоно.

Холевидыг зөвхөн эмчийн хяналтанд хэрэглэнэ.

ВЕРМОКС

(БНУАУ-д үйлдвэрлэсэн)

Нэг шахмалд 100 мг мебендазол агуулагдана.

Вермокс төрөл бүрийн цагаан хорхойтох өвчнийг эмчлэхэд хэрэглэнэ. Хэрэглэх тун хэмжээг тогтоохдоо насанд хүрэгчид болон хүүхдийн биеийн жин, насны онцлогийг харгалзана.

Самшуу хорхойтох өвчний үед 1 шахмалыг ууна. Халдварт ихэвчлэн давтагддаг учир эмчилгээг 2—4 долсо хоногийн дараа давтан хийнэ.

Цагаан хорхойтох өвчний үед өдөрт 1 шахмалаар 3 хоног ууна. Вермокс нь өвчтөнд сайн тохирдог бөгөөд одоогоор гаж нөлөө илрээгүй байна. Вермоксыг жирэмсний үед хэрэглэхийг хориглоно.

Улсын эм хангамж үйлдвэрлэлийн газрын
мэдээлэл технологийн тасаг